



УДИРДЛАГЫН
АКАДЕМИ

2021

**МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН
АЛБАНЫ ҮНЭТ ЗҮЙЛС
(ЭРХЭМЖ), УЛАМЖЛАЛ**

/XIII-XX зууны эхэн, Эзэн хаант засгийн үе/

Түүхэн эх сурвалжид хийсэн шинжилгээ



УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

030



УДИРДАГЫН
АКАДЕМИ

**МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН
АЛБАНЫ ҮНЭТ ЗҮЙЛС
(ЭРХЭМЖ), УЛАМЖЛАЛ**

*/XIII-XX зууны эхэн, Эзэн хаант засгийн үе/
Түүхэн эх сурвалжид хийсэн шинжилгээ*

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

030

Улаанбаатар хот
2021 он

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ҮНЭТ ЗҮЙЛС (ЭРХЭМЖ), УЛАМЖЛАЛ

/XIII-XX зууны эхэн, Эзэн хаант засгийн үе/

Түүхэн эх сурвалжид хийсэн шинжилгээ

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулийн дагуу хамгаалсан болно. Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн хувилах, нийтлэх, электрон системд оруулах болон бусад ямар нэг хэлбэрээр олшруулахыг хориглоно.

СУДАЛГААНЫ БАГ

Багийн ахлагч:

Я.Долгоржав Доктор (Ph.D), профессор

Багийн гишүүд:

С.Цэдэндамба Доктор (Ph.D), профессор

Т.Билэгсайхан Доктор (Ph.D)

Ц.Үүрийнтуяа Удирдлагын академийн докторант

Х.Балжмаа Удирдлагын академийн докторант

"Мөнхийн Үсэг" ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	IV
ӨМНӨХ ҮГ	V
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ	1
1.1. Тулгамдсан асуудал	1
1.2. Судалгааны асуулт	3
1.3. Судалгааны зорилго, зорилт	5
1.4. Судалгааны хамрах хүрээ	5
1.5. Судалгааны ач холбогдол	5
1.6. Нэр томъёоны тодорхойлолт	6
1.7. Судалгааны ажлын бүтэц	6
ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ	7
2.1. XIII-XVI зууны үеийн монгол төрийн албаны үнэт зүйлс, уламжлал	7
2.2. XVII-XX зууны эхэн үеийн монгол төрийн албаны үнэт зүйлс, уламжлал	9
2.3. Судалгааны үзэл баримтлалын хүрээ	11
ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	13
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ҮНЭТ ЗҮЙЛС, УЛАМЖЛАЛ (XIII-XX ЗУУНЫ ЭХЭН, ЭЗЭН ХААНТ ЗАСГИЙН ҮЕ)	18
4.1. Монгол Улсын төрийн албаны үнэт зүйлс	18
4.2. Төрийн албаны хүрээлэнд уламжлагдаж ирсэн зохион байгуулалтын бүтэц	32
4.3. Төрийн албан дахь эрх зүйн зохицуулалтын уламжлал	40
4.4. Төрийн албан дахь ажил үүргийн хуваарилалт	44
4.5. Төрийн албанд хүмүүсийг сургаж боловсруулж байсан уламжлал	47
4.6. Төрийн албан хэрэг хөтлөлтийн уламжлал	50
4.7. Төрийн албаны ёслол, хүндэтгэлийн хүрээний уламжлал	56
4.8. Төрийн албаны хүрээнд хариуцлага, урамшууллын тогтолцоонд баримталж байсан уламжлал	61
4.9. Төрийн алба, захиргааны зүгээс иргэдээ үүрэгжүүлж ирсэн уламжлал	72
ДҮГНЭЛТ	79
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	83



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МНТ	Монголын нууц товчоо
МУУТА	Монгол Улсын Үндэсний төв архив
ТБА	Түүхийн баримтын архив
ХА	Хөмрөг А
ХН	Хадгаламжийн нэгж
ТТА	Түүхийн төв архив
Ф.А	Фонд А

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харъяа Удирдлагын академи 2021 онд хэрэгжүүлэх эрдэм шинжилгээний ажлын хүрээндээ “Монгол Улсын төрийн албаны үнэт зүйлс, уламжлал (Түүхэн эх сурвалжид хийсэн шинжилгээ)” сэдвийг төсөл болгон судлахаар Эрдмийн зөвлөлөөрөө баталсан билээ. “Захиргаа нь төртэйгээ адилхан эртнийх” (В.Вильсон) учраас эртний түүхтэй Монгол Улс төрийн захиргаа, төрийн албаны эрхэмж буюу үнэт зүйлс, уламжлалаа нухацтай судлах нь зүйд нийцнэ.

Ийм сэдвээр судалгаа хийлгэх захиалгыг ч Монгол Улсын төрийн албаны зөвлөлөөс өгсөн аж. Энэхүү эрэлтэнд нийлүүлэлт хийх зорилгоор судалгааны баг бүрдэж судалгааны ажлын дизайн боловсруулж батлуулаад ажилдаа орсон. Эдүгээ судалгааны ажлын эхний үеийн тайланг хэвлэн нийтэлж олны хүртээл болгож буй нь энэ. Эхний үеийн гэж хэлж байгаагийн учир нь уг сэдэв өөрөө түүхэн урт хугацааг хамарсан өргөн агуулгатай учраас аливаа улсын захиргааны хөгжлийг гурван үед хувааж үзэх тухай В.Вильсоны үзлийг баримтлан Монголын төрийн захиргаа, төрийн албаны хөгжлийг мөн гурван үед хувааж энэ удаад зөвхөн нэгдүгээр үеийг хамруулж судалгаа хийсэн болно. Энэ үе нь XIII-XX зууны эхэн буюу манай эзэн хаант засгийн үеийг хамарч байгаа учраас тэр үеийн түүхэн бодит байдлыг тусгасан сурвалж бичгүүд, хууль цаазын эмхэтгэл, архивын материалуудад тулгуурлаж судалгаа хийгдсэн болно. Судалгааны үр дүнд тухайн сэдэвтэй холбогдол бүхий дөч гаруй эх хэрэглэгдэхүүнээс найман зуун ер орчим баримтыг түүвэрлэн сонгож таван зуун наян хуудаст багтаан (3 хэсэгт хуваан) эмхэтгэж хүлээлгэн өгсөн. Тэр баримтын эмхэтгэл бол судалгааны энэхүү тайлангийн салшгүй бүрдэл хэсэг мөн. Гагцхүү судалгааны эх хэрэглэгдэхүүнээс түүвэрлэсэн баримтын эмхэтгэлийг санхүүгийн боломжоос хамааран тайлантай хамт хэвлүүлж чадсангүй.

Монголын төрийн захиргаа, төрийн албаны түүхэн тодорхой үеийг хамарч судалсан манай судалгааны багийн ажлын үр дүнг товч тусгасан энэхүү тайлан нь манайд захиргааны түүхийн судалгааны анхны шанг татсан шинжээрээ шинэ бөгөөд цаашид энэ чиглэлээр сонирхон судалгаа хийх судлаачид, төрийн алба, захиргааны чиглэлээр суралцаж буй магистрант, докторант нарт бас ч хэрэгтэй баримт сэлт, онол, аргазүй, мэдээлэл, мэдлэг агуулж байгаа гэдэгт итгэж байна. Богд хаант Монгол Улсын үеийн төрийн нэрт зүтгэлтнүүдийн нэг

эрдэмт хүмүүн-Далай чойнхур ван Г.Цэдэнсодном “Аливаа хүн уг өвөг язгуур цагийн мандсан, мөхсөн, алдсан завшсаныг мэдвээс амьсгал мэдэл нээгдмүй, эс ухаж мэдвээс нэгэн насыг унтаж барах мэт” хэмээн хэлж байсныг энд сануулж хэлэх байна.

Эрдэм номын мөр үргэлж цагаан байх болтугай.

Судалгааны багийн ахлагч Олхонууд Ядамын Долгоржав, профессор
(Удирдлагын академийн Төрийн захиргааны тэнхимийн эрхлэгч)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

1.1. Тулгамдсан асуудал

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс Удирдлагын академид хандан “Монгол Улсын төрийн албаны үнэт зүйлс, уламжлал (Түүхэн эх сурвалжид хийсэн шинжилгээ)” сэдвийн хүрээнд судалгаа хийлгэх захиалга өгсний дагуу зохих шалгуур, процедураар сонгогдсон судалгааны баг ажиллаж судалгааны тайланг бэлэн болголоо. Захиалагч байгууллагын зүгээс уг судалгааны ажлыг хийлгэх болсон эрэлт хэрэгцээ, зорилготой уялдуулж судалгааны багийн зүгээс зайлшгүй судалбал зохих дараах зүйлсийг тэмдэглэж байна.

1. Монгол Улс нь бодит түүх, түүхэн эх сурвалж, дэлхийн нөлөө бүхий томоохон эрдэмтэд, улс төрчдийн хүлээн зөвшөөрдөгчлөн нэн эртний улс мөн боловч төрийн алба, төрийн захиргааны тал нь захиргааны шинжлэх ухааны талаас төдийлөн нарийн судлагдсангүй өдий хүрчээ.

2. Аливаа улсын төрийн алба, төрийн захиргаа нь төртэйгөө адилхан урт түүх, эртний уламжлалтай гэдэг нь нэгэнт тодорхой тул түүнийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлан тодруулж үеэс үед өвлөгдөн, тогтвортой, залгамжлагдаж ирсэн зүйл юу байгааг тодруулах нь чухал юм. Бид захиргааны хөгжлийн үе шатны тухай В.Вильсоны хийсэн үечлэлд тулгуурлан судалгаа хийхдээ, эхний ээлжинд түүний хөгжлийн нэгдүгээр үе шаттай холбогдох баримт бичгийн хүрээнд ажилласан болно.

Шигтгээ:

... Аливаа **улсын төрийн захиргааны хөгжлийн үе шатны ерөнхий зүй тогтлыг** нээн илрүүлсэн шинжтэй нэгэн томъёоллыг В.Вильсон уг эсээндээ анх гаргаж тавьсан юм. Энэ нь: “Дэлхийн бөмбөрцөг дээрх орчин үеийн гол нөлөө бүхий улс, үндэстнүүдийн түүхээс цэгнэн тунгаавал, эдүгээ оршин буй бүх тогтолцооноос илүү өндөр хөгжсөн нь аль хэдийнээ дамжин өнгөрсөн, бусад нь бүгдээрээ дамжих нь илэрхий өсөлт, өндийлтийн гурван үе шат байна.

1. Анхных нь Хэмжээгүй эрхт засаг баригч-ээд, хэмжээгүй эрхт дэглэмдээ нийцэж тохирсон захиргааны тогтолцоотой байсан үе.

2. Дараачийнх нь Үндсэн хуулийг тогтоож хэмжээлшгүй эрхт засаг баригч-ээдийг сөгтгөж оронд нь ард олны хяналт бий болгох, тэгэхдээ тэрхүү илүү чухал ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд захиргааг умартаж, хайхралгүй явсан үе.

3. Сүүлийнх нь Бүрэн эрхт түмэн өөрсдөд нь тийм эрх мэдэл олгосон шинэ үндсэн хуулийнхаа дагуу захиргааг хөгжүүлэх үе” аж (Wilson, 1887, p. 204).



а. Нэгдүгээр үеийг нь Хамаг Монгол Улсыг хамтатгаж улмаар Их Монгол Улсыг үндэслэн байгуулсан хэмжээгүй эрхт эзэн Чингис хааны засаглал тогтсон тэр үеэс, өөрөөр хэлбэл, Хамаг Монголыг хамтатгасан Тэмүүжинг Чингис хаан цол өргөмжилсөн 1189 оны шаргачин тахиа жилээс эсвэл, Их Монгол Улс байгуулагдаж хэмжээгүй эрхт эзэн хаанаар нь Чингис хааныг өргөмжилсөн 1206 оны улаан бар жилээс эхлэн 1911 оны цагаан гахай жил Монгол Улсын хэмжээгүй эрхт эзэн хаанаар өргөмжлөгдсөн Богд Жавзандамба хааны хэмжээгүй эрх хязгаарлагдах хүртэлх үеийг оруулан тооцох нь зүйд нийцнэ. Харин Монголын ард түмэн, Монгол Улсын хувьд тохиосон эмгэнэлт нэгэн үе болох 1691 оны цагаагчин хонин жил халхын дөрвөн аймгийн ноёд Долнуурын чуулган дээр Манж Чин улсад дагаар орсноос хойш 1911 оны цагаагчин гахай жил Монгол Улсын Олноо өргөгдсөний анхдугаар он эхлэх хүртэлх хугацаан дахь Ар Монголын төр, захиргааны явдлыг жичид нь авч үзвэл зохилтой.

б. Монголын захиргааны хөгжлийн хоёрдугаар үеийг 1921 оны цагаагчин тахиа жил тус улсад Ардын засаг тогтож хэмжээгүй эрхт Богд эзэн хааны эрх мэдлийг “Тангаргийн гэрээ” - ний дагуу хэмжээлсэн ч хэрэг дээрээ 1930-аад оны төгсгөл лам засагтай¹ үеийг оролцуулаад 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулийн нөхцөл дэх захиргаа, 1990-ээд онд өрнөсөн тэрхүү үйл явцын салшгүй нэгэн хэсэг, бодит үр дүнгийнх нь нэгээхэн илрэл болсон 1992 оны Үндсэн хууль батлагдах хүртэлх хугацаанд хамааруулж болох юм. Чухамхүү энэ үед хэмжээгүй эрхт эзэн хаант дэглэм нуран унаж феодалын хамжлагат ёсны харилцааг халсан ч тухайн цаг үе дэлхий дахиныг хамарсан сэргэлдэгч хоёр лагерийн тогтолцооноос хамаарч манай улсад ЗХУ тэргүүтэй социалист хамтын нөхөрлөлийн орнуудыг баримжаалж нэг намын удирдан манлайллыг Үндсэн хуульчлан мөрдөж байснаас чухамхүү, В.Вильсоны томьёолсончлон “Үндсэн хуулийг тогтоож хэмжээлшгүй эрхт засаг баригч-ээдийг сөлтгөж оронд нь ард олны хяналт бий болгосон ч, хамгийн гол, илүү эрхэм ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд төрийн захиргааг умартаж, хайхралгүй” лам засаг, нам засаг тогтоож байсан үе юм.

в. Харин Монгол Улсын захиргааны хөгжлийн гуравдугаар үе буюу В.Вильсоны томьёолсноор “бүрэн эрхт ард түмэн, өөрсдөд нь тийм эрх мэдэл олгосон шинэ үндсэн хуулийнхаа дагуу захиргааг хөгжүүлж байгаа үе” нь Монголын ард түмэн бид ... гэж тунхагласан 1992 оны Үндсэн хуулиас эхлэн эдүгээ хүртэл үргэлжилж буй цаг хугацаанд хамрагдана. Монголын засаг, захиргааны дээрх гурван үе тус бүрийг хэд хэдэн дэд үе болгон нарийвчлан авч үзэх шаардлагатай гэдэг нь илэрхий байна. Гагцхүү барууны улс орнуудад “ард түмнийхээ төлөө, ард түмнээсээ сонгож бий болгодог, ард түмний засаг захиргаа” буюу товчоор паблик захиргаа (Public administration) гэж нэрлэгддэг захиргааны эхлэл эрчимтэй тавигдаж эхэлсэн үе нь Монгол Улсад 1921 оны ардын хувьсгал, 1924 оны Үндсэн хуулийн үйлчлэлтэй холбогдож гарч ирсэн гэдгийг энд тэмдэглэн хэлэх байна. Үүнийг нотлон өгүүлэх баримт сэлтийн эмхэтгэл, судалгааны материалууд хангалттай бий (Орон нутагт ардчилсан засаг захиргаа байгуулагдсан нь, 1974) (Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд, 1954)

ЭХ СУРВАЛЖ: Төрийн удирдлага, эрхзүйн онол-практикийн өгүүлүүд УБ., 2019

¹ Нэгэн үед Улсын тэргүүн нь Богд Жавзандамба, Ерөнхий сайд нь Шанзов Бадамдорж, Жалханз хутагт Дамдинбазар, лам Бодоо, сайд нар дотор нь Манзшир хутагт Цэрэндорж, Эрдэнэ шанзудба Дашжав, Да лам Пунцагдорж гэхчлэн байсан төдийгүй орон Орон нутагт Дилав хутагт Жамсранжаваас, хутагтаас аваад хошуу захирсан тамгатай хутагт олон байсан лам нарын засаглал дахь байр суурь тийм ч амар амархан арилаагүй бөгөөд ил, далд хадгалагдсаар байсныг бүр сүүлд 1930-аад оны дунд үе гэхэд МАХН-ын Төв Хорооны даргаар Мөрөнгийн хүрээнд 16 жил суусан лам, Буддагийн шавь Лувсаншарав ажиллаж байснаас харагддаг. Энэ үед манай улсад “гэр бүр гэлэнтэй, жалга бүр жастай болж шашны санваар сахисан тоймог толгой, тоймгүй олшрон” 780 орчим том, жижиг хүрээ хийдэд 112 манган лам байсан нь бүх хүн амын тавны нэг, эрэгтэйчүүдийн гуравны нэг хувийг эзэлж байсан тийм нийгмийн (социаль) орчинд лам нар давамгай нөлөөтэй байж засаглах хэмжээнд байсан нь ойлгомжтой. Иймээс ч 1934 онд Монголын засгийн газрын төлөөлөгчид Зөвлөлтийн удирдлагатай уулзах үеэр Ерөнхий сайд П.Гэндэн: “Нам, засагт лам нар үндсэн гол аюул болж байна. Засгаас явуулж буй арга хэмжээг эсэргүүцэх, гажуудуулах, эсвэл саатуулахыг оролдож байна” гэж хэлж Сталин: “Танай улсын дотор

Гэвч монголчуудын төрийн албанд хэрэгжүүлж байсан уламжлал, үнэт зүйлс тэр болгон судалгааны бүтээлүүдэд сайн тодроогүй бүрхэг байгаа нь хэрэглээнд орох бодит байдалд ихээхэн бэрхшээлийг дагуулж байна.

3. Төрийн албаны хүрээн дэх уламжлал нь эцсийн эцэст тухайн үеийн улс, үндэстний болон төрийн албаны үнэт зүйлстэй холбоотой тул уг ойлголтуудыг нягт уялдаатай авч үзэх нь зүйд нийцнэ.

4. Манай зарим улс төрч, сэхээтний дунд гадаадын өндөр хөгжилтэй улсуудын төрийн албаны ололттой талыг Монгол Улсад нэвтрүүлэн шийдэж болно гэх хандлага байдаг. Харин олон улсын туршлагаас харахад аливаа улс гадаадын сайн туршлагыг хуулбарлан авахаас илүүгээр өөрийн орны нөхцөл байдалд тохирсон, үе улиран өвлөгдөж ирсэн төрийн албаны уламжлал, түүний үнэт зүйлсийг орчин үеийн глобалчлалын хүчин зүйлстэй хослуулан хэрэглэх нь үр дүнд хүргэж байгаа нь тодорхой байна. Иймд, төрийн албанахаа уламжлал, үнэт зүйлсийг түүхэн эх сурвалждаа тулгуурлан гаргаж ирэх явдал хойшлуулшгүй асуудал болж байна.

1.2. Судалгааны асуулт

Бид энэхүү судалгааны тулгамдсан асуудлын хүрээнд монгол төрийн албаны үнэт зүйлсийг тусад нь тусгайлан, түүний уламжлалыг дараах багцуудаар асуулт тавьж судалгааны түвшинд гаргаж ирэв. Үүнд,

1. Төрийн албаны үнэт зүйлс ба тэдгээрт үнэнч байх явдалд баримталж байсан шалгуур байсан уу? /Төрийн албанд оролцогчдын тангараг, үнэнч шударгын хэмжүүр, эзэн ба төрдөө үнэнч байх, шашин-үндсээ хамгаалах, улсаа хамгаалах, ард түмэн, эх орон, эрх чөлөө, бүрэн эрхт байдалдаа үнэнч байх, шударга байх, хуулийн дагуу засаглах, зөв ёс зүйтэй байх, эе эвийг эрхэмлэх, энэрэн нигүүлсэх, эрдэм номоор гийгүүлэн төрийн албыг гүйцэтгэх байдал гм/

2. Төрийн албаны хүрээлэнд уламжлагдаж ирсэн зохион байгуулалтын бүтэц судлагдан буй үед байсан уу? /Төвийн болон орон нутгийн түвшинд төвлөрүүлж байсан бүхий л төрийн албаны субъектүүд болох хэмжээгүй эрхтэй эзэн хааны хүрээлэн, зөвлөх эрхтэй их хуралдай, улсын дээд, доод хурал, улсын их хурал, ардын их хурал, гүйцэтгэх эрхтэй хэшигтэн, төрийн яамд, амбан сайдын газар, ардын засгийн газар, сайд нарын зөвлөл, тусгай хороод, газар, орон нутгийн шат шатны засаг захиргааны байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагааны уламжлал/

3. Судлагдан буй үед холбогдох Монгол төрийн албан дахь эрх зүйн

Гэндэнгийн засаг, лам нарын засаг бий болсон байна, лам нарын засаг илүү хүчтэй байна” гэж хэлж байсан нь ч лам засгийг бодитоор хүлээн зөвшөөрч байсны гэрч юм. 1934 оны үед хүрээ хийдийн дэргэдэх дацангууд ба сүмд 18000 гаруй хөвгүүд шавилан байсан бол улсын сургуульд нийтдээ 5000 орчим хүүхэд суралцаж байсан (Монгол улсын түүх. V боть, 2003, хууд. 196) орчинд лам нар давамгай нөлөөтэй байж, засаглах хэмжээнд байсан нь ойлгомжтой.



зохицуулалт гэж байгаа юу? /Түүхэн эрх зүйн сурвалж болох бичмэл хуулиуд, тодорхой эрх бүхий албан тушаалтны зарлиг, айлдвар, тушаал, шийдвэр, ард түмний дунд өвлөгдөн ирсэн зан үйл, аман сургаалууд дахь төрийн албаны эрх зүйн зохицуулалт хэрхэн явагдаж байсан уламжлал/

4. Тухайн үеийн төрийн албан дахь уламжлал болсон ажил үүргийн хуваарилалтын онцлог юу байна вэ? /Шаталсан удирдлагын тогтолцоо (hierarchy), шат шатанд ажил үүрэг гүйцэтгэж байсан түшмэдийн эрх, үүрэг, тэдгээрийн тогтвортой мэргэшсэн байдал, тушаал шийдвэр хэрхэн явагдах зэрэг төрийн албан дахь оролцогчдын ажил үүргийн хуваарийг нарийвчлан гаргаж байсан уламжлал/

5. Төрийн албанд хүмүүсийг сургаж боловсруулж байсан уламжлал юу байв? /Төрийн албаны цөмийг бүрдүүлэх түшмэдийг юуг баримталж хэрхэн бэлтгэж ирсэн, төрийн албанд анх орогчдод эзэмшсэн байх ёстой мэдлэг чадвар, чадахуйн зарчимд тулгуурлан дэвшин ажиллахад нэмж юунд суралцаж байсан, төрийн албан хаагчдын залгамж чанар ямар байсан уламжлал/

6. Тухайн үед төрийн албан бичиг хэрэг хөтлөлтийн талаар тогтсон уламжлал байсан уу? /Нүүдэлчдийн эзэнт улсыг цогцлоосон монголчууд өвөрмөц төрийн албан бичиг хэрэг хөтлөх соёл, төрийн албан баримт үйлдэх үйл явц, гадаад улс оронд болон дотоодын байгууллагад албан бичгээр харилцах, албан тушаалтнуудын хоорондын харилцаанд хэрхэн албан бичиг солилцох уламжлал/

7. Төрийн албаны ёслол, хүндэтгэлийн ямар уламжлал байв? /Төрийн уламжлалт баяр наадам, овоо тахилга зэрэг ёслол хүндэтгэлийн арга хэмжээ, төрийн албан хаагчдын хувцаслалт, эдэлж хэрэглэх эд зүйлс, тамга, тэмдэг хэрэглэх дэг жаяг, дагаж мөрдөх зан үйлийн уламжлал/

8. Төрийн албаны хүрээнд хариуцлага, урамшууллын талаар ямар уламжлал байсан бэ? /Төрийн албанд гавьяа байгуулсан, ажил үүргээ сайн гүйцэтгэгчдэд үзүүлж байсан урамшуулал, хэргэм, зэрэг, цол өргөмжлөх, түшмэдийн цалин хангамж, пүнлүү, тэтгэвэрт гарагчдад хүртээх тэтгэмжийн уламжлал. Нөгөөтээгүүр албан үүргээ ухамсарлаагүйн улмаас осол эндэгдэл гаргагчдад үзүүлэх сануулга, шийтгэл, торгууль, түшмэл эвдэх, цөлөх, цаазлах зэрэг ял шийтгэлийн уламжлал/

9. Төрийн алба, захиргааны зүгээс иргэдээ үүрэгжүүлж ирсэн уламжлал байгаа юу? /Иргэдээс төрийн захиргааны байгууллагуудад орж ажиллах болон алба гувчуур, өртөө улаа, цэрэг харуулын зэрэг төрийн тусгай чиг үүргийн албыг эд хөрөнгөөр болон биеэр гүйцэтгэх уламжлал/

1.3. Судалгааны зорилго, зорилт

Судалгааны зорилго: Монгол Улсын Төрийн захиргааны хөгжлийн нэгдүгээр үед холбогдох түүхэн эх сурвалжид шинжилгээ хийх замаар төрийн албаны үнэт зүйлс, уламжлалыг захиргааны шинжлэх ухааны өнцгөөс судалж тодруулах.

Судалгааны зорилтууд: Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна:

1. Төрийн албаны үнэт зүйлс ба тэдгээрт үнэнч байх явдалд баримталж байсан шалгуур байсан эсэхийг тодруулах;
2. Судлагдан буй үед холбогдох Төрийн албаны хүрээлэнд уламжлагдаж ирсэн зохион байгуулалтын бүтцийг тодруулах;
3. Монгол төрийн албан дахь эрх зүйн зохицуулалтын уламжлалыг гаргах;
4. Төрийн албан дахь уламжлал болсон ажил үүргийн хуваарилалтын уламжлалын онцлогийг гаргах;
5. Төрийн албанд хүмүүсийг сургаж боловсруулж байсан уламжлалыг тодруулах;
6. Төрийн албан бичиг хэрэг хөтлөлтийн талаар тогтсон уламжлал байсан бол гаргаж ирэх;
7. Төрийн албаны ёслол, хүндэтгэлийн хүрээний уламжлалыг судалж гаргах;
8. Төрийн албаны хүрээнд хариуцлага, урамшууллын тогтолцоонд баримталж байсан уламжлалыг гаргах;
9. Төрийн алба, захиргааны зүгээс иргэдээ үүрэгжүүлж ирсэн уламжлалын бичиг баримтын судалгааг гаргах.

1.4. Судалгааны хамрах хүрээ

Монголчуудын бүтээсэн төрийн албаны уламжлал, үнэт зүйлсийг түүхэн үе бүрээр (Хамаг Монгол ханлиг, Их Монгол Улс, Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улс болох Их Юань улс, Алтан ордны улс, Цагаадайн улс, Ил хаант улс, Улс төрийн бутралын үеийн Дөчин дөрвөн хоёрын Монгол Улс, Манж Чин улсын эрхшээл дэх үеийн Монгол орон, Богд хаант Монгол Улс) улируулан судлав.

1.5. Судалгааны ач холбогдол

Төв Азийн өндөрлөгт нүүдэлчдийн өвөрмөц ханлиг улс байгуулсан XII зуунаас Хэмжээт эрхт хаант Монгол Улс болсон 1921 оныг хүртэл урт хугацаанд монголчуудын бий болгосон төрийн албаны онцлог, ололт амжилт, сургамж, залгамж халааг ерөнхий тойм байдлаар шинжилсэн судалгааг урагшлуулж

түүний үнэт зүйлсийг түүхэн эх хэрэглэгдэхүүнд тулгуурласан ахисан түвшний судалгааг хийв.

Судалгаанд тулгуурласан төрийн бодлого явуулахыг хүчтэй дэмжиж буй энэ цаг үед бидний төслийн үр дүнг Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээрт тусгагдсан Мэргэшсэн, хариуцлагатай төрийн албыг бүрэлдүүлэх цогц арга хэмжээ, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.1 дүгээр зорилт Үндэсний нэгдмэл үнэт зүйлс, 5.4 дүгээр зорилт Чадварлаг, ёс зүйтэй төрийн албыг төгөлдөржүүлэхэд эрдэм шинжилгээний эх сурвалж болгон ашиглах хэрэглээний практик ач холбогдолтой болно.

1.6. Нэр томъёоны тодорхойлолт

Төрийн албаны уламжлал, Төрийн албаны үнэт зүйлс, Бичиг баримтын судалгаа, Төрийн алба, төрийн үйлчилгээ, Үнэнч байдал, Мэргэшсэн шинж зэрэг энэ судалгаанд хэрэглэгдэх гол нэр томъёонуудыг орчин үеийн улс төр судлал, захиргааны шинжлэх ухааны ойлголтоор авч хэрэглэнэ. Чухам үүнд манай судалгаанд түүхэн ба логик аргыг нэг хэрэгсэл болгож хэрэглэнэ гэсний учир бий.

1.7. Судалгааны ажлын бүтэц

Монгол Улсын төрийн албаны үнэт зүйлс, уламжлалд холбогдох түүхэн эх сурвалжуудыг тодруулж, дүн шинжилгээ хийснээр судалгааны тайлан 1 /А4: 70 тал/-ийг бичив.

Энэхүү судалгааны ажил нь:

1. Удиртгал
2. Судлагдсан байдлын тойм
3. Судалгааны арга зүй
4. Өгөгдлийн боловсруулалт, шинжилгээний үр дүн
5. Дүгнэлт
6. Эх сурвалжийн жагсаалт гэсэн үндсэн зургаан хэсгээс бүрдэнэ.

Тайлан нь төрийн албыг шинэчлэн хөгжүүлэх, түүний тогтолцоог боловсронгуй болгох санал, зөвлөмж, сургалтад хэрэглэгдэх гарын авлага болно.

Монгол төрийн албанд хэрэглэгдэж байсан аливаа арга барил, шийдлийг тодорхойлсноор өөрийн орны бодит жишээ, баримт бүхий “Төрийн албаны уламжлал, үнэт зүйлст холбогдох баримтууд” эмхэтгэл 1 /А4: 180-200 тал/-ийг хэвлэлд бэлтгэнэ гэж дизайнд тусгасан ч энэ хүрээнд 2 дахин их эх хэрэглэгдэхүүн хуримтлагдав. Иймд, эх хэрэглэгдэхүүнийг 3 ботиор хэвлэж Удирдлагын академийн Судалгааны төвд хүлээлгэн өгөв.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Монгол Улсын төрийн түүх, монголчуудын үнэт зүйлсийн талаар эрдэмтэн, судлаачдын туурвисан судалгааны асар их ном бүтээл хэвлэгдэн гарчээ. Эдгээрийг тэр болгон энд нарийвчлан дурдах бололцоогүй. Тэгээд ч төслийн зорилгын хамрах хүрээнээс халин гарах юм. Иймд судалгааны дизайныг боловсруулахдаа судлагдсан байдлын тоймыг XIII-XX зууны эхэн үеийн монгол төрийн албаны үнэт зүйлс, уламжлалын судлагдсан байдлаар хязгаарлахыг эрмэлзсэн тул монголын түүхийн ерөнхий үечлэлийг баримталж XII-XVI зуун, XVII-XX зууны эхэн хэмээн хоёр хэсэгт хуваан бүтээлийн тоймыг хураангуйлан гаргав.

2.1. XIII-XVI зууны үеийн монгол төрийн албаны үнэт зүйлс, уламжлал

Хамаг Монгол ханлиг хүчирхэгжсэн XII зуунаас Монголын нэгдсэн улс сулран доройтсон XVI зууны хоорондох үеийн төрийн албаны талаар манай улсын нэртэй эрдэмтдийн өгүүлэл, илтгэл, номын бүлэг, зүйлд дараах байдлаар тусгагджээ. Үүнд,

Академич Ч.Далайн монгол, хятад хэл дээрх сурвалжуудад тулгуурлан “Хамаг Монгол Улс”, “Их Монгол Улс”, “Монголын Юань улс” (1973; 1994; 1996) гурван боть бүтээл туурвисан нь Монголын эзэнт гүрний үеийн түүхийн асуудлаар эдүгээ хүртэл тус улсад хэвлэгдэн гараад байгаа томоохон судалгаануудын (ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн судлаачдын туурвисан Монгол Улсын түүх (2003) таван боть зохиолын - II боть, 2006, 2019 онд Монголын эзэнт гүрний түүхээр тусгайлан гаргасан түүхийн таван боть хамтын бүтээлүүд, МУИС-ийн Түүхийн тэнхимээс 2019 онд эрхлэн гаргасан Монголын эзэнт гүрний түүхийн таван боть) эх суурь болов. Түүний бүтээлүүдэд дундад үеийн монголын төрийн албаны ерөнхий байдал тодорсон болно.

Академич Ш.Бира монгол, түвд болон өрнөдийн олон хэлний сурвалжууд, судалгааны бүтээлүүдийг харьцуулан дундад үеийн төрийн албаны зарим асуудлыг хөндсөн хэд хэдэн эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлжээ. Тухайлбал, “Монголын төрт ёсны үүсэл хөгжил” нэртэй томоохон өгүүлэлдээ хэшигтэн нар нь эзэнт гүрний үеийн засаг захиргааны хэргийг хариуцсан албан хаагчид байжээ хэмээн үзсэн. Мөн тэнд төрийн албан хаагчдын ажил үүргийн хуваарийн талаар нарийвчлан шинжилсэн байна (Бира, 2001, хууд. 209).



Академич Ж.Болдбаатар тус улсын төр, эрх зүйн түүхэн асуудлаар онолын болон баримтат олон арван бүтээл туурвижээ. Түүний “Их Монгол Улс, эзэнт гүрний төрийн хэлбэр, шинж чанарын тухай асуудалд” онолын судалгааны өгүүлэлд “Төрийн бүтцийн хувьд Их Монгол Улс төрийн тэргүүн-Хаанаа өргөмжлөн сонгодог Их Хуралдай, Сэцдийн зөвлөл мэт ардчилсан шинжтэй зарим бүрдлийг өөртөө агуулсан, засаг захиргааны цомхон, оновчтой бүтцийг бий болгожээ” гэж дүгнэжээ (Болдбаатар, 2018, хууд. 22). Үүнээс гадна төрийн албанд үүрэг гүйцэтгэж явсан олон түүхэн бие хүний намтар түүний судалгаанд тусгалаа олсныг тэмдэглэх хэрэгтэй.

Дундад үеийн монголын төр, эрх зүйн асуудлыг тусгайлан судалсан доктор Ц.Минжин (2009), доктор Н.Ням-Осор (2012), доктор Д.Дашцэдэн (2015), доктор А.Цанжид (2019) нарын судалгааны бүтээлүүдэд бидний дэвшүүлэн буй асуудлууд нэлээн дурдагдсан. Мөн судлаач О.Дагвадоржийн түүхэн сурвалжуудаас шүүж эмхэтгэсэн XII-XIV зууны Монгол хаадын зарлигийн товчоон (2011 а, б) хоёр боть ном нь сонирхолтой бүтээл болсныг тэмдэглэе. Энэ мэтчилэн Монгол Улсад хэвлэгдсэн олон тооны судалгааны бүтээлээс гадна БНХАУ-ын ӨМӨЗО-ны Сайшаал (1987) зэрэг нэр хүндтэй эрдэмтэн судлаачдын ном зохиолд эзэнт гүрний үеийн төрийн албаны тухай чамгүй тодорсон болно.

Бидний төслийн судалгааны асуудлыг дан ганц монгол эрдэмтэд судалсангүй. Олон улсын нэртэй доктор, профессорууд өөр өөрсдийн судалгааны ажилтай уялдуулан анзааран судалсан ажээ. Үүнд,

Дундад зууны үеийн монголчуудын эрх зүйн сурвалжуудыг монгол, хятад зэрэг дорно дахины олон хэлийг ашиглан судалсан Австрийн нэрт монголч эрдэмтэн Игорь де Рахевилз (1993, 2004), Америкийн нэрт монголч эрдэмтэн Элизабет Эндикотт-Вест (1989), Христوفر Этвүд (2004) нарын томоохон судалгаануудад байдаг. Бидний хөндөж буй сэдвийн хүрээнд өрнө, дорно дахины хэл дээр бичигдсэн сурвалжуудыг ашигласан оросын монголч эрдэмтдийн цөөнгүй бүтээл гарсныг тэмдэглэхэд илүүдэхгүй. Тэдгээрээс дэлхийн монгол судлалын ноён оргил болсон Б.Я.Владимирцов (1934)-оор эхлэн В.А.Рязановски (1937), Ж.Вернадски (1938), Т.Д.Скрынникова (1997) нарын бүтээлүүдийг онцолж болно. Мөн ойрх дорнодын түүхэн сурвалжуудыг ашиглаж дундад зууны үеийн монголын төрийн байгуулал, төрийн зүтгэлтэн нар, эрх зүйн талаар цөөн тооны бүтээлүүд хэвлэгдэн гарчээ. Тухайлбал, Израйлын перс судлаач Д.Аялон (1971, 1973), Их Британийн монгол судлаач Дэвид О.Морган (1986), Паул Д.Буел (1993) зэрэг хүмүүсийн бүтээлүүд болно.

Эзэнт гүрний дараах үеийн төрийн албаны зарим асуудлууд ч дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдын бүтээлд бага зэрэг хөндөгджээ. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улсын хятад, монгол судлаач Хенри Серруис Монголын түүхийн тулгуур сурвалжууд, Минулсын судар зэрэг түүхэн эх хэрэглэгдэхүүнийг ашиглаж XV зууны Монгол дахь Тайшийн захиргааны талаар тусгайлан

өгүүлэл бичсэн (Serruys, 1977, pp 353-380). Үүндээ нэгэн цаг үед хаадтай өрсөлдөх хэмжээнд эрх мэдэл нь тэлж байсан алтан ургийн бус гаралтай төрийн зүтгэлтэн нарын үйл ажиллагааг тод гаргажээ. Түүний судалгааг цааш хөгжүүлсэн Дэвид М.Робинсон (2004) XV зууны монголын төрийн албаны зарим асуудлыг хөндсөн байна. Түүнчлэн Японы монголч эрдэмтэн Окада Хидэхиро XV зууны Монголын нийгмийн түүхийн талаар хэд хэдэн судалгааны ажил бичжээ.

Монгол Улсын түүхч, доктор Л.Жамсран, доктор Д.Гонгор нарын томоохон судалгааны ажлуудад эзэнт гүрний хүчин чадал бууран доройтсон XVI зууны сүүлээс XVII зууны эхэн үеийн монголын төрийн түүхийн судалгаа харьцангуй сайн тодорсон юм. Дээрх эрдэмтэд болон бусад судлаачдын бүтээлүүдэд гарсан үр дүнгүүдээс улс төрийн бутралын үеийн түүхийг Монгол Улсын түүхийн гуравдугаар ботид (ред. Л.Жамсран 2003) хураангуйлан бичсэн нь тэр үеийн төрийн албаны зарим зүйлсийг тодруулсан чухал албан түүх болжээ.

2.2. XVII-XX зууны эхэн үеийн монгол төрийн албаны үнэт зүйлс, уламжлал

Төвлөрсөн улсын сүр хүч сулран доройтсон XVII зууны эхэн үед монголчуудын дотоод улс төрийн хямрал туйлдаа хүрч ээлж дараалан Манж Чин улсын эрхшээлд орсноор нэгэн шинэ үеийн түүхийн эхлэл болов. Харь гүрний “хуваа, захир” бодлогын улмаас Манж Чин улсын баруун хойд хязгаар болсон монголчуудын уламжлалт засаг захиргааны бүтэц огцом өөрчлөлтөд оржээ. Үүнтэй холбоотой олон захиргаанд хуваагдсан монголчуудын талаарх судалгаа орон нутгийн шинж төрхтэй болов. Жишээлбэл, өгүүлэн буй үеийн монголчуудын хүн амын олонхыг бүрдүүлэгч Халхчуудын улс төрийн талаар академич Ш.Нацагдорж (1960, 1963, 1971, 1979) олон тооны томоохон бүтээл туурвисан юм. Түүний хэвлүүлсэн бүтээлүүдээс бидний судалгаанд хэрэглэгдэх нэгэн чухал эх хэрэглэгдэхүүн бол “Улаан хацарт” (1960) хэмээх монголын уламжлалт хэв хуулийг эмхэтгэн гаргасан явдал болно. Түүнээс гадна Америкийн нэрт монголч эрдэмтэн Оуэн Латтимор Манжийн үеийн Монголын талаарх (1934) бүтээлдээ Өвөр Монголчуудын засаг захиргааны тухай өгүүлэхийг зорьсон байна.

Манж Чин улсын түүхийн талаар олон улсын эрдэмтэд сүүлийн жилүүдэд хүч түрэн судалгааны ажил эрхэлж буй нь онцлог болж байна. Тэдгээрээс манж, хятад, монгол зэрэг олон хэлний сурвалжуудыг ашиглаж нэгэн сэдэвт бүтээл болон судалгааны нэлээд тооны өгүүлэл хэвлүүлсэн Америкийн Нэгдсэн Улсын нэрд гарч буй монгол судлаач Жохан Элверског (2006) энэ асуудлыг зарим талаар дурджээ.

1911 онд үндэсний эрх чөлөөний хувьсгалаар тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан Богд хаант Монгол Улсын үеийн төрийн түүхийн судалгаа



харьцангуй өргөн дэлгэр гэж үзэж болно. Тухайлбал, Богд хаант Монгол Улсын төрийн албанд ажиллаж байсан Н.Магсаржав (1928), Л.Дэндэв (1934) нарын бүтээлүүдэд XX зууны эхэн үеийн төрийн албаны зарим асуудлууд тэмдэглэгдэн үлджээ. Орчин үеийн шинжлэх ухааны онол, арга зүйн үүднээс академич Б.Ширэндэв (1967-1968), доктор М.Санждорж (1974), доктор Б.Содовсүрэн (1989) нарын бүтээлд ардын хувьсгалын урьдач нөхцөлийн үеийн нийгэм-төрийн байдал, эрх зүйн талаар даацтай тодорчээ. Энэ үеийн талаар туурвисан дотоод, гадаадын судлаачдын бүтээлийн үр дүнг нэгтгэж Монгол Улсын түүхийн тавдугаар ботид (ред. Ж.Болдбаатар, [М.Санждорж], [Б.Ширэндэв] 2003) дэлгэрэнгүй өгүүлжээ.

Сүүлийн жилүүдэд түүхийн шинжлэх ухааны доктор Ж.Урангуа (2006), Ц.Батбаяр (2006), О.Батсайхан (2008) нарын нэгэн сэдэвт бүтээлүүд Богд хаант Монгол Улсын үеийн төрийн албаны зарим зүйлсийг хөндсөн болно. Түүнчлэн доктор З.Лонжид, Г.Дашням, Т.Билэгсайхан, судлаач Ш.Эрдэнэбат, Г.Намансүрэн (2011, 2020) нар XX зууны эхэнд холбогдох архивын баримтуудыг эмхэтгэн хэвлүүлж буй нь тухайн үеийн төрийн албаны уламжлал, үнэт зүйлсийн талаарх зарим түүхэн эх хэрэглэгдэхүүнийг олны хүртээл болгож эхлээд байна. Мөн доктор Б.Баярсайхан нар Монгол Улсын түүхэн эрх зүйн баримтуудыг орчин үеийн кирилл үсэгт буулгах ажлыг цувралаар хийсэн (2006 а; 2006 б; 2008, 2010) нь эрх зүйн түүхэн сурвалжийн судалгаанд чухал алхам болов.

Өгүүлэн буй үеийн төрийн албаны зарим асуудлын тухай Япон улсын нэрд гарч буй монголч эрдэмтэн Макото Тачибана (2017) 1911 оны үндэсний хувьсгалын дараах тусгаар тогтносон монголчуудын засаглалын талаар анхаарсан бол ОХУ-ын нэрд гарч буй түүхч Иван Саблин нар (2021) монголчуудын хурлын үйл ажиллагааны талаар төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, судалгааны өгүүллүүд нийтлүүлж буй нь олон улсын мэргэжилтнүүдээс өндөр үнэлгээ аваад байна.

Бүгд найрамдах засаглал тогтсон үеийн төрийн албаны үнэт зүйлс, уламжлалын тухай зарим асуудал түүхчдийн бүтээлд тусгагдсан болно. Тухайлбал, доктор М.Санждорж “Ардын төрийн түүх” (1974) номондоо 1924-1940 оны үеийн захиргаанд гарсан түүхэн өөрчлөлтүүдийг нарийвчлан тодруулсан. Доктор Ч.Дашдаваа, академич Ж.Болдбаатар нарын туурвисан олон тооны судалгааны ажилд төслийн сэдэв тус тус хөндөгдсөн болно.

Судалгааны бүтээлүүд туурвихаас гадна түүхч, хэл бичгийн эрдэмтэд олон тооны эх сурвалжуудыг олон хэлнээс эх хэлээрээ орчуулж амжжээ. Тухайлбал, Монголын нууц товчоо, Дэлхийг байлдан дагуулагчийн түүх, Судрын чуулган, Юань улсын судар, Мин улсын судар, Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс, Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг, Гадаад Монгол, Хотон аймгийн ван, гүнгүүдийн илтгэл шастир, Монголчуудын хошуу нутгийн тэмдэглэл зэрэг олон тооны сурвалж бичгүүд

болно. Ерөнхийдөө хятад, орос, перс зэрэг олон хэлээр үйлдэгдсэн монголын түүхэнд холбогдох ихэнх эх хэрэглэгдэхүүнийг Монгол Улсад орчин үеийн кирилл үсэг, БНХАУ-ын ӨМӨЗО-нд худам монгол бичиг, өрнөдийн олон улсад англи хэлээр орчуулан буулгасан байна.

Харамсалтай нь олон улсын нэртэй судлаачдын хийсэн хятад, перс, манж, түвд, орос хэл дээр бичигдсэн эх хэрэглэгдэхүүний орчуулга, тэдгээрийг ашиглаж онолын өндөр түвшинд бичсэн судалгааны ажлуудыг манай улсын судлаачид ашиглах нь харьцангуй хангалтгүй байна. Мөн улс төрийн түүхээс илүүтэйгээр эх бичиг, сурвалж судлалын судалгаанд голлон төвлөрч ирсэн Өвөр Монгол судлаачдын эмхэтгэсэн сурвалж бичиг, хэвлүүлсэн судалгааны бүтээлүүдийг ч анзаарахгүй өнгөрөх тохиолдол гарсаар байна. Иймд бид монголын түүхэнд холбогдох сурвалж бичиг, судалгааны бүтээлүүдийг аль болох бүрэн шүүн үзэхээр ажил үүргээ хуваарилж аваад байна.

Эцэст нь дүгнэж үзэхэд бидний дэвшүүлэн буй сэдвийн талаар олон тооны бүтээлд хөндөн үзсэн боловч тэдгээр нь их төлөв дам, хавсарга байдлаар гарсан нь учир дутагдалтай байна. Тийм ч учраас ихэнхдээ нэгэн сэдэвт зохиол, хамтын бүтээлийн багавтар хэсэг, зүйл эсхүл богино хэмжээний өгүүлэл, илтгэл төдийгөөр олны хүртээл болж байв. Үүнээс үзэхэд Монгол Улсын төрийн албаны үнэт зүйлс, уламжлалыг тусгайлан шинжилсэн судалгааны дорвитой бүтээл туурвил гаргах нэн чухал эрэлт байгааг судлагдсан байдлын тойм бидэнд сануулж байна.

2.3. Судалгааны үзэл баримтлалын хүрээ

Бид судалгаандаа В.Вильсон, М.Вебер, Мооре нарын сонгодог эрдэмтдийн үзэл баримтлалыг баримталж ажиллав. Захиргааны шинжлэх ухааны суурийг тавигчдын нэг-В.Вильсоны “Захиргааг тухайлан судлахуй” хэмээх алдарт бүтээлдээ тусгасан төрийн алба, төрийн захиргааны хөгжлийн зүй тогтол, ялангуяа захиргааны хөгжлийн үечлэл нь биднээс судалгаандаа баримталсан үзэл баримтлалын нэг болж судалгааны ажлын ерөнхий хүрээг тогтооход чухал ач холбогдолтой байсныг тэмдэглэвэл зохино. Мөн германы онолч М.Веберийн “Улс төр мэргэжил болох нь” хэмээх бүтээлд тусгагдсан улс байгуулахад хүчирхийлэл, албадлагын үүргийн талаарх үзэл баримтлал зэрэг нь бидний судалгааны ажилд анхаарагдсан болно. Судлагдан буй үеийн Монголын төрийн уламжлал, үнэт зүйлсийн асуудал манай судалгааны гол объект болж байсан учраас Үнэт зүйлийн онол, уламжлалтай холбоотой судлаачдын үзэл баримтлал, ялангуяа АНУ-ын эрдэмтэн Марк Моорийн онол үзэл баримтлалын хувьд чиг болсон.

Судалгааны явцад сэдвийн нэрэн дэх уламжлал, үнэт зүйл гэх хоёр нэр томъёоны байрыг солиход хүрсэн. Үүний учир нь логикийн хувьд уламжлал болсон зүйл нь үнэт зүйлийг төрүүлдэггүй, харин эсрэгээрээ үнэт зүйлийн

хэмжээнд очсон зүйл уламжлал болон үргэлжилж хадгалагддаг болох нь тодорхой болсон билээ. Манай судалгааны явцад эдүгээ хүртэл дийлэнхийн хэрэглэж заншсан үнэт зүйл гэх нэр томъёоны алтернатив хувилбар болж болох “эрхэмж” гэх нэр томъёог шинээр оруулж хослуулан хэрэглэсэн болно. Цаашид уг нэр томъёо, түүнээс үүдэн гарах эрхэмжийн онол нь бусад судалгаанд үзэл баримтлалын нэг тодорхой чиг, хүрээ болж болох юм.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэ судалгаа нь нэг талаас эрэл хайгуулын, нөгөө талаас дискрептив судалгааны төрөлд хамаарагдана. Тухайн асуудлаар түүхэн эх сурвалжид тулгуурласан судалгаа, тэр тусмаа захиргааны шинжлэх ухааны аспектаар харьцангуй бага судлагдсан тул энэ нь яах аргагүй хайгуулын шинжтэй болж байгаа юм. Тодорхой чиглэлүүдээр хайгуулын үр дүнд шинэ баримт сэлт тогтоогдсон нь цаашид судалгаа, сургалтын эргэлтэд орно гэж найдаж байна.

Нөгөө талаас энэ нь Монгол Улсын төрийн албаны уламжлал, үнэт зүйлсийг бусад баримт сэлтийн хамт тодорхойлж өгөхөд хэрэгтэй өгөгдөл мэдээлэл болж чадах юм. Ингэснээр тухайн судлагдахууны дүр зураг илүү тодрох болов.

Судалгааны зорилго, зорилтоо хэрэгжүүлж судалгааны асуултад хариулт олохын тулд дараах арга, арга зүйг удирдлага болгон ажиллалаа.

1. Баримт бичгийн шинжилгээ хийх сурвалж судлал, архив зүйн аргын гол арга болох Документ судлалын аргыг ашиглаж төслийн сэдэвт ажлын хүрээнд холбогдох материалыг дараах эх хэрэглэгдэхүүнээс түүвэрлэн цуглуулав. Үүнд,

- Түүхэн эх зохиолууд (Монголын нууц товчоо, Судрын чуулган, Юань улсын судар, Цагаан түүх, Алтан товч, Мэргэн гэгээний Алтан товч, Хаадын үндсэн хураангуй алтан товч, Алтан хааны тууж, Алтан эрих, Алтан хүрдэн мянган хигээст бичиг, Эрдэнийн товч, Эрдэнийн эрих, Шар тууж, Асрагч нэртийн түүх, Гангын урсгал, Болор толь, Болор эрих, Богд Чингис хааны байлдааны бичиг, Монгол боржигид овгийн түүх, Хөх судар, Гадаад Монгол, Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир, Монгол Улсын шастир, Монголын товч түүх, Монгол Улсын товч түүх г.м)

- Эрх зүйн сурвалж (Их засаг, Халх-Ойрадын цааз, Халх журам, Улаан хацарт, Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг, Монгол Улсын хууль зүйлийн бичиг г.м)

- Архивын баримт (Монгол Улсын Үндэсний төв архивт хадгалагдаж буй хөмрөг М, хөмрөг А, хөмрөг С-ийн дансанд байгаа төвийн болон орон нутгийн засаг захиргааны бүхий л байгууллагын баримт бичгүүд г.м)

- Нийтлэл, дурдатгал, тэмдэглэл, судалгааны бүтээлүүд (Хорьдугаар зууны эхэн үед хэвлэгдэж байсан “Шинэ толь” зэрэг өдөр тутмын сонин, мөн тухайн үеийн үйл явдалд оролцож, албанд зүтгэж явсан хүмүүсийн дурдатгал, монгол нутагт ирж байсан жуулчдын тэмдэглэл, төрийн албаны талаар хэвлүүлсэн гадаад, дотоодын судлаачдын бүтээлүүд г.м)



2. Судалгааны хүрээнд цуглуулсан эх баримтуудад түүхэн ба логик арга зүйг хослуулан баримт бичгийн шинжилгээ хийв.

Тухайлбал, энд сэдэв болгон тавиад буй үзэгдэл, үйл явцыг оновчтой тодорхойлж гаргахад түүхчлэх хийгээд хийсвэрлэх, логик сэтгэлгээний үүднээс гаргасан ерөнхий зүй тогтолын шинжтэй зүйлсийг хослуулах явдал чухал гэдэг нь тодорхой. Манай судалгааны асуудлыг дан ганц түүхчлэх үзэл, түүхэн аргын үүднээс тайлбарлахад төвөгтэй бөгөөд заавал логик зүйл, логик арга шаардагдсан. Тэгэхдээ түүхэн хийгээд логик арга нь хоорондоо тэс харш биш, харин ч ивээл шинжтэй бөгөөд логик арга нь бодит түүхэн үйл явцыг өвөрмөц маягаар тусгаж байдгийг бодолцсон болно. Логик аргын онцлог нь түүхийн тодорхой хэлбэр болон хөгжлийн ерөнхий зүй тогтолыг эвдэн гажуудуулж байгаа элдэв төрлийн санамсаргүй, тохиолдлын чанартай зүйлсээс цэвэрлэгдэж чөлөөлөгдсөн болохоос биш мөн л түүхэн арга юм. Иймээс логик, сэтгэхүйн зүйлс гэдэг нь юмс үзэгдэл, түүний хөгжлийн түүхийг хийсвэр ойлголтоор сэргээн дүрсэлсэн хэрэг юм. Түүхэн зүйл нь логик зүйлтэй харьцуулахад анхдагч байдаг ч логик зүйл нь түүхийн үндсэн үеүдийг тусгадаг. (Я.Долгоржав, 1989, хууд. 97) Энэ талаар Ф.Энгельс “Түүх юунаас эхэлж байна, сэтгэхүйн үйл явц мөн түүнээс эхлэх ёстой бөгөөд түүний цаашдын хөдөлгөөн нь түүхийн үйл явцыг хийсвэрээр, онолын талаар тууштай хэлбэрээр л тусгасан тусгал байх болно. Энэ тусгал нь бодит түүхэн үйл явцаар нөхцөлдсөн ч зохих хуулиудаар засварлагдсан байх бөгөөд тэгэхдээ түүхэн үеийн процесс бүхнийг түүний хөгжил бүрэн боловсорч сонгодог хэлбэрээ олсон тэр байдлаар нь авч үзэж болох юм” гэж бичжээ. (К.Маркс, Ф.Энгельс, хууд. 572)

Иймээс зарим тохиолдолд, судлаач хүн юмс үзэгдлийг хангалттай хөгжсөн хамгийн боловсронгуй хэлбэрээс нь эхлэн судлах ёстой болдог бөгөөд үүнд логик арга чиглэдэг. Учир нь юмс үзэгдлийн хөгжил дөнгөж эхнийхээ үе шат, үр хөврөлийн байдалтай байхдаа бусад нөхцөл байдлуудаас болоод бүрхэгдэж, нуугдмал байсан үндсэн гол шинжүүд нь боловсронгуй шатандаа илүү тод илэрч гардаг. Ийм ч учраас хүний анатомийг судлах явдал мичний анатомийг судлах түлхүүр болдог. Капиталист нийгмийн хөгжлийн хуулиудыг мэдэх нь өмнөх нийгмийн хөгжлийн түүхэн үүсэл, хөгжлийг ойлгоход түлхүүр болдог юм гэж К.Маркс тэмдэглэж байсан. Чухам энэ арга зүйг удирдамж болговол, манай төрийн захиргаанд түшмэдийн хүрээ (институц) үүсч төлөвших шатанд гарч ирж байсан үзэгдэл, кейсийн учир шалтгааныг төрийн захиргааны шинжлэх ухааны өнөөгийн өндөрлөг, төрийн алба, түшмэдийн тогтолцооны өнөөгийн бодит практикийн түвшингээс өнгийж харах шаардлага тулгарч байгаа гэсэн үг. Ийм ч учраас манай судалгаанд төрийн захиргааг харьцангуй хөгжсөн түвшинд нь судалж үзэж онолын түвшний дүгнэлтүүд гаргасан Вудро Вильсон, Макс Вебер зэрэг нэрт эрдэмтдийн хийсвэр сэтгэлгээ, логикийн түвшинд боловсрогдсон үзэл баримтлалаас онол, арга зүйн “туслалцаа авах”, тэдгээрийг захиргааны хөгжлийн анхан шатанд манайд илэрч байсан түүхэн

баримт сэлтийг уялдуулж үзэхийг хичээсэн тал бий.

Баримтуудыг сэдэвчлэн ангилахдаа тухайн баримтын гол утгыг илэрхийлж буй ангилалд хамруулав. Иймд, зарим нэгэн томоохон хэмжээний баримт нь бусад ангилалд дам хамрагдаж буйг тэмдэглэх нь зүйтэй.

3. Кейс судалгааны арга

Энд судлагдан буй сэдвийн онцлогоос хамаарч судалгааны зарим хэсэгт “кейс судалгааны арга”-ыг хэрэглэхээр дизайндаа тусгасан төдийгүй хэрэглэх оролдлого хийв. Манай судалгааны явцад судалгааны эх сурвалж, хэрэглэгдэхүүн болгон авсан ном зохиол, архивын баримтанд төрийн захиргааны хөгжлийн үйл явцад холбогдох олон содон тохиол, жишээ-кейсүүд гарч ирсэн. Тэдгээр үйл явдал-кейс дээр шинжилгээ хийж зарим ерөнхий дүгнэлт гаргах бололцоо олдсон. Гэхдээ энэ аргыг бид зарим зүйлийг тодруулах, хийсвэр, ерөнхий дүгнэлтээ амьдралын жишээ баримтаар баяжуулах зорилгоор туслах хэрэгсэл болгон ашигласан болно. Тэгэхдээ кейс, түүнийг судалгаа, сургалтад хэрэглэх ерөнхий шаардлагыг харгалзан үзсэн. (Я.Долгоржав, Ш.Батсүх, Н.Болд, 2020)

4. Түүхэн уран зохиолыг ашиглах арга

Төрийн захиргааны судалгаанд, тэр тусмаа захиргаа, удирдлагын түүхэнд холбогдох асуудлыг судлахад уран зохиолын шинжтэй бүтээлүүд туслах материал болж ашиглагдах боломжтой юм. Учир нь тухайн цаг үед ажиллаж амьдарч байсан сэтгэгч, албаны хүмүүсийн бодит дурсамж, захиа, зарим албан бичиг баримтууд тухайн зохиогчийн ном бүтээлд тусгагдсан байдаг. Тэдгээр үнэ цэнэтэй баримт сэлтийг олж илрүүлэн судалгаанд ашиглах нь чухал. Францын төрийн захиргаа судлаачид судалгаандаа Бальзакийн зарим бүтээлээс үнэ цэнэтэй баримт, санаа олж ашиглаж байсан шиг бид монголын захиргаа, төрийн албаны түүхэнд холбогдолтой олон баримтыг энд ашиглагдсан Инжаннашийн “Хөх судар” мэтийн түүх-уран зохиолын шинжтэй бүтээлээс авч ашигласан болно.

5. Олж илрүүлсэн зарим баримт бичгийн агуулгад танин мэдэхүйн герменевтик шинжилгээ хийх тухай судалгааны төсөлдөө тусгасан. Энэ талаар бид цаг хугацааны болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан цаашид дэлгэрүүлж үзэх, нарийвчлах зүйл олныг орхигдуусан байж магадгүй. Гэхдээ уг судалгааны хүрээнд авч ашигласан баримтууд болон эдүгээ олон судлаачдын хувьд голлон хэрэглэгдээд буй “үнэт зүйлс” гэх нэр томъёо бидний сонирхон судалж буй үед байхгүй байсныг тогтоож түүний оронд “эр” язгууртай олон үг зэрэгцэн хэрэглэгдэж байснаас “эрдэнэ”, “эрхэм”, “эрхэмлэл”, “эрмэлзлэл” зэрэг нь утга агуулгын хувь өнөөгийн “үнэт зүйл” гэх нэр томъёоны дор ойлгогдож буй утгыг илүү тээж байж, тэр тусмаа “эрхэмж” гэсэн үг бүр илүү байж гэдгийг герменевтикийн үүднээс тодотгон гаргасан болно. Чингэхдээ, эрхэмж гэдэг үгний эсрэг утгыг “доромж” гэх үг илэрхийлж байсныг текстийн

шинжилгээгээр гарган, Эрхэмж гэх ойлголт гарч ирсэн танин мэдэхүйн герменевтик зураглалыг:

МЭДРЭМЖ- БОДОМЖ- ҮНЭЛЭМЖ- ЭРХЭМЖ гэсэн товч боловч зураглалаар илэрхийлсэн болно.

Судлагдан буй үеийн Монгол Улсын төрийн албаны уламжлал нь рационал сэтгэлгээний үүднээс хандвал, энэхүү судалгааны тайлангийн нэг дэх хэсэгт тоймлон гаргахыг оролдсон төрийн албаны үнэт зүйл, эрхэмжийн суурь, дэвсгэр дээр үндэслэн гарсан гэдэг нь тодорхой юм. Тэдгээр уламжлалыг тодорхой чиглэлүүдээр баримт түшин гаргахыг хичээхийн өмнө, ерөөс уламжлал гэдгийн дор юу ойлгож байгаагаар концепцийн хувьд товч тодорхойлолт өгөх нь зүйтэй юм.

Уламжлал гэдгийн дор, үеэс үед буухианы “мод” мэт дамжин, нийгмийн харилцааны нэгэн тогтвортой тохируулга, үнэ цэнтэй хэм хэмжээ болж байдаг ажил хэрэгч үйл явц, зан үйл зэргийг багтаасан (традици гэх латины *trāditiō* «дамжуулах» гэх үгээс гаралтай) цогц ойлголт, түүний практик илрэл бөгөөд хэн нэгэн зохиогчгүйгээр, хуримтлагдсан туршлага сургамжийн үр дүнд бий болж, түүнийг нийгмийн зонхилох, тогтвортой бүлэг хүмүүс **ЗӨВ** хэмээн үзэж өөрийн зан авир, үйл ажиллагаандаа шалгуур, удирдлага болгож байдаг жишиг загвар, дүрэм, төсөөлөл, хэм хэмжээний тогтолцоо гэж ойлгож байна. Чухам энэ утгаар уламжлал гэх ойлголтыг ойлгож Монгол Улсын төрийн албаны тодорхой үед холбогдуулан авч үзсэн болно.

Судалгааны эх хэрэглэгдэхүүн болгон ашигласан эх сурвалжууд, тэдгээрээс **баримт түүвэрлэсэн байдлыг** дүрслэн харуулбал:

Зураг 1. Төрийн албаны үнэт зүйлс, уламжлалд холбогдох баримтууд



Хүснэгт 1. Баримтын эх сурвалж

№	Сонгож авсан баримтын эх сурвалж	Баримтын тоо
1	Монголын нууц товчоо	23
2	Арван буянт номын Цагаан түүх	7
3	Хаадын үндсэн хураангуй Алтан товч	9
4	Лувсанданзан. Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой	3
5	Мэргэн гэгээн Лувсандамбижалцан. Их Монгол Улсын үндсэн алтан товч тууж оршвой	2
6	Чакраварди Алтан хааны тууж	4
7	Саган Сэцэн. Эрдэнийн товч	12
8	Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршвой	2
9	Жамба. Асрагч нэртийн түүх	6
10	Рашпунцаг. Болор эрих	69
11	Гомбожав. Гангын урсгал	1
12	Галдан. Эрдэнийн эрих хэмээх түүх болой	9
13	Дарма гүүш. Алтан хүрдэн мянган хигээст	8
14	Гомбованжил. Алтан эрих	4
15	Ломи. Монгол Боржигид овгийн түүх	2
16	Чингис хааны үе улирлыг тэмдэглэсэн хаадын үндэсний шастир хөх түүх	2
17	Ванчинбалын Инжаннаши. Хөх судар	2
18	Юань улсын судар	317
19	Монгол татаарын бүрэн тэмдэглэл, Хар татаарын хэргийн товч	10
20	И-юй бичиг	1
21	Марко Поло. Орчлонгийн элдэв сонин	4
22	Гийом де Рубрук. Монголын эзэнт гүрэнд зорчсон нь	1
23	Плано Карпини. Монголчуудын түүх	4
24	Рашид ад дин. Судрын чуулган	34
25	Алааддин Ата Мелик Жувейни. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх	1
26	Мин улсын судар	11
27	Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс	36
28	Биеэр дайлж өрнө умрын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг	16
29	Зүүн гарыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг	43
30	Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир	21
31	Монгол цаазын бичиг	18
32	Илтгэл шастир	8
33	Жинхэнэ дагаж явах хууль, дүрэм	1
34	Н.Магсаржав. Монгол Улсын шинэ түүх	2
35	Л.Дэндэв. XX зууны монголын түүхийн эх сурвалж (Автономит Монгол Улсын үеийн онцлог баримт бичгүүд)	1
36	И.Майский. Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр)	4
37	М.И.Боголепов, М.Н.Соболев. Орос, монголын худалдааны найруулал	1
38	Архивын баримтууд	188
	Нийт	887

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ҮНЭТ ЗҮЙЛС, УЛАМЖЛАЛ (XIII-XX зууны эхэн, эзэн хаант засгийн үе)

4.1. Монгол Улсын төрийн албаны үнэт зүйлс

Судлагдахуунд хамаарах үе. Захиргааны шинжлэх ухааны суурийг тавигчдын нэг В.Вильсон аливаа улсын төрийн захиргаа, төрийн албаны хөгжлийг үечлэн авч үзэхдээ “Тэдгээрийн **анхных** нь хэмжээгүй эрхт засаг баригч-эзэд, хэмжээгүй эрхт дэглэмдээ нийцэж тохирсон захиргааны тогтолцоотой байсан үе” (The first of these periods is that of absolute rulers, and of an administrative system adapted to absolute rule) (Wilson, 1887, p. 204) хэмээн тодорхойлсон билээ. Тэгэхээр энэ үе нь Монгол Улсын тухайд эзэн Чингис хааны үеэс аваад БНМАУ-ын анхдугаар Үндсэн хууль (1924 он) батлагдахын өмнөхөн хүртэл Улсаа тэргүүлж байсан Богд Жавзандамба хутагт хааны таалал төгссөн үеийг хамарч байгаа юм². Энэ үеийн Монгол Улсын төрийн албаны үнэт зүйл, уламжлалыг судлан тодруулж гаргах явдал судалгааны багийн үндсэн зорилт билээ. Энэ хэсэгт, судлагдан буй үеийн Монгол Улсын төрийн албаны үнэт зүйлсийг тодруулан гаргахын тулд ер нь “үнэт зүйл” гэх ойлголтын талаар орчин үеийн судлаачид хэрхэн ямар үзэл бодолтой байдгийг тоймлон үзэж онолын баримжаа болгохын хамт чухам тодорхой судлагдахууныхаа орон, цагт орж, тэр үеийн үг хэллэгийг ойлгохыг оролдож, онцлог зүйлсийг гаргахыг хичээсэн болно.

Бусад судлаачид ба үнэт зүйлийг тодорхойлох гэвэл. Сүүлчийн гурван арван жилд л гэхэд төрийн алба, захиргааны удирдлагад үнэт зүйлийн хүчин зүйлийг харгалзан үзэх талаар Харвардын Их сургуулийн профессор Марк Моор “Australian Journal of Public Administration” сэтгүүлд “Public value as the focus of strategy” хэмээх өгүүлээ бичсэн нь орчин үеийн олон түмэн (төр)-ий үнэт зүйлийн онол (The Theory of Public value)-ын хөгжилд шинэ түлхэц өгсөн гэдэг. Түүний үзэл санааг эдүгээ Meynhardt, T, Van der Wal. Z нарын зэрэг эрдэмтэд хөгжүүлсээр байна. (Meynhardt, 2009, pp. 192-219), (Van der Wal. Z., 2016). Манай судлаачид, тухайлбал, профессор Ш.Түдэв, профессор Ч.Санжмятав, доктор Б.Хэрлэн нар эрдэмтэн Шцварцын аргачлалаар монголчуудын үнэт зүйлсийг судалж бүтээлээ олны хүртээл болгоод байна. (Б.Хэрлэн, Ш.Түдэв, Ч.Санжмятав, 2017)

Ерөнхийдөө тэдгээрийн үзэл баримтлал нь тухайн байгууллага, үйлдвэр, аж ахуйн газарт ажиллагчид үнэт зүйлийг хамтран бүтээж, улмаар түүнийхээ

² Тус Үндсэн хуульд: “Бидний ардын эрхтэй хэмжээт цаазат улсыг тэргүүлж байсан Богд Жавзандамба хутагт хаан Олноо өргөгдсөний арван дөрөвдүгээр он дөрвөн сарын арван долооны өдөр нэгэнт таалал төгссөн...” гэжээ.

хувь эзэмшигчид, үр нөлөө ашгийг хүртэгсэд байснаар улсын салбарын менежментийн ажил хэрэгч, овсгоотой байдлыг дээшлүүлж, улмаар нийт нийгмийн хөгжилд, олон түмний төлөөх буянт үйлсэд эерэг нөлөө үзүүлнэ гэж үздэг ч үнэт зүйлийн асуудлыг тухайлсан улс, төрийн албаны түвшинд авч үзээгүй гэж хэлэхэд болох юм. Харин үнэт зүйлийн категорийг хийсвэр сэтгэлгээний түвшинд боломжийн хэмжээнд тодорхойлох оролдлогууд хийсэн нь сайшаалтай юм. Гэвч үнэт зүйлд ягшмал, нэг товч тодорхойлолт өгнө гэдэг хэцүү ажил аж. Тэр бүү хэл, барууны улсуудад “Үнэт зүйлийн онол” гэж гарч ирэхэд түлхүүр үг нь болсон *valere* (value) гэх ойлголт нийгэм-улс төрийн хэллэгт бүр анх, эртний, эхийн эрхт ёсны үетэй нь харьцуулахад ч юм уу, хөөрхийлөлтэй, дорой, доромж байдалд орсон эмэгтэйчүүдийг нийгмийн амьдралд оролцоот ач холбогдолтой, нэр хүндтэй идэвхтэй байгаач (*be worth*) гэсэн үзлийг тээж орж ирснийг нь бодолцвол уг үгийг монгол хэлээр “үнэт зүйл” гэж хэлэх нь яг оносон үг гэхэд хэцүү. Хэцүү учраас ч зарим судлаачид “үнэлэмж”, “эрхэмлэл”, эрхэм чанар” гэх мэтээр өөр хувилбар үг хэрэглэсэн нь байдаг. Амьдрал дээр манай монголчуудын дотор үнэт зүйл гэдгийн дор хөөрөг, гаанснаас авахуулаад материаллаг эд юмсыг ойлгож төөрөгдөх нь ч цөөнгүй байдаг.

Ямар ч гэсэн, судлагдан буй үед холбогдох сурвалж бичгүүдэд текстийн шинжилгээ хийж үзэхэд итгэл, үнэмшил зэрэг субъектив шинжтэй үзэл санааны зүйлсийг үнэт зүйл, төрийн албаны үнэт зүйл гэхчлэнгээр илэрхийлсэн үг, өгүүлбэр, хэллэг огт таарсангүй. Харин “үнэт зүйл” гэж үзэж болохоор ойлголтыг “эрэлхэг”, “эрдэм”, “эрдэмт”, “эрдэнэ”, “эрэмгий”, “эрмэлзэх”, “эрмэлзлэл”, “эрхэм”, “эрхэмлэл” гэхчлэнгийн “эр” язгууртай олон үг, “...Жүрхэн үрхэн овог, Хабул эрхийдээ эрчимтэй... хүчит бөх, эрдэмт эрсийг ялгаж хөвгүүндээ өгсөн.” /МНТ.139-р текст/ гэхчлэнгийн илэрхийлэл давамгайл байсан баримт элбэг байна (Үүнтэй холбогдуулж цуглуулсан баримт бичгээс дэлгэрүүлж харах).

Эрхэм улс, төр, элгэн олон, эх орон, эрх чөлөө, эрхт ёсныхоо төлөө энэ үеийн эрчүүдэд байвал зохих итгэл, зориг, эзэмшвэл зохих эрдэм чадлын талаарх цогц ойлголт, зарчмуудыг товчхоноор илэрхийлбэл, **эрэист үзэл**³ гэвэл зохилтой. “Төрт улс бүхэн хүчирхийллээр бий болдог” гэж Троцкий тухайн үедээ Брест-Литовскт хэлж байжээ. Энэ бол бодит үнэн юм. Хэрэв хүч хэрэглэх нь төрийн эрх тогтоох нэг арга гэж танигдаагүй тийм нийгмийн тогтолцоонд оршин байсан бол тэнд төрт улс гэдэг ухагдахуун байхгүй, харин анархи буюу эмх журамгүй байдал жинхэнэ утгаараа бий болох байсан” (Вебер, 2018, хууд. 18) хэмээн М.Веберийн хийсэн дүгнэлтийг бидний судлан буй үеийн нөхцөлд холбогдуулан авч үзвэл, тухайн үеийн хүч, хүчирхийллийн бодит шалгуур, түүнийг аван явагч эр хүний, эр цэргийн эзэмшвэл зохих **эрдэм чадал**, итгэл үнэмшил, зориг, биеийн хүчний ач холбогдлыг эрх биш

³ Бидний энд хэрэглэсэн эрэист үзэл, эрээзмийг баруунд тодорхой цаг үед гарч ирсэн маскулинист (*masculinism*) үзэлтэй ойролцоо гэж ойлговол зохино. Я.Д



хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм. Иймээс, энэ үеийн сурвалж бичгүүдэд тийм итгэл зориггүй, эрдэм чадал, зориг тэнхээгүй хүнийг эм хүнтэй ижилтгэн доромж (доогуур) зэрэгт үзэж байсан нь орчин үеийн утгаар ойлгогдох феминист үзлийг эсэргүүцсэндээ биш, гагцхүү эрхэмжийн зүйлээ тодотгох гэснийх ажгуу. Үнэндээ ч тэр үеийн монгол хүний үнэлэмжээр юуг эрхэмж, юуг доромж хэмээн ялган үзэж байсныг “Монголын нууц товчоо” дахь “Жирэмсэн эмийн шээх газраас хол яваагүй, жижиг тугалын бэлчих газраас гарч үзээгүй, эм Таян зүрх алдаж энэ үгийг хэлжээ”/МНТ-194/, “Хүчүлэг хөвүүн чиний хүчирхэх бардам их боловч хүрэлцэн алалдах цагт хүнээс урьд шантрах биз. Тэр их омгоо тэрс дайсанд гаргаасай”/ МНТ-189/, “...Хар нохой муу ёроор хуцах болов. Хатан Гүрбэсү хамаг хэргийг мэдэх болов. Хан Таян чи халшрах зөөлөн хүн байна.... Ан гөрөө хийхээс өөр мэдэх эрдэм чадалгүй ажээ” гэх буюу эсвэл, Жамуха-ын “... Атаат эмийн үгээр андаас салаад алжаан зовов би.”...илүү дутуу үгтэй их домч эхнэртэй ийм байсан учраас Тэнгэр эцгээс заяатай Тэмүжин чамд дийлдэв би” \МНТ:201\” гэхчлэнгийн хэллэгээр илэрч байна. Харин эрхэмж зэрэгт “эрдэм ухаан”-тай, “эрхийдээ эрчимтэй”, “шил сайтай” зэрэг хүмүүсийг оруулж байсан аж.

Энэ бүхнээс эргэцүүлж үзвэл, энд бидний сонирхон авч үзэж буй үед “**эрхэмж**” гэх үг өнөөгийн “**value**” гэх ойлголтыг илүү илэрхийлж байсан байна. Цаашид ч тийм байх бололтой.

Эрхэмж гэдэг нь олон түмний сэтгэлийг эзэмдэн цагийг элээж, ноёлох хүчийг олсон итгэл бөгөөд хүний болон хүй олны үйл ажиллагааны өдөр тутмын болон алсын чигийг зааж тэдгээрээс өөр хоорондоо болон байгаль, нийгмийн бусад хүрээнд харилцах практик харилцааны хэм хэмжээг тохируулан тодорхой болгож, харьцангуй тогтвортой баримтлагдах зарчим болж байдаг байна. Ийнхүү тодорхой хэмжээний норматив шинжийг агуулж байдгийнхаа улмаас эрхэмж нь зарим тохиолдолд хуультай эн зэрэгцэж, зарим тохиолдолд түүнийг давах хэмжээнд хүрч болох ч ихэнхдээ түүнтэй хоршиж хэрэглэгддэг зүйл юм.

Ингэж ойлгогдох эрхэмж буюу үнэт зүйлийг судлагдан буй үеийн төрийн албаны түвшинд авч үзвэл, түүнийг хэд хэдэн төрөлд хувааж үзэж болохоор байгаа нь бодит баримтаас харагдаж байна. Үүнд:

Нэгдүгээрт, улс төрийн үнэт зүйл буюу эрхэмж. Энэ нь аливаа хүн бүр эхнээсээ улс төрийн харилцаанд орж улс хэмээх бүхлийн бүрэлдэхүүн хэсэг болох гэсэн байгалиас заяасан үндсэн өгөгдөлтэй байдгаар тайлбарлагдана. Үүнийг их Аристотель: “хүмүүс бүр анхнаасаа улс төрийн амьтан бөгөөд үүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө байнга эрмэлзэн тэмцэж ирсэн” гэдгийг тэмдэглэхийн хамт улс төрийн зохион байгуулалтанд орох гэсэн хүслийг нь удирдан зохион байгуулж гүйцэлдүүлж өгсөн хүн л хамгийн буянт сайн үйлстэн байх болно гэж дүгнэсэн байдаг.” (Aristotle, 1946, p. 1253a)

Монголчуудын хувьд тэр ариун эрхэмжийг нь гүйцэлдүүлж улс байгуулахад оройлон хошуучилсан буянт үйлстэн нь эзэн Чингис хаан юм. Энэ хүртэл монгол

угсааны олон овог, аймгууд өөр өөрсдийн “жалга дов”-ны явцуу эрхэмж, үнэт зүйлсийн улмаас өөр хоорондоо сөргөцөлдөн “орондоо унтах завгүй олзлон булаалдаж” “хөнжилдөөн унтах завгүй хөнөөлдөн тэмцэж байсан” /МНТ-254/ улс байгуулах болон өмнөх өмнөх үеийн баримт сэлт, төдийгүй эрдэмт лам зава Дамдин мэтийн тулхтай судлаачдаас:

“Эрт цаг дор Монголын овог, аймаг нугууд
Эрхшээсэн нэгэн хаан нийт дор үгүй бөгөөд
Эсгий туургатан нүүдэлчин малчид олонх нь байсан ба
Эртнээс харилцан амраглан, дайсагналцах ээлжлэх хийгээд
Эгнэгт магадлал үгүй хоосон газар нутгаар хэрэн оршиж

Элэгсэн заримууд бээр Уйгар Монголчууд лугаа өмөг нэгдэн...” (Зава Дамдин, 2007) гэхчлэнгээр дүгнэн тодорхойлсон бодит дүгнэлтүүд судалгааны хүрээнд эмхэтгэсэн “бичиг баримтын багц”-д багтаж ороод байгаа юм.

Улс, түүний утга агуулгыг тодорхойлон ойлгоход **төрт ёс** буюу **улс төрхт төлөв байдал (Statehood)** хэмээх ойлголт чухал ач холбогдолтой бөгөөд үүнгүйгээр үе үеийн төрийн албаны улс төрийн эрхэмжийн асуудлыг авч үзэх боломжгүй юм. Чингис хааны зарлиг, сургаалиас харахад тэр үед “**бүрэн улс**” гэх ойлголтонд улс төрхт төлөв байдлын элементүүдийг багтаан ойлгож, тэдгээрийг эрхэмийн дээд эрхэмжийн зэрэгт үзэж байсан байна. Түүний:

“Алд бие минү алжааваас алжаатугай
Аху төр минү бүү алдартугай
Бүтэн бие минү зовбоос зовтугай

Бүрэн улс минү бүү сандартугай” (Ц.Нацагдорж, 2006, хууд. 265) гэсэн сургаал нь бүхэл, бүтэн, бүрэн зүйлийн тухай өгүүлж буй нь илт аж.

Чингис хааны үеэс уламжилж ирсэн “Бүрэн улс”-ын тухай монголчуудын ойлголт, сэтгэлгээ нь эдүгээ дэлхий дахины хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж олон улсын эрхзүйн баримт бичгүүдэд нэгэнт тусгалаа олсон “statehood”⁴ гэх нэр томъёоны агуулгатай үндсэндээ тохирно. Эдүгээ цагийн Statehood гэх нэр томъёо нь улс төрхөө олж нэгэн бүхэл, бүрэн, бүтэн болж чадсан улс төрийн биетийг: а\“нутаг дэвсгэр” \territory\, б\“ард иргэд” \population\, в\“бүрэн эрхт байдал” \sovereignty\, г\“төр засаг”\government\ гэсэн аливаа улсын гол атрибут шинжүүдийг цогцод нь багтаасан ойлголт юм. Энд задлан харуулсан улс төрийн үнэт зүйл, эрхэмжийн төлөө үнэнч зүтгэсэн хүмүүсийг эзэн Чингисийн зүгээс хэрхэн үнэлж шагнаж хариуцлагатай албанд томилж байсан олон баримт сэлт байгаагаас энд онцгойлон дараах баримтуудыг эшлэл болгон энэ тайланд оруулж байна. Үүнд:

⁴ Англи хэлний энэ үг нь “государственность \орос\,...” үгтэй нийцдэг. Үүнийг молхи бичээч агуулга тааллыг нь гаргахын тулд “улс төрхт төлөв байдал” гэж сунжруу болгон илэрхийлсэн удаа бий. Ямар ч гэсэн “төр ёс” гэх манай уламжлалт ойлголтын утга, орчин үед шинэ утга тээх болсон “statehood” гэх ойлголтын утга хоёр ихээхэн зөрүүтэй юм.



Түүнээс Чингис хаан дүү нар хийгээд түшмэддээ улс иргэнийг хувааж өгрүүн, хоёрдугаар дүү Хасарт Хорчин, Лусчин, Мянган тэргүүтэн улс, гутгаар дүү Бэлэгдэйд Омой Шүүсэнгэ тэргүүтэн улс, дөтгөөр дүү Хачигунд Оннигуд, Хистэй, Балчудай тэргүүтэн улс, тавдугаар дүү Өчигэнд Хэрэйд, Мүн тэргүүтэн улсыг өгөөд цөм ван цол өргөвэй. Бэгтэр өчүүхэндээ үргүй өнгөрлөө. Бас есөн өрлөг тэргүүтэн их бага түшмэддээ хүч өгсөн их багын ялгалаар мужийн ноён, хэдэн түмэн ба хэдэн мянган хийгээд хэдэн зууны ноён болгон хишиг хүртээвэй. Гагц анх учирсан нөхрийн дээд Хүлэг Боорчи-д юухан бээр эс өгөөд, тэр үдэш Бэчин нэрт хөтчөө Боорчийг тэнсүүлэхээр зарсанд, Бэчин Боорчийн гэрийн гадна эчиж чагнаваас, Боорчийн Төгөлдөр гоо нэрт гэргий нь өгүүллүүн:

“Бүтэхийн урьд чи учирч

Бүгд улсыг хураалцлаа.

Бүрэн их төрийг нь хашиж

Бүхнээс илүү хүчийг өгсөн бөгөөтөл энэ мэт их хишигт чи эс хүртвэй” /Би тодотгов-Я.Д/”

хэмээсэнд Боорчи өгүүллүүн: “Ер эм хүний жолоо богино, санаа нь цухал эзний алтан оосор бат болохул надад олз, эр чинь би амьд бөгөөс чамд олз” хэмээхүй тэргүүтэн олон сайхан үгсийг Бэчин сонсож ирээд айлтгасанд, Чингис хаан манагар нь олон түшмэдийг цуглуулж, Боорчийн сайн эрдмийг олонход сайшаагаад, бас Мухулайн эрдмийг сайшааж бүрүүн. Мухулай Боорчи хоёрт нэжгээд мужийг эзлүүлж, баруун зүүн түмэн шадар цэргээ захируулж бүрүүн, зарлиг болруун: “Би урьд Хасарын харвадал, Бэлэгдэйн бөхөөр бүхүй улсыг эрхэндээ оруулаад чадмуй за хэмээн санасан билээ. Эдүгээ та хоёрын зүтгэсэн нь маш их, би бээр та нарыг тэрэгний арал, биеийн мөр мэт итгэмүй. Тан *(та нар)* бээр язгуурын сэтгэлээс бүү алгасагтун” хэмээлээ [Рашпунцаг, 2006, хуудсд. 51-52].

Чингис хаан [Мэнлигт] түүнд Өүлэн эхээ өгсөн бөгөөд тэр Чингис хаантай эн зэрэгцэн түүний баруун гар талд цэргийн бүх ноёдын дээд талд нь суудалтай байв. Тэр Хөхөчү хөвүүнтэй байсан бөгөөд түүний нь монголчууд Тэб Тэнгэр гэдэг байв.

Түүний заншил нь гэвэл далдыг мэдэж, болж болох бүх үйл явдлыг тааварлан хэлдэг байв. Тэр “... Тэнгэр надтай ярьж байна...” “... би тэнгэрт бараалхаж байна...” гэх мэт үг хэлдэг. Тэр Чингис хааныд орж “... Чи тэнгэрээс заяасан ёсоор Ертөнцийн эзэн байх ёстой...” гэж үргэлж хэлдэг байв. Чингис хаан гэдэг өргөмжилсөн нэрийг өгсөн байна. “... Тэнгэрийн зарлигаар чиний нэр тийм л байх ёстой...” гэж хэлсэн гэнэ билээ. Монголоор бол “чин” гэдэг нь “бат бэх” гэсэн үг, Чингис гэдэг энэ үг нь бас л “бат бэх” гэсэн үг боловч тэдгээр нь энэ цолоо эзэнтэн нь үнэхээр туйлын их болохоос нааш түүнд өгдөггүй байв. Монгол хэлээр Чингис гэдэг өргөмжилсөн нэр нь мөн тийм утгатай боловч түүнээс бүр их бөгөөд сүрлэг байдал тусгагдах утгатай юм. Энэ нь олон тоонд байгаа түүнийг ерөнхийлөн хэлбэл Персийн шахан шах буюу ханы хаан гэсэнтэй адил болох жишээтэй юм. Тэб Тэнгэр нь өвлийн жин хүйтэнд Орхон Хэрлэнгийн нутгийн хамгийн хүйтэн газрын мөсөн дээр чармай нүцгэн суудаг дадалтай болжээ. Түүний илчинд хөлдсөн ус нь хайлан уур савсаж байдаг гэнэ. Монголын эгэл жирийн хүмүүс, зарим нэгэн бие хүн ч тэр цагаан морь хөлөглөн тэнгэрт гардаг гэж ярьдаг, түүний нь нийтээрээ мэддэг болжээ. Энэ бүхэн нь жирийн хүмүүсийн үнэнд үл нийцэх цуу үгс болох нь мэдээж боловч тэр хүмүүсийг хуурах арга мэддэг бололтой. Чингис хаантай тэр шазуурхан ярьдаг боловч зарим үг яриа нь Чингис хааны сэтгэлийг амраах мөн ч түүнд дэмжлэг үзүүлэх зэргээр нөлөөлдөг болохоор түүний санаанд нийлдэг байв. Яваандаа Тэб Тэнгэр илүү юм чалчих, юм бүхэнд оролцох болж, дээрэлхэх, яршиг болох нь их болсон учир Чингис хаан бүрэн саруул ухаанаараа юмыг нэвт шинжих чадалтай учир тэр бол худалч хууран мэхлэгч хүн болохыг нь ойлгожээ [Рашид ад дин, 2002, хууд. 124].

Бүрэн улсын тухай энэхүү улс төрийн үнэт зүйл, эрхэмж үзэл бүр хожуу Богд хааны үед бас тодоор илэрч байсан нь түүхэн баримтуудаар нотлогдож байна.

Цагаагчин гахай жилийн хувьсгалаар бүрэн улсаа сэргээн байгуулахыг зоригчид чухам л түүнийг улс төрийн эрхэмж болгон зүтгэсэн байна. Иймээс ч “өбэсүбэн улс болж”, түүний бүтэн байдлыг бүрдүүлж, улс төрхт төлөв байдал (statehood)-ыг төлөвшүүлэхийн тулд аумар зүгийн дэлхий дахины орон газрыг уул эзэн нь хураан авч бүрэн бүтэн болгон батлах”, б\“монгол овгийн олон аймаг бүгдээр нийлж”, өөрөөр хэлбэл, ард иргэдээ “монголын бүх найрлын хүй” болгон хураах, в\бүрэн эрхт байдлаа сэргээж “өөрийнхөө хэргийн эрхээн бусдаар эрхлүүлэхгүй” болох, г\энэ бүхнийг гүйцэлдүүлэхийн тулд шинэ, “тулгар төр тогтоох” явдлыг чухалчлан ажиллаж эхэлсэн байдаг. Энэ тухайд, “Манай монголчууд яахин хүмүүжвээс сайн болохыг заан сургахыг хүсэж Богд гэгээнтнээ айлтгасан хэрэг, буулгасан лүндэнг сийрүүлж улам улмаар явуулж гүйцэтгүүлэх зэрэг учир олон монгол чуулганы дарга нарын зэрэг газруудад явуулан тушаасан эх” зэрэг түүхэн баримт бичгүүдээс харж болно (МУУТА. ХА-2, Д-1, ХН-73. Б.1, 2015).

Улс төрийн үнэт зүйлсийн сэргөлдөөн. Улс төрийн хүрээний үнэт зүйл, эрхэмж нь өнгөц харвал харьцангуй цөөн зүйлээр хэмжигдэх нэлээд тогтвортой зарчимлаг үзэл санаа, итгэл үнэмшил мэт боловч хэрэг дээрээ туйлын эмзэг, өчүүхэн зүйлээс ч өдөөгдөн “том хэрэг” болж болох зүйл гэдгийг Тэмүүжин, Жамуха хоорондын, Тэмүүжин, Хөхчү бөө хоёрын харилцаанаас харж болно. Улс төрийн үнэт зүйлээ үгүй хийх үү, үлдээж авч хоцрох уу гэдэг ширүүн сэргөлдөөнийг харуулсан баримтын нэг бол Бээжингийн зүгээс Богд хааны үзэлд сэргүүлэн тавьж байсан дараах: “... Бээжингийн Төвд, Монголыг нэгтгэх хурлаас эдүгээ Манж, Хятад, Монгол, Хотон, баруун зуу таван төрөл бүгдээр нэгэн гэр болсонд бүх улс үл баярлах нь үгүй...”, “...Эрхэм ламын санаа амаргүйг үнэхээрийн улсын хүн бүгдээр мэдмүй... Эдүгээ таван төрлийг нийлүүлэн шинэ төр байгуулахад манай Их ерөнхийлөн захирах сайд Эрхэм лам лугаа нэгэн биед болбоос гар хөл мэт, нэгэн гэрт болбоос ах дүү мэт бөгөөд ... жаргал зовлонг хамт хүлээхийн тул ... бөгөөтөл юунд эрхгүй бусдыг зүдүүлэн хамааргаж эзний эрхийг алдагдахад хүргүүлэх билээ...” гэсэн баримт, манай зүгээс үүний эсрэг баримталж байсан үнэт зүйл, зарчмын байр суурь, өөрийн эрхэмжийг харуулсан доорх: “... Монгол хүн хятадын суртал өөр, шашин өөр, үг хэл, бичиг үсэг цөм тус тусдаан нэвтрэхгүй, нэг нь тэнгэрийн оёдолд, нэг нь газрын зовхист буй агаад хоёулаа харилцан гүйцэхгүй болой Монгол хүмүүс ... Хятад иргэн улс лугаа нэгэн гэрт хамт сууваас үнэхээрийн харилцан өө сэв өдөөгдөж ухасхийн гарахад хүргүүлэх болуужин хэмээмүй. Одоо зүй нь харилцан найртай улс боллоцож тус тусдаа улсаа хамгаалан бүрэн бүтэн болгож найртай ёсыг журамласугай” байр суурь, баримт гэрчилнэ (Л.Дэндэв, 2015, хууд. 38). Бас улс төрийн үнэт зүйлсийн сэргөлдөөнд холбогдох нэгэн чухал баримт бол манай талаас Гурван улсын хэлэлцээрт *Монголын талыг*

төлөөлөн оролцож байсан, Бүрэн эрхт элчин бөгөөд ДЯЯ-ны сайд, билигт гүн Да Лам Дашжавын хэлсэн үгэнд буй: "Бидний Монголчууд шашин үндэс, хэв суртал, газар орноо бүрэн бүтэн болгохын тулд мөнөөхөн Чин улсаас салан тусгаар **УЛС** болж, **ТӨР** байгуулан манай Монголын Шарын шашны эзэн Жавзандамба лам юугаан бүгдээр өргөмжлөн Монгол Улсын эзэн хааны сууринд залаад өөртөө тогтносон улс болж нэгэнт 4 он болсон ... Хятадын бүрэн эрх барих тусгай элчингийн бичсэн ёсоор Манай улс ба Хаан эзний цолыг хасах явдлыг зөвшөөрөн хүлээж хэрхэвч ядахгүй, тэр ч байтугай хэлэлцэж ч огт чадахгүй ..." гэх байр суурь яриангүй мөн юм [ТТА, Ф.А-4-д 1, х/н38].

Улс төрийн үнэт зүйл нь угтаа эмзэг нандин зүйл учраас л улс төрийн хүрээнийхний хувьд тэрхүү "эрхэмж"-дээ үнэнч тууштай байхаа илэрхийлэн амь, насаараа андгайлан **улс төрийн тангараг**, андгай өргөх ёсон эрт гарч үүнтэй холбоотой баримт материал Тэмүүжин-Чингисээс эхлээд Богд Жавзандамба хутагт хааны үед ч хангалттай баймуй. Үнэндээ ч улс төрийн харилцаанд үхлийн гэсгээл амсвал зохих хамгийн том нүгэл бол улс төрийн эрхэмжээ умартаж, түүнээс урван өөр, харь үнэт зүйлийг баримжаалан өргөсөн тангаргаа няцах явдал аж. Ийм гэсгээл энэ үед олон хүн амссаны дотор Чингист шадарлаж явсан Хөхчү бөө, Жамуха сэцэн нар орж буй нь сургамжтай юм.

Хоёрдугаарт, Хууль, эрх-зөвийн эрхэмж, дэг журам. Судлагдан буй үеийн хууль, эрх-зөвийн эрхэмж, тэдгээрийн эцсийн зорилго болох эмх цэгц, дэг журам тогтоох үзэл санаа бол цаашид бие даалган гүнзгийрүүлж судлах учиртай чухал судлагдахуун гэдэг нь тодорхой байна. Тэр тусмаа эдгээрийг төрийн албаны хүрээнд холбогдуулж авч үзэх нь нэн сонирхолтой ч нэлээд ярвигтай ажил ажээ. Энэ судалгааны хүрээнд хамрагдаж буй үед Монгол Улсын тухайд үндсэн хууль гэж байсангүй. Тэгэхээр үндсэн хуулийн үнэт зүйлийн тухай яриа огт байхгүй, тийм баримт материал ч гэж байхгүй нь тодорхой. Харин дэлхийн бусад улсын хөгжлийн эхэн хийгээд дунд үед түгээмэл байсан бурхан, **тэнгэрийн бошго (Divine right-англиар, Божественное право-оросоор) хууль**, эрх-зөвт байх тухай санаа манайд мөн л ноёрхож байсан нь судалгаагаар тогтоогдлоо. Тэнгэрийн таалал ямагт зөв байх санаа улс, төр, хүмүүний амьдралын бүх салбарт, түүний дотор улсын хаан хэн байх, уламжлан засаг хэн барих нь ард түмний сонгууль, хүсэл зоригоос үл хамааран гагцхүү дээд тэнгэрийн бошгоор болох тухай итгэл энэ үеийн хууль, эрх-зөвийн эрхэмж болж байжээ. Энэ нь тус үеийн сурвалж бичгүүд, ялангуяа "Монголын нууц товчоо", "Судрын чуулган", "Улаан хацарт", "Халх журам", "Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг" зэрэгт нэн тодорхой тусгагдсан байна. Улсын хаан, түүний төрөл, хиад боржигин овгийнхны гарвал угтаа дээд тэнгэрээс гаралтай болохыг илтгэсэн: "Шөнө бүр цэгээн шар хүмүүн гэрийн өрх, тотгын гэгээгээр орж, хэлэл (хэвлийг) минь билиж, гэгээн инү хэвэлд минь шингэх бүлгээ. Гараруун, наран сарны хилээр шар нохой мэт шарвалзан

гарах бүлгээ. Дэлэмэ яахин өгүүлэх, та (та нар). Түүгээр ухваас, тэмдэг инү тэнгэрийн хөвгүүд биз.

Хар тэргүүт хүмүүнд

Ханилган яахин өгүүлэх, та

Хамгийн хаад болбоос

Харцас тэнд ухах, ээ” хэмээн /МНТ-21-р текст/ бичвэр үүнийг тодорхой харуулж байна.

Улсын эзэн болох магадлалтай байсан Жамуха, Тэмүүжин хоёрын тухайд ч хэн нь хаан болох учиртайг зөгнөн хэлж буй Хорчи бөөгийн “... Заарин ирж нүдэнд үзүүлэв. Ухаагчин үнээ ирж, Жамухыг орчин явж, гэр тэргийг инү мөргөлөөд Жамухыг мөргөж, өрөөл эврээн хугарч ... Жамухын зүг ... шороо сацан сацан баймуй. Тэмүүжиний хойноос их тэргүүрээр ... айсруун:

“Тэнгэр газар зетэлдэж

Тэмүүжинийг улсын эзэн болтугай” хэмээн улс тээж авч айсуй хэмээн заарид нүдэнд үзүүлж надад заамуй” (Монголын нууц товчоо, 2019, хууд. 69) гэж хэлж байгаа үг ч нөгөө л Тэнгэрийн бошгын хүчийг илэрхийлж буй нь илт.

Тэнгэрийн нэр барих (өнөөгийн ардчилсан дэглэмийн үеийнх шиг ард түмний хүсэл зориг гэхгүй) тэнгэрийн бошго хуулийг эрхэмлэн үзэх итгэл, үнэмшил нь судлагдан буй үеийн манай эзэн хаадаас нийгмийн олон талт харилцааг зохицуулахаар соёрхсон хууль, эрхэмж, зарлиг, айлтгалууд төдийгүй төрийн тамганых нь үгэнд нэвт шингэсэн буй нь энэ хүрээнд эмхэлж цэгцэлсэн олон баримтуудаас тодорхой харагдаж байна. Тухайлбал,

а). Их Монгол Улсын их хаанаас уламжилсан гэх Гүег хааны тамганы: “*Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол Улсын далай хааны зарлиг ил болгон иргэн дор хүрвээс биширтүгэй, аюутугай*” гэсэн үг-үсэг, Богд Жавзандамба хааны төрийн тамганы:

“Шашин төрийг хослон баригч наран гэрэлт, Богд ханы тамга”

“Шашин маш тунгалаг, Төр маш бат” гэсэн үг, шашны алтан тамганых нь

“Шашныг мандуулах, амьтныг жаргуулагч олноо өргөгдсөн Монгол Улсын эзэн, шашин төрийг хослон баригч наран гэрэлт, түмэн наст Богд хаан” гэсэн үг-үсгэнд бүгдэд нь энэ санаа тээгдэж “*Мөнх тэнгэрийн хүчин дор*”, “*наран гэрэлт*”, “*Монгол Улсын эзэн, шашин төрийг хослон баригч наран гэрэлт, түмэн наст*” гэхчлэнгийн үг орсон байгааг Та харж байна.

б). Дээр нэгэнт тэмдэглэсэнчлэн, энэ үед хэдийгээр улс хэмээх улс төрийн биетийн цогц конституцийг тодорхойлсон үндсэн хууль байгаагүй ч улсыг удирдах бодит хэрэгцээ, ард олны амьдралын дэг жаяг, эмх цэгцтэй байх шаардлагын үүднээс хууль, эрхэмжүүд гарч байсан аж. Гэвч тэр бүхэнд, юуны түрүүнд улсын эзэн-тэргүүний байр суурийг бататгах, түүнд хамгийн ойр түшээ, түшмэл болж байсан цэрэг, санваартан, бичиг эрдмийн хүмүүс,



язгуур угсаатны эрх ашгийг эрхэмд үзэж байсан нь харагдана. “Арван буянт номын цагаан түүх”, “Улаан хацарт”, “Халх журам”, “Гурван хошууны журам”, “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” сэлтээс энэ талаар харж болно. Тухайлбал,

Дотоод, гадаад яам (*тушаал-хөр.*) ёс үл осолдохын тул хонжин, тайш, зайсан-тан тэргүүлэн бүгд яамтан (*тушаалтан-хөр.*) жаран нэгэн яамыг эндвээс, тэдний морийг ав.

Хуур, чэрби тэргүүтэн аливаа алтан мөнгөн савыг эвдвээс урьдчилан тунгаагаад тэмээ тэргүүтэй анз гурван ес автугай. Алдваас тэмээ тэргүүтэй нэг ес автугай. Алдсан хүнийг цагаан гэрийн хичээнгүй хэрэг-т явуул.

Модны зэргийн тахил тавигийн эдийг эвдвээс тэмээ тэргүүтэй нэг ес анз автугай. Гэрийн ноёдын анзыг хаан ба жонон автугай.

Хаан ба жонон андваас (*осолдвоос-хөр.*) ноёдын ёс мэдэгч түшмэл дагал-ын морьдыг гэрийн ноёд автугай (Арван буянт номын Цагаан түүх, 2006).

в) Судлагдан буй үеийн хууль, эрх-зөвийн эрхэмж-үнэт зүйлийн ач холбогдолтой өвөрмөц зүйл бас байна. Үүнийг хамгийн тодоор харуулж буй бичиг баримтаар эхлээд харуулъя.

Баримт: Монголын нууц товчооны 260-р текст:

“Жочи, Цагаадай, Өгөөдэй гурван хөвгүүд Өрүнгэчи балгасыг оруулж, гурвуул балгад, иргэн хуваалцаж, Чингис хаанаа хувь эс гаргажухуй. Эд гурван хөвүүдийг бууж ирвээс Чингис хаан ...хөвүүдийг чамадаж, гурван өдөр эс уулзуулав. Боорчи, Мухали, Шихи Хутугу гурав өчрүүн: “Өчин мэлзэн Сартуул иргэний Султаныг доройтуулж, балгад иргэнийг ану авав, бид. Хувааж автах Өрүнгэчи балгас, хуваалдаж авахун хөвүүд бүгд Чингис хааных буй. Тэнгэр газраа хүч нэмэгдэж, Сартуул иргэнийг өдий доройтуулсанд ба олон эр агт чинь баясч, махайж амуй. Хаан яахан ийн хилэгнэж амуй? Хөвгүүд буруугаан ухаж, айв зэ. Хойч юугаан суртугай. Хөвүүд авираа алгасуузай. Соёрхвоос уулзуулж болох уу?” хэмээн өчвөөс Чингис хаан залирч... гурван хөвүүдийг уулзуулж донгодруун:

Өтгөс үг орхидож

Хуучин үгс хадалж

Байсан газраа

Багтан алдтал

Магнайн хөлс

Арчин ядтал бадар хийж (хатуу зэмлэж)

Чамлах сүюгэр дууган бүхийд Хонхай хорчи ...Чингис хаанаа өчрүүн: “Бор шувуу буулианд сая орох мэт, хөвүүд сая өдий аялан, суран бүхийд хөвгүүдийг шантлан, энэ мэт яахан ийн донгодмуй? Хөвүүд айж, сэтгэлээ алгасуузай! Наран шингэхээс ургахуйд хүртэл дайн иргэн олон буй. Хаан бээр маньг, төвд ноходоо,

тухирч, илгээвээс, дайн иргэнийг бээр дарж ... алт мөнгө, агуурс таваар, иргэн оргон чамд авчирсугай! Аль иргэн хэмээвээс, энэ өрнө Багдад иргэний Халибай султан хэмээх буй хэмээмүй. Түүнд ба /бид/ аялсугай” хэмээн өчвөөс, хаан хугарч эд үгст залирч, Чингис хаан зөвшөөж... Өтэгэдэй Чормаханыг Багдад иргэнд, Халибай султанд аялуулав” гэсэн байна.

Үүнээс дараах эргэцүүлэл - санаа (**coment**) төрж буйг тэмдэглэж байна.

1. Энэ үед **өвгөдийн үгийг** үндэс, **хуучны үгийг** хууль болгодог нэгэн бичигдээгүй хэм хэмжээ хууль, эрхэмжийн хүрээнд үйлчилж байжээ. Энэ тухай МНТ-ны 78 дахь текстэнд бас бий.

2. Энэ үед Чингис хаан шиг суу зальтай, харизмын хүчтэй хүний хүч, хуучнн үгийн хуулийн хүч, өвгөдийн өв соёл, уламжлалын хүчтэй нийлчихээр эгэл ард байтугай эзэн хаан болох хан хөвүүдийг хүртэл байх газраа олж ядтал нь, дуслан урсах дух магнайн хөлсөө арчих сөхөөгүй болтол айлгаж тэвдүүлдэг хүчтэй байсныг харуулж байна. Ийм, өнө мөнхөд өчигдрийнхөөрөө (of the 'eternal yesterday,') байдаг эрх мэдлийн хүчийг, харьцангуй хожуу барууны орны эрдэмтэд, тухайлбал, М.Вебер анхааран тэмдэглэсэн байдаг (Weber, 1946, p. 78). Энэхүү уламжлалын хийгээд харизмын хоёр их хүчийг, орчин цагийн үндсэн хуулийн хийгээд олон түмний оролцооны их хоёр хүчтэй эвцэлдүүлж нийлүүлээд хэргэлчихдэг иргэний нийгэм эдүгээ бүрдчихвэл мөн сайхан аа.

3. Залуу үе нь өвгөд, ахмад, эцэг дээдсээсээ айх, хүндлэх мэдрэмжтэй, буруугаа хүлээх чадвартай, ахмад үе нь хойч үеэ зэмлэх, сургах, уучлах, урамшуулах, итгэх ухаан, туршлагатай байх нь сайхан ажээ.

г.) Тэнгэрийн бошго хуулийг баримтлах, Улсыг улсын эзнээр төлөөлүүлэн ойлгож түүнийг дээд тэнгэрээс соёрхолтой хэмээн үзэж хууль, эрх-зөвийн талаар онцгой эрх дархтай байх итгэл, үнэмшил, зарчим Богд хааны үед ч хэвээр байсан байна. Энэ нь:

“Жавзандамба лам болбоос эртний Мин улсын цаг, Их Юань улсын Тайзу хааны үр, Халхын Очирбат Түшээт сайн ханы гэр дор хувилгаан гарч бурхны шашныг дэлгэрүүлэн хамаг амьтныг тусалж халхын олон монголчуудыг тэргүүлэн авч манж монгол овогтныг найрамдуулан зохиож гайхамшиг явдлыг илэрхийлсэн учир дор манж хаанаас Жавзандамба ламыг умард зүгийн амьтны итгэл номын богд хэмээн өргөмжилж алтан тамга, алтан навчит өргөмжлөлийн зэрэг ... юм шагнаж лам эзэн нэгэн суурин дор заларсан ба багш шүтэж ихэд өргөмжилсөн анхны төрлийн Өндөр богдоос эхлэн төрөл тутам сайн билиг бэлэг лүгээ төгссөн...Жавзандамба лам дор үе үеийн хэргэлсэн олон зүйл ямба, цолын дээр аврал итгэл хамгийг айлдагч оройн чандмань очир дара хэмээн нэмэн өргөмжлөөдЖавзандамба ламыг хаанаас ахлуулж эрхэмлэн өргөмжлөгтүн.”; “Жавзандамба ламын лүндэнгээр явуулж буй журамлан шийтгүүлсэн аливаа хэргийг олон харьяат газар, нийтээр дагаж шийтгүүл....



Олон яам айлтгал үгүй зоргоор халж болохгүй. Зөрчвөөс Зарлигийг зөрчсөн ял хэлэлцэгтүн” гэсэн зүйлсээс харагдаж байна (Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг, 1995).

Гуравдугаарт, Эв нэгдэл, итгэл үнэмшил, эрдэм, соёлын хүрээний эрхэмж. Эзэн Чингис хаант их Монгол Улсын үеэс Богд хаант Монгол Улсын төрийн албаны хүрээнд үнэт зүйлийн зиндаанд эрхэмлэгдэж байсан нэгэн багц эрхэмж бол эв нэгдэл, итгэл үнэмшил, эрдэм, соёлын хүрээний асуудлыг хамарч байгаа юм. Үүнд, юуны өмнө МНТ-ны 19-р текстэнд тусгагдсан Алан гоо эхээс эв нэгдлийг эрхэмлэхийн учрыг ухааруулдаг таван мөсний сургаал холбогдоно. Тэнд: “Хаврын нэгэн өдөр таван хөвгүүнээ зэрэгцүүлэн суулгаж, нэжгээд мөсөд “хугаладхун” хэмээн өгөв. Нэжгээдийг юу байгуулахун, хугачиж оров. Бас таван мөсөд хамт цуглаж “хугаладхун” хэмээж өгөв. Тавуул таван цугтай мөсөд хүмүүлэлдэн барьж бидүүлж, хугалан ядав” гэсэн нь бий. Энэ хийгээд Сүбээдэй баатараас Хасар эзнээ хандан айлтгасан:

“Хүй элгэнээсээ хагацваас

Хөндлөн хүний идэш болом.

Өнөр хүн эвдэрвээс

Өөр хүний олз болом гэлээ

Хөдлөх бүгд олдох

Хүй элгэн үл олдох гэсэн сургаал (Саган Сэцэн, 2006, хуудсд. 63-64) бол тухайн үеийн төрийн албаны үнэт зүйл, эрхэмж байгаад зогсохгүй, эдүгээ ч нэгэн улсын төрийн албанд бүү хэл, энэхүү дэлхий дахины хэмжээнд ач холбогдолтойг АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Буш 2005 онд манай улсад айлчилж төр, засгийн өндөр албан тушаалтнууд, иргэд, олон нийтийн төлөөлөлтэй уулзсан уулзалт дээр багцалж боосон таван мөсний талаар онцгойлон дурдсанаар илэрнэ.

Энэ үеийн эрдмийг эрхэмлэх үзэл санааны хувирал бөөгийн зөнч эрдмээс эхлээд цэрэг эрийн эрдэм чадал, эгэл иргэний бичиг эрдмийг оролцуулсан өргөн хүрээтэй байгаа ч ерөөс “эрдэм”, “эрдэнэ” гээч ерөнхий ойлголтонд хамрах нэгэн эрхэмжийг бий болгосон нь үнэн байна. Энэхүү багц эрхэмжийн хүрээнд монголчуудын оюун санааны амьдралд нэвтэрч орсон шашны онол, номнол ялангуяа “гурван эрдэнэ”-ийн холбогдолтой материал, баримтууд нэгтгэгдсэн болно. Тэр бүхнийг энэ товч тайланд дэлгэрүүлж оруулах бололцоо хомс. Энэ үед холбогдох олон сурвалж бичгүүдэд улсыг засаж төрийн албыг тэгшитгэхэд “хааны ёс цааз хийгээд номын цааз ёсыг тэгш хослуулж, хамаг улс гүрний бүгдийн дээд багш” (Сажа бандида, Пагва лам гэх мэт) сэлтэй болсны ач тусыг өргөсөн баримт арвин байна.

Судлагдан буй үеийн энэ хүрээний үнэт зүйл, эрхэмж маш тогтвортой “тайван” байсан гэж хэлж болохгүйг Эрхэм судлаач зава Дамдины:

“Тэр үе дор тэнгэрийн хөвгүүн Өгөөдэй хаан бээр

Тэртээх Уйгар монголын шашин, төрийг сүйтгэгч
Тэрс Хиргисүүдийг газрын хязгаар лугаа хөөгөөд
Тэнэгэр Монгол нутгийн төв болсон Очирт суурь
Тэнцэш үгүй Эрдэнэ Зуугийн их сүмийг сэргээсэн бөгөөд
Тэнд үргэлж эргэл, мөргөл, тахилын ёсыг тогтоон
Тэнгэрлэг Уйгар Монгол үндэстний аймаг угсааг

Тэгш илэрхий магадтай өндөр сайн мөр дор оруулсан нь үзэгдэнэ” (Зава Дамдин, 2007, хууд. 44) гэсэн үгээс харж болно.

Дөрөвдүгээрт, Захиргаа, төрийн албаны хүрээний эрхэмж. Судлагдан буй үе бүхэлдээ, ялангуяа түүний эхэн ба дунд хэрд, төрийн эрх мэдлийг хуваарилах тухай үзэл санаа огт нэвтрээгүй байсан ч манай төрийн захиргааны салбарт цаашид үнэт зүйл, эрхэмж болон тогтсон зарчимлаг баримтлалуудын үр хөврөл гарч эхэлжээ. Үүний улмаас ч улс төр, эзэн хаад, улс төрийн эрх баригчдын хүрээнд “хувьсгал”-ын шинжтэй огцом өөрчлөлтүүд үе, үе гарч байсан байхад захиргаа, удирдлагын салбарт, түүний үүрэг, бүтцийн хүрээнд “энх тайван” ноёрхож үеэс үед, өнө удаан өвлөгдөн уламжилж ирсэн зүйл ихтэй аж. Үүний нэг нь Чингис богдын удам угсаа Монголын төрийн алба, захиргаанд үндсэндээ 1924 оныг дуустал тасралтгүй бие биеийг залгамжлан ажиллажээ. Гэтэл энэ хооронд улс төрийн олон өөрчлөлт гарч тэр бүү хэл, улсын эрх ч алдагдан өөр улсын эрхшээлд орж явсан үе байна. Захиргаан дахь энэ мэт тогтвортой уламжлалыг гайхахдаа Чингисийн удмын тайж Инжаннаши нэгэн багшаасаа: “Юань улсын Тайцзу үрсээ тайж болгон чадаад, Мин улсын Тайцзу юунд үрсээ тайж болгож чадмуй?” гэж асууснаа бичсэн байдаг (Инжаннаши, 2005, хууд. 62). Багшийн тайлбар нь: “Мин улсын Тайцзу хэмээгч тэргүүнд: эзнийхээ төрийг булаасан хүн, хоёрт, Монголын гэрийн хятад боолоос төрсөн боолын боол, гуравт, тойдын өвөрт хэвтсэн бузар хүүхэд болно. Юань улсын Тайцзу хэмээгч угаас алтан яст, тэнгэрийн үрс, хаадын үндэс, бадрангуй цагаан сүлд тэнгэрийн цагаан гэрлээс бүтсэн ...богд бөгөөтөл хэрхэн Чжау Хун-ү лүгээ үлитгэж болох буй?”/мөн тэнд/ гэжээ. Энэ бол мэдээж, тэнгэрийн бошго хуулийг баримтагчийн хариулт. Түүний хариултыг одоо цагийн ардын эрхт, ардчилсан дэглэмийн хүмүүн үл зөвшөөнө, тиймээс ч олон асуулт гарна, Инжаннаши ч асуусан. Гэвч тэр бүхний хариулт:” ...Өөрийн уг үндэсний түүх бичиг ба цэдэг судраа үл үзэн, урьдас дээдсээ, угсаа эшээ үл мэдэн, хүн бөгөөд үндсээ үл мэдэх нь адгуус буюу...” гэх үгээ л хэлэх болов уу. Энэ нь захиргаа, удирдлагын асуудалд түүхэн байр сууринаас ханд гэсэн утга буюу.

Тэдгээрийг энэ үеийн төрийн уламжлалын хэсэгт тусгайлан задалж авч үзэх тул энд илүү нурших юун. Эзэн Чингис хаанаас өөрөө зарлигдан эхлүүлж төрийн албанд үнэт зүйл болгон хэвшиж эдүгээ ч тодорхой түвшинд хөгжсөн хэлбэрээр хэрэглэгдсээр буй зүйлд холбогдох цөөн баримт оруулбал:

А) "...Чингис хаан ав буугаад Абжига Хөдөхэрээс хөдөлж, Халхын Орнугугийн Хэлтгий Хад бууж, тоогоо тоололдож, мянган тэнд мянгалж, мянганы ноён, зууны ноён, арваны ноён тэнд түшив. Чэрбинийг тэндхүү түшив. Додэй чэрби, Доголху чэрби, Өгэлэ чэрби, Толун чэрби, Бачуран Чэрби, Сүйхэтү чэрби эд зургаан чэрбинийг тэнд түшив. Мянган мянгалан, зуу зуулан, арван аравлан баржняан хэвтүүл, далан турхаг, хишигтэн тэнд ялгаж оруулахдаа, мянгадын зуутын ноёдын хөвгүүдийг, дүү нарыг үтү дүрийн хүмүүний хөвгүүдийг дүү нарыг оруулахдаа, **эрдэмтэн, бие, шил сайтыг ялгаж** оруулав. Тэнд Архай Хасарыг соёрхож "баатдыг ялгаж мянгалтугай! Хатгалдаан өдөр өмнө минь байж хатгалдтугай! Олон өдөр турхаг хишигтэн минү болтугай" хэмээн зарлиг болжээ. "Далан турхагийг Өгэлэ чэрби ахалж атугай. Хутус Халчанлугаа зетэлдэж ахлахтун". \МНТ-191\ хэмээжээ. Энэ баримтанд Монголын түшмэдийн тогтолцооны үүсэл, хөгжилд холбогдох тун тодорхой мэдээ занги агуулагдаж байгаагаас гадна төрийн захиргаан дахь "шаталсан удирдлага", төрийн албанд тодорхой шалгуураар шилж оруулах", Төрийн албан дахь "тушаал", "шийдвэр", "гүйцэтгэл"-ийн талаар олон зарчимлаг, зарчимлаг гэхээр тогтвортой хадгалагдах эрхэмжийн шинжтэй зүйлс байгааг тэмдэглэж байна.

Б) Тухайн үед улсын алба, улсын удирдлага, захиргааны хүрээнд ажиллах хүнд тавьдаг байсан эн тэргүүний зарчим, эрхэмжийн шалгуурын нэг нь үнэнч байдал байж. Хэнд, юунд үнэнч байх вэ гэхээр, ард түмний сонгож байгуулдаг тогтолцоо биш юм болохоороо эзэн ба улсад гэдэг нь тодорхой. "Хаанаа (эзнээ) хайрлах их ёсыг мэддэг", "үнэнч" хүнийг газар дээр нь шалгаад тэгтлээ итгэл хүлээлгэж эрхэмлэж байсныг илтгэх баримт олноос нэгийг онцолж оруулав, энд. Энэ нь: "МНТ-ны 197-р текстийн эхэн хэсэгт дурдсанчлан ...Увас мэргэдийн тэргүүлэгч Дайр-Үсүн өөрийн охин Хуланг Чингис хаанд үзүүлэхээр авчирч явтал монгол цэрэг саатуулж, Бааридайн ноён Наяад: "охины чинь бид хамт үзүүлье". Самуун цагт цэргүүд хэцүү, гурав хоног хүлээ гээд гурав хоногийн дараа түүнийг Чингис хаанд авч очжээ. Гурав хоног саатсаныг сонсоод "...Чингис хаан Наяа-г "Яахан түдээж ав (байв), чи" хэмээн маш хилэгнэж, "Хатан гуйяа мяраан асууж засаг болгоё" хэмээн асуун бүхийд Хулан хатан өгүүллүүн: " Наяа өгүүллээ. Чингис хааны их ноён буюу би. Бид охиныг чину хаанаа үзүүлье. Зуур цэргүүд самуурах самуурах хэмээн ятгалаа. Эдүгээ Наяа-гаас, бус цэргүүдэд учирваас самуунд түйдэхүйд орох бус уу. Ай, энэ Наяа-д учрах ману сайн болов. Эдүгээ Наяа-гаас, асуутал, Хаан соёрхвоос, тэнгэрийн заяагаар, эцэг эх төрүүлсэн марианаас асууваас ?" хэмээн өчжүхүй.

Наяа асуугдаруун (асуугдахдаа):

"...Хацар гоо охин хатан

Харгам сайн агт учирваас

Хааных хүү (хааных л) хэмээж амуй зэ, би

Үүнээс бус сэтгэл минь бөгөөс

Үхсү, би” хэмээжихүй.

Чингис Хулан хатны өчил зөвшөөж, мөн өдрөөр бөгөөд болгон соривоос” Хулан хатны өчил үнэн байсан тул Хулан хатныг ч “соёрхон таалж”, Наяа-г ч “**үнэн үгт ажгуу**” хэмээн “**Их үйлд түшсү**” хэмээн соёрхов” (Монголын нууц товчоо, 2019, хуудсд. 151-152)

Үнэхээр ч үнэнийг үнэт зүйл, эрхэмжийн түвшинд залсан Чингис хаан мөдхөн “Хаанаа хайрлах их ёсыг мэддэг гэж үгийг зөвшөөж нэгэн хэргийг тушаая гэснээ дурсаж Наяа төвийн түмнийг захирах ноён болтугай” гэж зарлигдсан билээ (Монголын нууц товчоо, хууд. 220).

В). Монголын төрийн захиргаанд баримталж байсан нэгэн чухал эрхэмж бол их, бага хамт олны хүрээнд “дэг журам”, “эмх цэгц”, “сахилга бат” буюу одоогийн нэр томъёогоор бол “шатлан захирагдах ёс” юм. Энэ нь Их Монгол Улс байгуулагдах үеэс өмнө хэвшин тогтсон байсан нь түүхэн сурвалжуудад тэмдэглэгдэн үлдсэн бөгөөд эдүгээ ч эрхэмлэгдсээр байна. Монголын нууц товчооны 28-39-р зүйлд энэ тухайд анх дурьдагдсаныг хүснэгтэнд сийрүүлбэл,

28. Дүйрэн [уулын] хяраас Түнхэлиг горхи уруу [нэгэн] бүлэг иргэн нүүж ирэв. Бодончар тэр иргэнд харцагаа орхин одож өдөр эсэгчилж [айраг цэгээ ууж] шөнө өвсөн эмбүүл гэртээ ирж хонох бөлгөө.

29. Тэд иргэн Бодончарын харцагыг гуйваас эс өгөв. Тэд иргэн Бодончарыг “Хэн, юун [хүн] бэ” хэмээн асуух үгүй. Бодончар тэд иргэнийг “юун иргэн” хэмээн асуулцах үгүй явцгаав.

30. Бугу Хатаги ах нь Бодончар Мухаг дүүгээ энэ Онон мөрөн рүү явлаа гэж эрж ирээд Түхэлэг горхи уруу нүүж ирсэн иргэдээс “тийм морьтой, тийм тийм [маягийн] хүн [үзэгдэв үү]” хэмээн сураглаваас

31. Тэд иргэн өгүүллрүүн: “Хүн, морь нь чиний сураглахтай адил буюу. [Тэр хүн] харцагатай буюу өдөр бүр манд ирж эсэгчилж одно. Шөнө [тэр] магад хаана хонох ажгуу? Баруун хойноос салхи салхилахад харцагаар бариулсан нугас, галуудын өд сөд нь цас бургинах мэт бутарч хийсэж ирнэ. Энд ойр буй за. Одоо ирэх цаг болов. Түр хүлээ” хэмээв.

32. Хоромхон атал Түнхэлиг горхи өөд нэгэн хүн айсуй буюу. Хүрч ирвээс Бодончар мөн ажгуу. Бугу Хатаги ах нь [дүүгээ] үзээд таньж дагуулж аваад Онон мөрөн өөд хатируулан зорчиж одов.

33. Бодончар Бугу Хатаги ахынхаа хойноос дагаж хатирч явах [зуур] өгүүллрүүн: “Ахаа ахаа! **Бие түрүүтэй, дээл захтай сайн**” хэмээв. Бугу Хатаги ах нь тэр үгийг нь юман тоонд эс бодов.

34. Бас мөн үгээ өгүүллээс ах нь [мөн] юман тоонд үл болгон хариуд нь үл дуугарав. Бодончар [жаахан] явж [байгаад] бас мөнхүү үгээ өгүүлэв. Тэр үгний [хариуд] ах нь өгүүллрүүн: “Түрүүнээс [хойш] дахин дахин ямар үг өгүүлнэ чи” гэв.

35. Тэндээс Бодончар өгүүллрүүн: “**Саяын Түнхэлэг горхиноо бүхий иргэн их бага, муу сайн, адаг түрүү үгүй [эн] сацуу буй. Хялбар иргэн буй. Бид тэднийг дагуульа хэмээв.**”

36. Тэндээс ах нь өгүүллрүүн: “За тийм бөгөөс гэртээ хүрч, ах дүү нар зөвлөлдөж тдэ иргэнийг дагуульа” гэлдээд

37. Гэртээ хүрч ирж ах дүү нартайгаа хэлэлцээд [буцаж] мордов. Мөн Бодончарыг хошууч [болгон] довтолгов.

38. Бодончар хошуу [болон] довтоолж [явах] дунд [нэгэн] жирэмсэн эмийг барьж “Чи юун хүн” хэмээн асуув. Тэр эм өгүүлрүүн: “Би Жарчиуд аданхан урианхай эмэгтэй” хэмээв.

39. Тэд иргэнийг ах, дүү тавуул дагуулж, адуу [мал] идээ [хүнс], ард боолыг [нь] эзэгнэн суух болов (Д.Цэрэнсодном, 2000, хуудсд. 34-35).

Энэ үйл явцын үр дүнд наад зах нь төр, түмний хэргийг захирах залах, ахлах даргалах, албадах аргадах, гардах чиглүүлэх, гамнах гарлагадах чиглэлээр Монголын захиргааны үүрэг-бүтэц, үйл ажиллагааны хүрээнд хэрэглэгдэж байсан, цаашид ч шинэлэг байдлаар хэрэглэж болохоор арвин баялаг баримт сэлт, өв түүх, сонин содон кейс дэлгэгдэж таарна. Ингэх нь, тухайлбал, “их эрдэмтэн М.Веберээс бюрократ онолын хүрээндээ дэвшүүлж тавьсан шатлан захирах ёсны тухай сургаал, “Монголын нууц товчоо”-нд “мунхаг” мулгуугаараа дуудуулсан Бодончирын “бие тэргүүтэй, дээл захтай сайн” (Монголын нууц товчоо) хэмээх сургаал хоёрт угтаа утга агуулгын ялгаа байхгүй ч хэн нь хэзээ, хаана, хэрхэн айлдав? гэдэг дээр анхдагчийн хийгээд ахуй соёлын ялгааг тодруулах талаасаа асар их ач холбогдолтой юм.” (Я.Долгоржав, 2020, хууд. 9)

Чингис хааны дээд өвөг Боржигин овгийн үндэслэгч Бодончарын үеийн энэхүү эрхэмж нь Их Монгол Улсын үед уламжлагдан өвлөгджээ. Судлан буй үеийн сүүлд холбогдох нэгэн баримтыг хураангуйлбал, Богд хаант Монгол Улсын анх байгуулсан таван яамдыг эрэмбэлж Дотоод яам угаас тус улсын дотор тэргүүлэгч ахмад яам мөн. Гагцхүү манай улс гадаад лугаа найрамдахыг эрхэмнэн гадаадын хэргийг чухал болгох тул Гадаадын яамыг дэд болготугай. Бас улсыг хамгаалах үндэс цэрэг буй тул Цэргийн яамыг гутгаарт болготугай. Сангийн яамыг дөтгөөрт болго, Шүүх таслах яамыг тавдугаарт болго (МУУТА. ТБА. ХА-3, Д-1, ХН-16, хуудас 2а-4а) хэмээсэн нь орчин үеийн төрийн албан дахь шатлан захирах тогтолцоог чанд мөрдөж байсан эрхэмжийг илэрхийлж буй болно.

4.2. Төрийн албаны хүрээлэнд уламжлагдаж ирсэн зохион байгуулалтын бүтэц

Төслийн судалгааны үр дүнд түүхэн эх сурвалжуудаас төрийн албаны хүрээлэнд уламжлагдаж ирсэн зохион байгуулалтын бүтэцтэй холбогдох 159 баримтыг түүвэрлэн цуглуулав. Эдгээр баримтад шинжилгээ хийж үзэхэд төрийн албаны хүрээлэнгийн үндсэн дараах институтийн үйл ажиллагааг тодруулах боломжийг олгосон байна.

1. Хэмжээгүй эрхтэй эзэн хааны хүрээлэн
2. Зөвлөх эрхтэй их хуралдай, улсын дээд, доод хурал

3. Гүйцэтгэх эрхтэй засгийн газар, яамд
4. Орон нутгийн засаг захиргааны нэгжүүд

1. Хааны хүрээлэн

Монголын нууц товчооны 126-зүйлд Чингис хааныг хан болгов хэмээн Хэрэйдийн Тоорил ханд Тахай, Сүхэхэй хоёрыг элч илгээв. Тоорил хан: “Тэмүжин хөвүүнийг минь хан болгох ай зөв. Монгол хан үгүй хэр байх, та нар.

Энэ эеэн бүү эвдэгтүн!

Эв зангиан бүү тайлагтун!

Эх захаан бүү тамтлагтун!” хэмээж илгээжүхүй (Монголын нууц товчоо, 2006, хуудсд. 70-72).

Тархай байдалтай байсан өвөг эцгийн байгуулсан ханлигийг сэргээсэн Тэмжүүжинг 1189 онд Хамаг Монголын ханд, тал нутгийн ханлигуудыг нэгтгэсэн дараа Их Монгол Улсын хаанд өргөмжилснөөр түүний угсааны хаанчлал эхлэв. Энэ үеэс улсын дээд эрх мэдэл нь хэмжээгүй эрхтэй эзэн хааны хүрээлэнд хадгалагдах болов. Энэ талаар их хаан Гүюгийн үед Монголын эзэнт гүрэнд ирсэн Ромын пап ламын элч Плано Карпинигийн тэмдэглэлээс үзэж болно. Үүнд:

Татарын эзэн хаан бусдыгаа захирах гайхам их эрх дархтай бөлгөө. Хааны зааж өгөөгүй нутагт хэн ч нутаглаж үл зоригломуй. Хаан бээр удирдагч жанжнуудаа, удирдагч жанжнууд нь түмтийн ноёдоо, түмтийн ноёд мянгатын ноёдоо, мянгатын ноёд зуутын ноёдоо, зуутын ноёд аравтын ноёдоо захиран нутаглах газрыг тус тус зааж өгмүй.

Бүх юмс эзэн хааных бөгөөд “миний юм” гэх буюу “тэрний юм” гэж хэлж зүрхлэх хүн ер байхгүй. Эд хөрөнгө, уналга ачлага тэр ч бүү хэл хүн хүртэл бүх юм эзэн хааны юм болдог бөгөөд энэ тухай саяхан хааны зарлиг ч гарсан гэдгийг мэдвэл зохилтой. Татар болон бусад иргэд удирдагч ноёдод хуваагдан захирагдах бөгөөд тэдгээр ноёд нь албат нараа мөн л энэ маягаар захирдаг бөлгөө (Карпини, 1988, хуудсд. 34-35) хэмээжээ.

Бидний судлан буй түүхэн урт хугацааны ихэнхэд Чингис хааны шууд угсааныхан буюу “Алтан ургийнхан”-нд улсын дээд эрх мэдэл энэ мэт хадгалагдаж байв. Лигдэн хутагт хаан 1634 онд нас барсны дараагаар Манж Чин улсын эрхшээлд орсон ч Чингисийн угсааныхан өөрсдийн эзэмшилдээ засаг ноёноор үргэлжлүүлэн ХХ зууны эхэн хагас хүртэл хэмжээгүй эрх дархтай байв.

2. Хуралдай, хурал

Түүхэн урт хугацааны туршид Монгол Улсын дээд эрх барих төрийн нэгэн өвөрмөц байгууламж нь Их Монгол Улсын үеийн “Их хуралдай”, Богд хаант Монгол Улсын үеийн “Улсын хурал” юм. Зөвлөх эрх бүхий эдгээр байгууламжийн эх суурийг баримтуудаас үзвэл Чингис хааны ургийнхны

“Их эе”-ээр Хамаг Монгол ханлигийн онц чухал хэргүүдийг хэлэлцэж байв. Жишээлбэл, Монголын нууц товчооны 154 дүгээр зүйлд тэмдэглэсэнээр “Их эе”-ээр хэлэлцсэн Татар иргэнийг цээрлүүлэх шийдвэрийг задруулсан Билгүдэйг дахин эелдээнд оруулахыг хориглож байв. Тал нутгийн монголчууд нэгэн захиргаанд орох болсноор энэхүү Их-эеийн хэмжээ нь өргөжиж алтан ургийнхнаас гадна улс байгуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн зүтгэлтнүүдээс бүрдсэн “Их хуралдай” болж өргөжив. Эрх хэмжээний хувьд шинэ хааныг өргөмжлөх, аливаа чухал улс ба цэргийн шийдвэрүүд Их хуралдайгаар заавал хэлэлцүүлэгдэж байв. Тухайлбал, Өгөдэй хааны үед болсон нэгэн хуралдайн тухай мэдээг иш татвал,

Хаан хятадын мужуудыг байлдан дагуулаад, морин жилд буцаж Талан-Даба /Далан даваа/-д ирээд хуралдай хуруулав. Энэ жил буюу хонин жилд тэр бээр бүх хөвүүд, төрөл төрөгсөд ба ноёдоо цуглуулж, яс хууль ба тогтоолыг дахин сонсгоно хэмээсэнд тэд бүгд л зарлиг ёсоор цугларахад бүгдэд нь янз бүрийн хишиг соёрхол хүртээсэн байна. Тэд бүтэн сар өдөр бүр заншил ёсоор өглөөнөөс одод түгэх хүртэл эелдэн найрласаар, сан хөмрөгтөө хуримтлуулсан бүх баялаг эрдэнэсийг цугларагсдад хаан тараан дуусгалаа. Найр цэнгээнийг дуусгаад, тэр бээр улс ба цэргийн чухал ажил хэргийг зохиоход анхаарлаа (Рашид ад дин, 2002, хуудсд. 36-37) хэмээжээ. Хуралдайн эрх хэмжээ багассан ч дараа дараагийн үед ноёдын чуулган, аймгийн чуулганы хэлбэрээр уламжлагдаж ирэв.

Энэхүү хуралдайн уламжлалыг Богд хаант Монгол Улс тухайн үеийн олон улсын жишигт нийцүүлж сэргээсэн байдаг. Энэ тухай баримтаас дурдвал, “улс төрийн ихээхэн хэргийг зөвлөлдөн хэлэлцэх Улсын дээд, доод хоёр хурал байгуулж Дээд хурлын гишүүд нь таван яамны тэргүүн, дэд сайдууд, Нийслэл Хүрээний эрдэнэ шанзудба, да лам нар, жич Хүрээн дор бүхий ван, гүнгүүд тусгай оролдсон тушаал буй үгүйг бодохгүй цөм Дээд хурал дор хэлэлцэх эрхтэй оролцох ба Доод хурлын гишүүд нь олон яамны эрхэлсэн түшмэл, дэс түшмэл, эх зохиогч түшмэдүүд, дөрвөн аймаг, шавь таван аймгийн төлөөлөх түшмэл зэргүүд болох нь аливаа хурал дор оруулсан хэргийг шүүмжлэн хэлэлцэх төлөвлөх ба санал гаргах эрхтэй боловч цөм Дээд хурал дор оруулж тасалмуй. Дээд хурлын таслах эрх нь тэргүүн, дэд сайдууд дор баймуй” (Н.Магсаржав, 2014, хуудсд. 88-89) хэмээжээ.

Монголын хуралдай, хурлыг зарим судлаачид парламентын нэгэн хэлбэр гэж үздэг бол няцаасан ч бий. Энэ асуудлыг эцэслэн шийдвэрлэх нь энэхүү судалгааны зорилго бус тул холбогдох баримтуудыг эх хэрэглэгдэхүүнд оруулж, дараа дараагийн судалгааны шатанд дүгнэж цэгнэхийг нийт судлаачдад нээлттэй үлдээж байна. Харин тайлангийн хэмжээнд товчлон өгүүлэхэд Монгол Улсын эрх барих дээд байгууллагын нэгэн чухал элемент бол Их хуралдайгаас Улсын хурал хүртэл уламжлагдан ирсэн өвөрмөц нэгэн байгууламж юм.

3. Зөвлөл, яамд

Хэдэн жил болж өргөн хүрээнд хуралддаг Их хуралдайн завсар хооронд иргэний болон цэргийн чухал хэргийг хэлэлцдэг байгууламж нь Чингис хааны үед хэлбэржин тогтсон есөн өрлөг тэргүүтнээс бүрддэг “Сэцдийн зөвлөл” юм. Бичгийн болон аман сурвалжид есөн өрлөгийн талаар олонтоо дурддаг бөгөөд нэгэн баримтыг иш татвал,

“Есөн өрлөг хэмээн ихэд алдаршсан сайд нь, есөн мужийн ноён Арлудын хүлүг Боорчи, Дэлгэт баяны хөвгүүн Жалайдын Хоо ван тайш Мухулай, Үшиний хайрт Борхул [*а.=Бугурал*], Ойрадын Хар Хирүгэ, Урианханы Сайн Зэлмэ, Бэсүдийн ноён Зэв, Татарын Шихихутаг, Сүлдэсийн Торгон шар, Гун Нин Цзин ван Зөрчидийн Чуу мэргэн эд буй.

Эзэн богдод учирч дагаад

Эн улсаас хүчээ их өгч

Эрхлэн төр тогтоож хаан эзнээ баясгаад

Эрхэн сайд болж төрийн ёсыг бүрнээр баривай (Дарма гүүш, 2006, хууд. 152) хэмээжээ.

Өгөдэй хааны үед гүйцэтгэх засаглалын эрх, үүрэг улам тодорхой болж цэгцэрсэн юм. Энэ нь цаашид Юань гүрний үед улам төгөлдөржиж “Төвлөн засаглах газар” нь засгийн газрын үүргийг гүйцэтгэх болов. Тус газрын тэргүүнийг угсаа залгамжлах хан хүү тэргүүлж байв. Сурвалж сөхвөл, “Улаагчин тахиа өдөр абгай Аюуширидарыг [хунтайж] хуантайзи байгуулж, [Төвлөн засаглах газрын тэргүүлэгч сайд] жуншу лин, [Цэргийн явдлын түшмэл] шуми ши болгоод алтан эрдэнэ өгч тэнгэр газар ба өвгөдийн сүмд хэлж тайв (Юань улсын судар III, 2021, хууд. 183). Хунтайжийн дор баруун, зүүн гарын чинсан буюу тэргүүлсэн сайдууд Төвлөн засаглах газрыг ахалж байв. Юань гүрний үед олон тооны түшмэд тэрхүү чинсан болон Төвлөн засаглах газарт харьяалагдах яамдын сайдын тушаалыг эрхэлж байсны их төлөв нь Их Монгол Улсын сурвалжит хүмүүсийн удам байв.

Улсыг удирдахад хааны чухал тулгуур болох гүйцэтгэх засаглал Юань гүрний дараа ч үргэлжилж байлаа. Тухайлбал, Түмэн тайж⁵ хорин найман насандаа хаан болж, зургаан түмнийг чулгуулж (чулууулж хөр.) их цааз хийвэй. Зүүн гурван түмнээс Намудай хунтайж, Халхын Субухай үйзэн, Баруун гурван түмнээс Ордосын Хутагтай сэцэн хунтайж, Асудын Ном-дарахолучи(н) ноён, Түмэний Намудай чөрүхү хунтайж, эднээр засгийг бариулж, “Түмэн засагт хаан” хэмээн алдаршиж, хүн амьтныг жаргуулан, гучин таван жил хан орон сууж ... (Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршвой, 2006, хууд. 71) хэмээснээс тодорхой байна.

⁵ Гүдэн Дарайсун хааны их хөвгүүн, 1539 оны шарагчин гахай жил төрж, 1558 оны шар морин жил хаан суужээ.

1911 онд үндэсний эрх чөлөөний хувьсгал ялсны дараа таван яамны бүрэлдэхүүнтэй Засгийн газрыг шуурхайлан байгуулав. Эхэндээ Дотоод, Гадаад, Цэрэг, Сан, Шүүх зэрэг асуудлыг хариуцсан таван яамыг байгуулсны Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яам нь бусдыгаа ахалж байлаа. Гэвч удалгүй 1912 онд Бүгд ерөнхийлөн шийтгэх яамыг байгуулсан нь орчин үеийн Засгийн газрын эхлэл байв.

Олноо өргөгдсөний гуравдугаар он долоон сарын хорин долоонд зарлигаар баталгаажсан Засгийн газар, яамдын эрхлэн шийтгэх хэрэг нь нарийн тодорхойлогдсон байв. Үүнийг хүснэгтээр үзүүлье.

№	Яамдын нэр	Яамдын эрхлэн шийтгэх хэрэг
1	Бүгд ерөнхийлөн захирах яам	Улсын хэрэг. Амьдрах иргэнд холбогдсон ашиг зовлон, түшмэл файлангийн төв гажууг гарган айлдах хачлан хэлэлцэх зэрэг хэргийг бүгд захиран шийтгэх ба харьяат олон яамны айлтгах бичгийг дараалан хянаж, эс нийлэлцсэнийг нь байцаан гаргаж, Дээд Зарлигийг уламжлан буулгах бас Дээрээс тусгайлан буулгасан Зарлигийг гүйцэтгэн шийтгэмүй. Жич харьяат олон яамдууд эл шийтгэж дуусгасан ба шийтгэн дуусгаагүй хэргийн товчийг цагийн эцэст Ерөнхийлөн шийтгэх яаманд хураангуйлж үзүүлэн байцаалгамуй. Хэрэв үл нийлэлцсэн зүйл буй аваас тухайд байцаан гаргаж, залруулан засах зэрэг зүйлийн хэргийг цөм бүгд захирч шийтгэмүй.
2	Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яам	Олон монголын доторх элдэв хэргийг эрхэлж сургаж цаазлахыг тархаан, нутаг үндэс, хүн ам, газар орон, зах хязгаар, өртөөний захирах, дагаар орогсдыг агуулах, тохинуулах зэрэг хэргийг эрхлэн шийтгэмүй. Түшмэлийн яамыг хавсарсны тул, зэрэг дэв улируулах, хэрэглэх түшмэл тавих, хуулийг нийгэм түвшин болгох, шалган байцаах, гавьяа эндэгдлийг ялган хөхиүлэх, өргөмжлөх, нэхэн өргөмжлөх, түшмэл залгамжлах, өргөмжлөлийг хянаж, буулгах зэрэг хэргийг эрхлэн шийтгэмүй. Ёслолын яамыг хавсарсны тулд, хууль дүрмийг ариутган эрдэнэ тамга цутгах, дээр мөргүүлэх, тайх тавиглах, баярын ёслол, бэлэвсрэлийн ёслол, зочдыг зочлох, хуримыг базаах зэрэг хэргийг эрхэлж шийтгэмүй.

3	Гадаадын хэргийг бүгд захиран шийтгэгч яам	<p>Гадаад улс лугаа найрамдлын ба худалдаа нэвтрүүлэх, гэрээ бичиг байгуулах хэрэг тохиолдох бүр Зарлигийг гуйн айлтгаад тусгайлан бүрэн эрх барих сайдыг томилон гаргаж, нарийвчлан хэлэлцэн тогтоож сонсгон айлтгаад нийтээр явуулан тушааж дагаж явуулмуй. Жич бусад аль ч улсын хэрэг шийтгэх газар ба мөн тэдний сайдууд, түшмэл лүгээ аливаа хэргийг ам ба бичгээр харилцан хэлэлцэж шийтгэмүй. Мөнхүү бусад улсын сайдууд, түшмэл ба цэрэг албаны хүн нарыг сайшаан хөхиүлэх хэрэг тохиолдвоос айлтгаж хишиг хүртээлгэмүй. Бас аливаа гадаад улсын засгийн хэрэг шийтгэх газар ба худалдааны хүн нар манай Монгол Улсын харьяат олон газар төмөр зам, цахилгаан тэрэг байгуулах ба худалдааны пүүс, байшин орон байгуулах, бас ч олон зүйлийн уурхай нээх, уул дэлхийн ашгийг авахыг гуйх зэрэг хэргийг бүрнээ эрхлэн гүйцэтгэн шийтгэмүй. Аливаа Монгол, Орос харилцан холбогдсон зарга заалхай, хулгай худал, хүний амины зэрэг хэргийг Оросын консул сайд лугаа хамт нийлэн шүүн шийтгэх буюу эсхүл зохих газруудад явуулан тушааж гүйцэтгэн шийтгэмүй. Дундад иргэн лүгээ гэрээ бичиг байгуулахуйн янар аливаа харилцан холбогдсон хятадын зарга заалхай, хулгай худлын зэрэг хэргийг цөм эрхлэн шийтгэмүй. Хаяа хүний амьтны зэрэг хүнд чухал хэрэг тохиолдвоос Шүүх таслах яам лугаа хамт нийлэн шүүн шийтгэмүй. Манай улс нэгэнт Гаалийн яам байгуулсны тулд, гааль хураах хэргийг цөм Гаалийн яам эрхлэх боловч, гадаадаас гааль хураах нь багагүй тул Гадаадын яам Гаалийн яамыг хавсарч шийтгэмүй.</p>
4	Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам	<p>Цэргийн засаг, чуулган чуулж эр төөлөх, цэргийн түшмэлийг нөхөх тавих хэргийг эрхэлж, цэргийн үнэнийг хянан байцааж, улсын засагт туслан, цэргийн түшмэл сонгон тавих, өргөмжлөн өглөгийн түшмэл өгөх, жич байлдах дайлалдахад сургах, ухуулах, засаг цаазыг зарлах, дэлхий дахин газар орны зургийг эрхэлж бэрх чухлыг мэдэн, гавьяаг ялган эндэгдлийг байцаах, хөхиүлэх, залхаах, дэвшүүлэх, бууруулах, цэргийн данс, цэргийн эрдэмтнийг шалгах, цагдах, манах зэрэг хэргийг эрхлэн шийтгэмүй. Цэргийн тухай чухал хэрэгт хурдан бичиг илгээх ба мэдээлэн түшмэлийг зарах зүйлд улаа шүүс хэрэглэх зэрэг хэргийг дангаар эрхэлж шийтгэмүй. Цэргийн тухайн чухал хэрэгт хурдан бичиг илгээх ба мэдээлэн түшмэлийг зарах зүйлд улаа шүүс хэрэглэх зэрэг хэргийг дангаар эрхэлж шийтгэмүй. Басхүү цэргийн хүн аливаа гадаадын хүн лүгээ холбогдсон хэргийг Гадаад яам лугаа нийлэн байцааж шийтгэмүй. Жич хянаваас аливаа улс төрд үйлдвэрээс эрхэм нь үгүй тул, Цэргийн яамны дотор үйлдэх хэлтэс байгуулж мөн үйлдвэрт хэрэглэх эдийн сан бэлтгэж хааны үйлдвэр ба цэргийн зэвсгийг үйлдэж бэлтгэвээс зохимүй. Энэ үйлдэх хэлтсийг эрхлэх хэргийн товч нь дэлхий дахины урчууд үйлдвэрийг захирч Хааны орд харш ба цэргийн гэр хороо, усны үйлдвэр, гүүр байгуулах, онгоц сан бэлтгэх, цэргийн албаны амуу тариа, түлш мод зэргийг бэлтгэх зэргийг эрхлэн шийтгэмүй.</p>



5	Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яам	Дэлхий дахины газар орны тариалан, өрх ам, эд малын засгийг эрхэлж, гаргах оруулахыг тохиолдуулан, эдийн засгийг дэлгэрүүлж, цалинг нийгэмчлэн, хот хэрэм, албаны гэр хороог дагаж шийтгэмүй. Жич Сангийн яамны дотор Гааль хураах яам байгуулж захиран хураасан гаалийг шилжүүлэн авч улсын хэрэглэлд оруулмай. Олон газрын ноёд лам нараас Дээр барьсан есөн цагаан, бэлгийн зүйлсийг хураангуйлан айлтгах ба сүрэг болгон айлтгах, жич амгалан айлтгагсдын шагнал ба олон чуулганы ноёд, лам нар, гавьяа бүхий хүн нарын хүртвээс зохих пүнлүү цалинг ноёд, лам нар, гавьяа бүхий хүн нарын хүртвээс зохих пүнлүү цалинг түгээн шагнаж олгох, алтны зэрэг олон уурхайгаас гаалийг сар дараалан хураан авах ба мөн уурхайн хэргийг шийтгэх түшмэдийг томилон суулгах, Нийслэл Хүрээ ба зах хязгаарт дайчлан мордуулсан, сэргийлэн суулгасан олон ангийн түшмэл цэргүүд, захирагсдын цалин хэрэглэл зүйлийг тавин олгуулж, Улиастай, Ховдын зэрэг газар ба олон аймаг хошууд, хязгаарын газар үржүүлсэн сүргийн адуудыг жил бүр байцаалгах, адуулан үржүүлэх, жич зохихыг үзэж элдэв зарлагад татан авч зарцуулах, Бүгд ерөнхийлөн захирах зэрэг олон газрын яамны бичиг цэргийн сайд, түшмэдийн хэрэглэл мөнгө ба бийр цаас, бэх зэргийг тавин олгуулах, олон албан яам ба зочдын суух хашаа гэр, сав хэрэглэлийг үйлдүүлэх, засах зэргийн элдэв зүйл бүрийн үйлтгэлийн тухай орлого зарлагын зүйлд холбогдсон хэргүүдийг эрхлэн гүйцэтгэж шийтгэмүй.
6	Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яам	Цааз хууль, эрүү хорыг эрхэлж зарлигаар тушаан өгч шүүн шийтгүүлэх хэрэг ба олон яамны шүүх таслахууд холбогдсон хэргийг цөм Шүүх яамнаа шилжүүлэн өгч улсын доторх аливаа хүний амь, хулгай, худал, зарга заалхайн зэрэг их бага хэргийг бүрнээ ялган салгаж шүүн тодорхойлоод, сайшаах, буруушаах, хэлтрүүлэх, оноох зэргийг хянаж хууль ёсоор ял оноож таслан шийтгэх зэрэг хэргийг эрхэлж, гяндан хороо ба ялтны хэрэглэл зэргийг цөм эрхэлж шийтгэмүй (МУУТА. ТБА. ХА-3, Д-1, ХН-413, нугалбар 4).

4. Орон нутгийн засаг захиргааны нэгжүүд

Орон нутгийн засаг захиргааны систем нь үндсэндээ цэрэг, иргэний хосолмол хэлбэртэй явагдаж ирэв. Их Монгол Улс байгуулагдах үйл явцад идэвхтэй оролцсон сурвалжит ноёдоос эхлээд эгэл жирийн ардуудыг орон нутгийн үндсэн засаг захиргааны нэгж болон 95 мянганы ноёдод томилсон байдаг.

Энэ тухай Лувсанданзан гүүш бээр Алтан товчид бичихдээ, ..., улсыг хураан, төрийг тэтгэлдсэн сайд ардыг түмдийн ноён, мянгадын ноён, зуугаадын ноён, арваадын ноён болгон, дотоод бие сахих түмэн хэвтүүл, найман мянган Хорчин, хишигтэн болгож, цэрэг мэдэх баатар ноёдоор цэрэг мэдүүлэн, улсын албан гувчуурын дарга шүүлэн дэмч тавивай. Зарга ялгах зайсангууд тавин, улсыг мэдэх чэрби, цэргийг мэдэх чэрби тавьж, тус тусад нь түшин, яам ёсыг төгсгөж, таван өнгийн их улсыг хөл хөсрөө, гар газраа хүргэн энх жаргуулбай (Лувсанданзан, 2006, хууд. 225) хэмээв.

Мянган нь дотроо зуут, аравтад хуваагдах бөгөөд тэдгээрийг эзэн хаанаас томилогдсон мянганы ноён эрхлэн томилж байв. Харин мянганууд нь нэгдэж нэгэн түмт болон зохион байгуулагдана. Энэхүү нэгэн түмт нь том түмт буюу баруун, зүүн, төвийн түмэнд захирагдаж байв.

Монголын Юань гүрэн унасны дараагаар эзэн хааны сүр хүч доройтож, орон нутгийн эрх мэдэлтнүүдийн эрх хэмжээ өсөв. Энэ үеэс язгууртнууд төвлөрсөн хааны захиргаанд хамаарагдахаас аль болох зайлсхийж байлаа. Зарим тохиолдолд нэр нөлөө бүхий язгууртнууд эзэн хааныг хороох, өөрийн нөлөөний алтан ургийн хүнийг эзэн хаанд өргөмжлөх тохиолдол үүсэв. Энэ цаг үеийг социализмын үед “феодалын бутралын үе” хэмээн нэрлэж байсан бол эдүгээ “улс төрийн бутралын үе” гэх болов. Гол онцлог нь орон нутгийн сурвалжтанууд орон нутгаа бүрэн мэдэх ванлиг улстай ойролцоо байжээ. Тухайн үед зүүн монгол нь зургаан түмэнд хуваагдаж байсан бол баруун монгол нь дөрвөн үндсэн хэсэгт хуваагдаж байлаа. Түмэн нь дотроо отогт хуваагдаж байв. Отог нь Их Монгол Улсын “мянган” засаг захиргааны нэгжийг залгамжлан гарч ирсэн орон нутгийн үндсэн нэгж болно.

Монголчууд ээлж дараалан Манж Чин улсын эрхшээлд орсон үеэс орон нутгийн засаг захиргааны нэгжийг задлан жижиглэж, тоо хэмжээ нь огцом өсөх болов. Жишээлбэл, Манж Чин улсын эхэн үед Халх түмэн нь үндсэн гурван аймаг, долоон хошуунд хуваагдаж байсан бол үүнийг дөрвөн аймаг, дөчин есөн хошуу болгож, хожмоо хошууны тоог 100 гаруй болгосон байна. Хошуу нь дотроо сум, баг, арванд хуваагдаж байв. 150 эр цэрэгт гаргах боломжтойг нэгэн сум хэмээж байсан бол энэ эрсийг гаргаж чадахгүйг тал сум буюу “хондого” хэмээнэ. Эдгээр үеийн нэг онцлог бол шарын шашин монголд ихэд дэлгэрсэнтэй холбогдуулан шавийн харьяатууд бий болов. Богд Жавзандамбын болон тамгатай хутагтын шавь нар албан ёсны нутагтай, орон нутгийн засаг захиргааны нэгж болж байлаа.

Богд хаант Монгол Улсын үед засаг захиргааны нэгж төдийлөн өөрчлөгдсөнгүй. Хаант орос улсын төлөөлөгч И.Майски тухайн үеийн монголын орон нутгийн засаг захиргааг дараах байдлаар тэмдэглэн үлдээсэн байна. Үүнд, “Автономит Монголд 111 хошуу байхаас гадна бас засаг захиргааны үүднээс хошуунаас онц ялгаагүй 13 шавь /хутагтуудын ванлиг/ байна. Хошуу шавиуд нь Цэцэн хан, Түшээт хан, Сайн ноён хан, Засагт хан, Далай хан, Зоригт хан гэсэн зургаан аймагт нэгджээ. Аймгуудыг аймгийн чуулганы дарга нар толгойлно” (И.Майский, 2001, хууд. 341) гэв.

Бидний авч үзсэн түүхэн хугацааны туршид орон нутгийн засаг захиргааны нэрийдэл нь цөөнгүй хувирч ирсэн боловч үндсэн агуулга нь хэвээр дараа дараагийн үеүдэд уламжлагдсаар иржээ. Их Монгол Улсын үеийн “мянган” нь улс төрийн бутралын үед “отог” болж хожим Манж Чин улсын үед “хошуу” болсон юм. Эдгээр орон нутгийн засаг захиргааны үндсэн нэгжийн гол онцлог нь иргэний болон цэргийн давхар зохион байгуулалттай байв.

Төрийн албаны хүрээлэнд уламжлагдаж ирсэн зохион байгуулалтын бүтэцтэй холбогдох олон баримтуудыг эх сурвалжуудаас түүвэрлэн авч тайлангийн хавсралт эх хэрэглэгдэхүүнд оруулж өгсөн нь эдгээр асуудлыг гүнзгийрүүлэн судлахад дөхөм, материал, энэ чиглэлээр суралцагсдад үзэх гарын авлага болох юм.

4.3. Төрийн албан дахь эрх зүйн зохицуулалтын уламжлал

Чингис хааны Их засаг хуулиас Богд хаант Монгол Улсын Хууль зүйлийн бичиг хүртэл эмхэтгэгдэн гарч тухайн үеийн нийгмийн харилцааг зохицуулж байсан хуулиудыг дотоод, гадаадын түүх, төр эрх зүй, эх бичиг судлаачид өөр өөрсдийн судалгааны өнцгөөс дүн шинжилгээ хийсээр иржээ. Иймд Их засаг, Их цааз, Халх журам, Зарлигаар тогтоосон Гадаад монголын хууль зүйлийн бичиг, Монгол Улсын хууль зүйлийн бичиг зэрэг нэгэнт орчин үеийн үсэгт тайлбар сэлттэй хэвлэгдэн гарсан эрх зүйн сурвалжуудаас эх баримтыг сонгож авахыг эн тэргүүнд зорьсонгүй. Харин судлаач, суралцагсдын эрэн сурвалжилж байж олж авах 109 баримтыг түүхэн тулгуур эх сурвалж, архивын материалаас түүвэрлэн эх хэрэглэгдэхүүнд оруулав. Эдгээр сонгож авсан эх баримтуудад тулгуурлан төрийн албан дахь эрх зүйн зохицуулалтын уламжлалыг тодруулахыг зорилго болгов.

Их засаг хууль хэрхэн эзэнт гүрэнд хэм хэмжээ тогтоож байсныг Судрын чуулганд тэмдэглэснээс үзвэл, “эмх цэгцгүй, бодолгүй улс түмэн нь Чингис хааны мандан гарч ирэхэд захирагдаад, түүний туйлын хатуу яс хуулиар ёс журамтай /заншилтай/ болгов” (Рашид ад дин, 2002, хуудсд. 404-405) хэмээжээ. Чингис хааны эзэнт гүрэн даяар мөрдөгдөж ирсэн Их засаг хуулийг хойч үеийнхэн нь сахин хэрэгжүүлж байхыг тэр бээр сургаж өгүүлсэн байна. Энэ тухай баримтыг иш татвал, Тэр бээр өгүүлрүүн: “Хэрэв /төрийн/ ихэс хүмүүс эзэнтнүүдийн олон хөвүүдийн дэргэд баатрууд, ноёдууд буй болно, энэ бүхний эцэст цаазаа хатуу сахихгүй болж, төрийн хэрэг доргиж тасалдаад ирэхэд Чингис хааныг эрээд эрээд ч олохгүй (Рашид ад дин, 2002, хууд. 405) гэжээ.

Энд нэгэн зүйлийг цохон тэмдэглэхэд зарим судлаачид Их засаг хуулийг их төлөв “цаазалсугай” хэмээх заалттай их харгис эрх зүйн акт хэмээн дүгнэсэн нь нягтлууштай. Энэхүү цаазалсугай гэдэг нь “хориглосугай” гэсэн утга гол төлөв илэрхийлэхээс ойрын “цаазын ял буюу алах ялтай” холбоогүй мэт. Их засаг хуулийг хэрэгжүүлэгч Их Монгол Улсын заргач Шихихутугийн шүүх үйл ажиллагаанаас харахад энэрэнгүй байжээ. Тэр наян хоёр настайдаа заргыг шударгаар шүүж, ялтнуудад их тусалж, энэрч байжээ. Тэр “Айж цочин хэрэг хүлээх хэрэггүй” гэж нэг биш удаа давтан хэлдэг байсан. “Айлгүй үнэнээ хэл!” гэж хэрэгтэн нарт хэлдэг байсан. Тэр үеэс одоо үе хүртэл Могулистанд ч, бусад нутагт ч түүний арга барилын зарчмыг шүүхийн шийдвэрийн үндэс болгодог

нь заргачдын /шүүгчдийн/ маргаанаас тодорхой байна (Рашид ад дин, 2002, хуудсд. 70-71) гэж дүрслэн бичжээ.

Мөн Чингис хаан улсыг удирдалцах түшмэдийг хэрхэн ажиллах талаар зарлиг гаргасан байна. Үүнд: “Жилийн эхэн ба эцэст ирж Чингис хааныг билэгдлийг мэдээд буцдаг түмэт, мянгат, зуутын зөвхөн тийм ноёд л цэргийг толгойлж байх учиртай. Гүнзгий усанд унасан чулуу, эсвэл зэгсний ширэнгэ рүү харвасан сумтай адил ул мөргүй арилдаг шиг гэртээ суугаад л билэгдлийг үл ойшоогчид, дарга байж таарахгүй” гэжээ. Бас нэгэнтээ өгүүлрүүн: “Өөрийнхөө гэр орноо цэмбэгэр байлгаж чаддаг хүн бүхэн /бүхэл бүтэн/ эзэмшлийг ч цэгцтэй байлгаж чадна. Арван хүнийг дайтахад байвал зохих ёсоор засаж чаддаг хүн бүрт мянгат буюу түмтийг ч өгсөн болно. Тэр ч түүнийг байлдахаар засаж чадна” гэжээ (Рашид ад дин, 2002, хуудсд. 404-405). Өвлийн сүүл сард Чингис хаан, Мухулайг төрд тусалсан гавьяа буй хэмээн алтан тамга өгч, тайши Го Ван өргөмжлөөд, үрийн үрд Монгол хятадын цэргийг захиртугай хэмээгээд, бас зарлигийг дагуулж аливаа тушаасан хэргийг шийтгүүлэн Хонгирадын зэрэг арван хүрээний цэрэг ба бас Монгол хийгээд Хятадын бүгд цэргийг захируулж, Яньюнь-ий газарт Явах шэн яам байгуулав. Түүнээс ван Мухулайд сургаж, зарлиг буулгаруун: “Улс төрийн үйлийг сайхан тэтгэж, миний өршөөх сэтгэлийг олон иргэнд нийтээр хүргэ. Буруутныг гэгсгээж, зөвтнийг хөхиүлтүгэй. Жич, Тайхан-аас хойшхыг би тогтоосугай. Тайхан-аас урагшийг сайд чи хичээгтүн” хэмээлээ (Рашпунцаг, 2006, хууд. 77).

Хэмжээгүй эрхтэй хаадын зарлиг нь эзэнт гүрний хэмжээнд шууд үйлчилж байсан тул чухал нэгэн эрх зүйн сурвалж болно. Иймд төрийн албатай холбоотой нэлээдгүй зарлиг, сургаалуудыг эх хэрэглэгдэхүүнд хавсралтаар оруулав. Чингисийн дараах Өгөдэй, Гүюг, Мөнх хааны үед улсын албыг сайжруулахтай холбогдох гарсан үе үеийн олон зарлигуудын үр өгөөж тухайн үедээ үр дүнгээ өгч байсныг сурвалжуудад тэмдэглэсэн ажээ. Тэдгээрээс нэгийг утгачилбал, Мөнх хаан болсон даруйдаа урьд өмнөх хаадын олгосон болон тэр үед сурвалжитнуудыг гаргасан өртөө улаа хэрэглэх пайзнуудыг хураан авч, түүнээс хойш их хааны зарлигаар олгож байхаар хатуу хуульчилж мөрдүүлж байв. Үүний үр дүнд өртөө улааны хүнд алба цэгцэрч түүгээр гол төлөв төрийн чухал хэрэгтэй элч төлөөлөгч нар л сааталгүй явах болов.

Хубилай хаан Юань улсын үндэслэн байгуулсан үеэс эзэнт гүрний хэмжээнд хэрэгжих хэд хэдэн эрх зүйн баримтуудыг гаргаж, зарлигаар түшмэдийг сонгох, хэрэглэхтэй холбоотой олон чухал дүрэм, журмууд хэрэгжих болов. Эдгээрээс товчлон дурдвал,

- Дотоод, гадаад түшмэдийг хуучин хууль ёсоор болгож гурван жил нэг удаа дэвшихээр тогтоов (Юань улсын судар I, 2021, хууд. 192).
- Цэргийнтүшмэлдайндүхвээстүүнийхөвүүнээрзэргийгзалгамжлуулаад, өвчнөөр үгүй болбоос түшмэл тавихад нэг зэрэг бууруулаад цөм хууль болгогтун хэмээв (Юань улсын судар I, 2021, хууд. 288).



- Шадар бараач нар хүний тулд түшмэл гуйж сонгох хуулийг самууруулахыг цаазлав (Юань улсын судар I, 2021, хууд. 304).
- Данж хөвгүүнийг тогтоосон нь аливаа их түшмэдийн хөвгүүд дүү нар нийслэл хотод илгээгтүн хэмээв (Юань улсын судар I, 2021, хууд. 311).

Хубилай хааны дээрх зарлигуудад улсын албанд ажиллагсдыг шатлан дэвшүүлэх, залгамжлуулах, сонгон хэрэглэх, үнэнчээр ажиллуулах зэргийг нарийн тусгажээ.

Эзэнт гүрний хэмжээнд бүхий л асуудал зөвхөн хааны зарлигийн дагуу явагдаж байсангүй. Хэд хэдэн томоохон хуулиудыг эмхэтгэн гаргасан байна. Юань улсын сударт тэмдэглэгдсэнээр, “Хууль дүрэм төгсөж тогтсон нь бүгд хоёр мянга таван зуун гучин есөн зүйл дотор дүрэм зүйл нэг мянга нэг зуун тавин нэг, тархаах зарлиг хэлтрүүлэх зарлиг ерэн дөрөв, зарлалын зүйл таван зуун далан долоо Их Юань улсын бүгд хууль хэмээн нэрийдээд дэлхий дахинд тархаан явуулав (Юань улсын судар II, 2021, хууд. 312). Улаагчин туулай өдөр бичгийн утгач улсын судрын яам (Гэгээн хаан) Инзун-гийн магад хуулийг зохиож төгсөв (Юань улсын судар III, 2021, хууд. 36) гэж эзэнт гүрний хэмжээнд хэрэглэгдэх болсон олон зүйл заалт бүхий томоохон эрх зүйн актуудыг удаа дараа гаргаж мөрдүүлж байв.

Хубилайн дараагийн хаадууд эцэг хааны үед хэрэглэж байсан хуулийг гол болгон тулгуурлаж зарлиг, шийдвэр гаргаж байлаа. Тухайлбал, “Шарагчин гахай өдөр зарлигаар зуун түшмэдийн сонгож тавих түшмэдийг [Сэцэн хаан] Шизу-гийн хуучин хуулийг дагагтун гагцхүү [Цэргийн явдлын хүрээлэн] Шуми юань, [Хянан байцаах газар] Үйши тай, [Ярууг дэлгэрүүлэх хүрээлэн] Суаньхуй юань яам өөрөө айлтгаж сонордуулбаас болно бусад бүрнээ [Төвлөн засаглах газар] Жуншу шэн-ээс дэвшүүлэгтүн хэмээв) Цагаагчин үхэр өдөр Мамуша-г [Цэргийн явдлын хүрээлэн] Шуми юань яамны хэргийг мэдүүлэв” (Юань улсын судар II, 2021, хууд. 320). Юань Чжэнь-ий хоёрдугаар он, цагаан сард, Чэнцзун хаан жуу бичиг буулгаж: “Олон ван, гүнж, фума (тавнан) миний зарлиггүй болбоос, түшмэдийг бүү яллагтун” хэмээн зарлиг буулгавай (Рашпунцаг, 2006, хууд. 288). Зургаан сард, бүгдийг байцаах түшмэл Чэнцзун хаанд үг айлтгаруун: “Түшмэд хүний хахуулилан өгөх мөнгөн эдийг хүлээн авч, анх асуун тогтоосон үгийг дахин шүүхүйд, тал харж зөрчиж шүүвээс, энэ мэтсийг хүндэд яллаваас зохимуй” хэмээсний хойно, Чэнцзун хаан мөн хэмээвэй (Рашпунцаг, 2006, хууд. 289) зэрэг болно. Үүнээс үзэхэд Юань гүрэнд төрийн албанд эрх зүйн зохицуулалт нарийн мөрдөгдөж байв. Ялангуяа төрийн албанд ажиллах түшмэдийн эрх, үүрэг, хамгаалал, цээрлэлийг хатуу мөрдүүлж байсныг жишээ баримтуудаас тодорхойлж болно.

Улс төрийн бутралын үед монголчууд хямралыг давах үүднээс Дөчин дөрвөн хоёрын Их цааз, Халхын долоон хошууны цааз зэрэг хууль эрхэмжийн бичгүүдийг боловсруулсан байдаг. Эдгээр монгол хуулиудыг Манж Чин улсын эрхшээлд орсон эхэн үед хэвээр хэрэглэж байв. Энэ тухай баримт сөхвөл, Энх-

Амгалангийн гучдугаар он долоон сарын хөх морь өдөр. Зарлиг шинэ дагасан халх нарыг түр тэдний хууль ёсоор болго хэмээв. Гадаад Монголын төрийг засах явдлын яамнаас айлтгасан нь, “Халх нарыг дөчин есөн хошууны адил болгосны тулд олон засгийн чин вангаас доош, орлон хөөгчөөс дээш аливаа амгалан эрхээр, алба хүргэхээр, бичиг айлтгахаар, элч зарав ч тэдний биес ирэвч цөм дөчин есөн хошууны хууль ёсоор явууля...” хэмээв [Биеэр дайлж өрнө умрын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг (дэвтэр: 1-13), 2019, хуудсд. 172-173].

Гэвч удалгүй шинээр боловсруулсан Монгол цаазын бичиг, Гадаад Монголын хууль зүйлийн бичгийн дагуу нийгмийн харилцааг зохицуулах болов. Эдгээр хуулиудад төрийн албаны үйл ажиллагааг хэрхэн зохицуулж байсныг Хошууны хэргийг туслан ялгагч тайж нарыг тавих тухай заалтыг иш татаж үзье. Үүнд, Нэгэн зүйл. Дотоод, гадаад хошуу бүр хошууны хэргийг туслан ялгагч тайж нарыг тавиад, өөр өөрийн засгууд лугаа хамт хэрэг ялга. Ор гарсны хойно харьяат Засгийн газраас харьяат чуулганы тэргүүн лүгээ нийлж сул вангуудаас доош тайж нараас дээш хүн нь ариухан хэрэг ялган захиран чадагчийг сонгож батлаад нэгийг тусгайлж нэгийг ташлуулаад тусгайлж Явдлын яаманд илгээ. Явдлын яамнаас авч биеийг нь үзүүлж тавина (Монгол цаазын бичиг, 2004, хууд. 36) хэмээжээ.

Богд хаант Монгол Улс байгуулагдсан даруй манжийн үед хэрэгжиж байсан есөн эрүү зэрэг харгис эрүү заалтуудыг халж, шүүх цаазын бичгийг мөрдөн дагахыг хэрэгсэхгүй болгов. Монголчууд язгуураас хэрэг бүрд мөрдөн дагасан нь бус тусгайлан монгол цаазын бичиг хуулийг мөрдөн журамлаж, хааяа гүйцэлдэхгүй нь буй аваас зохих газарт лавлан мэдүүлж тогтоолгосоор ирсний дээр эдүгээ хууль зүйлийг бүрнээ шинэчлэн тогтоохын инар хуучин хуулийг түр мөрдөн дагаж шийтгүүлж (МУҮТА, ТБА. ХА-3, Д-1, ХН-81, Хуу-394а-396а) байв.

Шинэ байгуулагдсан засгийн газрын хувьд олон асуудлыг шашин төрийг хослон барьсан Богд хаанд айлтгаж зарлигаар баталгаажуулан шийдвэрлэж байв. Үүний нэгэн жишээ нь: Аргын тооллын 1912 оны 01 сарын 11-ний өдөр айлтгаж, “Монгол өөртөө тусгай улс болон тулгар төр байгуулж, Чин улсын хууль, дүрэм, сургаалыг хэрэглэхгүй болсны тулд Монгол олон яам газрын тамгыг битүүмжлэх ба нээхийг үүрд байлгаж харьяат олон газраа нийтээр зарлаж дагаж явуулбаас болох ба үл болох явдлыг хичээнгүйлэн хуудас хавчуулж айлтгаад Богд бээр толилж заалхийлэн сургах ажаамуу. Үүний тул хичээнгүйлэн айлтгав. Зарлигийг гуймуй хэмээн айлтгасанд мөнхүү сарын хорин дөрвөнд хүлээн авсан уг нугалбарт улаан бийрээр цохсон зарлиг гуйсан ёсоор болгогтун хэмээв (МУҮТА, ТБА. Х-А3, Д-1, ХН-3, Хуу-28а-29)” гэснээр хоёр зуу гаруй жил тогтсон манжийн хэвшлийг халсан байна. Ийнхүү төрийн албанд эрх зүйн зохицуулалтаар шинэчлэл явагдаж байв. Мөн үед олон түмэн дагаж мөрдөх дүрэм, журмууд олноор боловсруулагдаж гарч байв. Тухайлбал,

Гадаад, Сан хоёр яамнаас олон худалдааны иргэдээс хураалгах гаалийн дүрэм хэмжээ тогтоож байв.

Улс байгуулагдах үеэс түмэн улсын ердийн цааз зэрэг олон улсын хууль дүрмүүдийг судалж монгол хуулийг боловсруулах ажлыг шат дараалалтай явуулж байв. Үүний хүрээнд 1913 онд Монгол Улсын хууль зүйлийн бичгийг боловсруулах ажлын хэсгийг өргөн бүрэлдэхүүнтэй байгуулж, дараа жил нь Улсын дээд, доод хурлыг тус тус байгуулж хууль зүйлийн саналуудыг, хэсэг, хурал, яамдаар тухай бүр хэлэлцүүлж 1918 онд “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” нэртэйгээр 65 дэвтэр болгон эмхэтгэж гаргажээ. Судлаачид хууль зүйлийн бичгийн агуулгад үндэслэн Төрийн байгуулалд хамаарах 6 дэвтэр, Төрийн захиргааны асуудлыг хөндсөн 9 дэвтэр гэж тэмдэглэсэн байдаг.

Тус хууль зүйлийн бичгийг тусгайлан судалсан Б.Батбаяр дүгнэлтдээ тухайн цаг үеийн төрийн бодлого, түүний зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж, нийгмийн харилцааны үндсэн хэсгийг зохицуулж чадсан төдийгүй, нийгмийн амьдралын бүх хүрээ, олон талыг хамарч, хууль зүйн суурь дэвсгэр болсон (Б.Батбаяр, 2011, хууд. 86) хэмээн үнэлэлт өгчээ.

Энэхүү хууль цаазын бичгүүд, хааны зарлиг, сайд, жанжин, түшмэдийн тушаал, шийдвэрүүд нь тухайн цаг үеийн төрийн албыг хэвийн явуулахад зохицуулалт болж иржээ.

4.4. Төрийн албан дахь ажил үүргийн хуваарилалт

Их Монгол Улс байгуулагдахдаа засаг захиргааны нэгжийг аравт, зуут, мянгат, түмтийн системээр зохион байгуулж аравтын захирагчийг зуутын захирагч, зуутын захирагчийг мянгатын захирагч, мянгатын захирагчийг түмтийн захирагч, түмтийн захирагчийг их хаан томилдог тогтолцоог бүрдүүлжээ. Аравт, зуут, мянгат, түмтүүд нь бүгд хамтын хариуцлагын тогтолцоотой байжээ. Жишээлбэл: зуутын захирагч алдаа гаргавал мянгатын захирагч хамт шийтгэл хүлээх гэх мэт. Мөн өөрийн хариуцсан нэгж тус бүрийнхээ цэрэг татлага, ахуйн амьдрал, амьжиргааг бүрэн хариуцдаг тогтолцоотой байсан.

Улс гүрний хэмжээнд үйл ажиллагааг удирдах, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхийн тулд овог аймаг бүрийг аж ахуй эрхлэх онцлог, чадавхаас хамааран зохих үүргийг өгч, хуваарилдаг байжээ. Түүхэн сурвалжуудыг шүүн үзэхэд Тэмүжинг Хамаг Монголын ханд өргөмжлөгдсөн даруйд тэр бээр өөрийг нь түшин ирж улс байгуулах үйл хэрэгт үнэнчээр зүтгэсэн хүмүүсийг зохих албанд томилсон байна.

Монголын нууц товчооны 124 дүгээр зүйлд: “Чингис хаан болоод, Боорчугийн дүү Өгэлэ чэрби хор агсав⁶. Хачигун тохуруун хор агсав. Жэтэй Доголху чэрби ах дүү хоёр хор агсав.

⁶ саадаг агсуулж, шадар цэрэг болгов.

Өнгүр, Сүйхэгү чэрби, Хадаан Далдурхан гурван өгүүллүүн:

“Манагарын⁷ ундыг бүү мөхөсдүүлсүгэй.

Үдийн ундыг бүү осолдсугай.” хэмээн буурчин болов.

Дэгэй өгүүллүүн:

“Шүдлэн иргийг шөл болгож

Манагар⁸ бүү мөхөсдүүлсү.

Хоногт бүү хожидсу.

Алагч⁹ хоньдыг адуулж алам дүүргэсү¹⁰.

Хонсогч¹¹ хоньдыг адуулж хотон дүүргэсү.

Хоолонцор муу бүлгээ, би

Хоньд адуулж хошног идсү, би” хэмээгээд Дэгэй хонь адуулав.

Дүү Хүчүгүр инү өгүүллүүн:

“Цуургат тэрэгний цүү инү бүү цүүдүүлсү¹²,

Тэнхлэгт тэргийг тэргүүр дээр бүү тээглүүлсү” хэмээн “Гэр тэрэг тэгшлэн
зассу”¹³ хэмээв.

Дөдэй чэрби “Гэр дотор гэргэн тудхар¹⁴ нарыг базаалсугай”¹⁵ хэмээв.

Хубилай, Чилгүдэй, Харахай Тохуруун гурвыг Хасар лугаа болон илд агсаж,

“Хүчирхэгсдийн хүзүүг ану хянгардагтун!

Оморхогсдын омрууг огтлогтүн!” хэмээв.

Бэлгүдэй, Харалдай Тохуруун хоёрыг,

“Агт барьтугай

Агтчин болтугай” хэмээв. Тайчуудай Хуту, Моричи, Мулхалху гурвыг адуу
адуултугай хэмээв.

Архай Хасар, Тахай, Сүхэхэй, Чахурхан дөрвийг

“Холын хоочаг ойрын отора¹⁶ болтугай” хэмээв.

Сүбээдэй баатар өгүүллүүн:

“Хулгана болж хураалдсу.

Хар хэрээ болж гадуун бүхнийг хармалдсу¹⁷.

⁷ өглөөний

⁸ өглөө (Эртний монгол хэлэнд “манагар” хэмээх нь 1.маргааш өдөр 2.өглөө хэмээсэн хоёр утгатай.)

⁹ алаг зүсийн эм хүйсийг заасан үг

¹⁰ Хот хороо, хотгор хөндий дүүргэе.

¹¹ хонгор зүсийн эм хүйсийг заасан үг

¹² бүү тээглүүлэе

¹³ засья

¹⁴ гэр зуурын үйл хийгч зарц тэргүүтэн

¹⁵ харгалзаж хамаарсугай

¹⁶ хол ойр тусах сумны нэгэн зүйл нэрс

¹⁷ хамж халмаж цуглуулъя

Нөмрөг эсгий болж нөмөрлөлдөн хорьсу.

Хэрсэг¹⁸ эсгий болж гэр орныг хэрсэглэлдэн хорьсу” хэмээв.

125.Тэнд Чингис хаан хан болж, Боорчу Зэлмэ хоёрт өгүүллүүн:

“Та хоёр намайг

Сүүдрээс бус нөхөр үгүйд

Сүүдэр болж, сэтгэлийг минь амуулав зэ, та нар.

Сэтгэлд атугай хэмээв.

Сүүлээс бус чичуга үгүйд

Сүүл болж, зүрхийг минь амуулав зэ, та нар

Цээж дотор минь атугай.” хэмээв. Та хоёр урьд байсаар эд бүхнийг ахалж байх бус уу?¹⁹ та нар хэмээв (Монголын нууц товчоо, 2006, хуудсд. 70-72).

Энэхүү ажил үүргийн хуваарилалт нь Их Монгол Улсыг байгуулсан үеэс улам хөгжиж, албан үүргээ гүйцэтгэх журам нь нарийсав. Жишээлбэл,

Чингис хаан зарлиг болруун: “Хорнин²⁰, турхаг, хэшигтэн, буурч, үүдэч, агтач өдөр хэшиг орж, нар шингэхийн урьд хэвтүүлд зайлж, агтастаа гаран хонотугай. Хэвтүүл шөнө гэр орчин²¹, хэвтэхүүнээ хэвтүүлж, үүдэнд байхуунаа хэшиглэн²² байгуултугай. Хорчин, турхаг манагар ину биднийг шөл идвээс, хэвтүүлд хэлж, хорчин, турхаг, буурчин, үүдчин мөн мөн мөртөөн явтугай. Сууриндаа суутугай. Гурван шөнө, гурван өдөр хэшиг өдрөө дуусч, мөнхүү ёсоор гурван шөнө хонолдож, егүүтгэлдэж²³, шөнө хэвтүүл атугай²⁴. Орчин хэвтэж²⁵ хонотугай!” хэмээн зарлиг болов (Монголын нууц товчоо, 2006, хуудсд. 132-134).

Энэ үед төрийн алба хэвийн явах бүх систем бүрэлдэн тогтсон төдийгүй давхардуулахгүй бүгд өөрийн хариуцсан үүрэг рольтой байжээ²⁶. Жишээлбэл, Улсыг хураан, төрийг тэтгэлдсэн сайд ардыг түмдийн ноён, мянгадын ноён, зуугаадын ноён, арваадын ноён болгон, дотоод бие сахих түмэн хэвтүүл, найман мянган хорчин, хишигтэн болгож, цэрэг мэдэх баатар ноёдоор цэрэг мэдүүлэн, улсын албан гувчуурын дарга шүүлэн дэмч тавибай. Зарга ялгах зайсангууд тавин, улсыг мэдэх чэрби, цэргийг мэдэх чэрби тавьж, тус тусад нь түшин, яам ёсыг төгсгөж, таван өнгийн их улсыг хөл хөсрөө, гар газраа хүргэн энх жаргуулбай хэмээн зарлиг буулгажээ.

¹⁸ хашаа хайс, хашлага

¹⁹ тэргүүлж байх бус уу

²⁰ нум сум агсагч шадар цэрэг

²¹ тойрон эргэн

²² ээлж ээлж болгон

²³ солилцож

²⁴ байтугай

²⁵ тойрон хэвтэж

²⁶ Торгууд – тэд өдрийн хамгаалагчид бөгөөд тэд эзнийгээ дайнд ч өдөр тутмынх нь ажилд ч дагаж ойрхон явдаг. Хэвтүүл – Тэд шөнийн харуул бөгөөд эзнийгээ шөнө гэрт унтаж байхад нь хамгаалах үүрэгтэй. Хорчин – Тэд эзэн хаадын дайны үеийн хамгаалагч нар

Их Монгол Улсын үед хамаг хэргийг Их хуралдай зөвлөлдөн шийддэг байсан бол Юань улсын үед 3 яам буюу Төвлөн засаглах газар, Хянан байцаах газар, Цэргийн явдлын хүрээлэнгээр хэлэлцдэг болжээ. Их Монгол Улс газар нутгаа тэлэхийн хэрээр төрийн тогтолцоонд дагаад өөрчлөлт орох нөхцөл бүрджээ. Олон орны соёлтой олон овог, аймгийг нэгтгэн захирахын тулд тус соёлыг мэддэг жишээлбэл, Кидан гаралтай Елюй Чуцай, Мусульман шашинтай Махмуд Ялавач гэх мэт эрдэм чадалтай хүмүүсийг цуглуулан монголын төрд олноор зүтгүүлж байжээ.

1911 оны 12 сарын 29-нд Их Хүрээнд наймдугаар Богд Жавзандамба хутагтыг тулгар улсын хаанд өргөмжилж, Засгийн газрыг шинээр байгуулан дэлхий нийтэд зарлан тунхаглажээ. Шинэ байгуулагдсан 5 яамны тэргүүн зэрэгт Дотоод хэргийг бүгд захиран шийтгэх яамны сайдаар Да лам Цэрэнчимэд, Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны сайдаар Чин ван Ханддорж, Сангийн хамаг хэргийг бүгд захирах яамны сайдаар Түшээт ван Чагдаржав, Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны сайдаар Далай ван Гомбосүрэн, Шүүх таслах хэргийг бүгд захирах яамны сайдаар Эрдэнэ ван Намсрай ван нарыг тохоон томилжээ. 1912 оны 8 дугаар сард Бүгд ерөнхийлөн захирах яамыг байгуулж сайдаар Сайн ноён хан Намнансүрэнг томилсон байдаг.

Богд хаант Монгол Улсын үеийн улсын байгууллагууд, тэр дундаа яамдад алба хаах сайд, түшмэдийн эрхлэх үүргийг тусгайлан зааж өгчээ. Мөн орон нутгийн засаг захиргаад болох аймгийн чуулган, жанжны газар, олон хошуудын тамгын газар алба эрхэлж байсан түшмэдийн эрх, үүргийн Монгол Улсын хууль зүйлийн бичигт хуульчлан өгсөн нь орчин үеийн албан тушаалын тодорхойлолт шиг байв.

4.5. Төрийн албанд хүмүүсийг сургаж боловсруулж байсан уламжлал

“Мерит” буюу чадахуйн зарчимд суурилсан, шатлан дэвших тогтолцоо нь манай улсын хувьд онолын шинэлэг зүйл мэт боловч үнэн хэрэгтээ Их Монгол Улсын үед ч хэрэгжиж байсан зүйл юм. Мэдлэг, ур чадвартай бол харц гаралтай гэж ялгалгүй хэргэм зэрэг олгож, гавьяа зүтгэл байгуулсан тохиолдолд 9 удаа ялаас хэлтрэх, тодорхой албан тушаалд томилох, цол хэргэм олгох гэх мэтээр шагнаж урамшуулдаг байв. Мэдлэг чадвараас гадна эзэнд үнэнч байх, хувь хүний бие бялдрын зэрэг бусад ур чадвар, зан чанарыг харгалздаг байв.

Мөн эрт дээр үеэс төрийн албыг залгамжлан, олон ардыг захирах хаад, ноёдын хөвгүүдийг багаас бэлдэж сургаж байв. Багад боловсорч төгсвөөс их болсон хойно элдэв хэрэг шийтгэхэд итгэж хэрэглэвээс оролдсон тушаалыг гутаахгүй болон чадахын тулд зүй нь аливаа нас бага ван, гүн, тайж нарыг багаас сурган, түшмэд болгон бэлтгэж иржээ. Багаас боловсорч, албан тушаалыг багаас нь хийж, цаашид дэлхийн эзэнт гүрнийг удирдах их хааны

тулгуур болгон бэлдэнэ. Үүний нэгэн илрэл нь Монголын нууц товчооны 138 дугаар зүйлд дурдсан нь: Өгээлүн эх Мэргидийн нутгаас олдсон Хүчү нэрт хөвүүхнийг, Тайчуудын дотор Бэсүдийн нутгаас олдсон Хөхөчү нэрт хөвүүхнийг, Татаарын нутгаас олдсон Шигихэн хутугу нэрт хөвүүхнийг, Жүрхиний нутгаас олдсон Борохул нэрт хөвүүхнийг, эд дөрвөнийг гэр дотор тэжээхдээ Өгээлүн эх хөвүүддээн:

“Өдөр үзэхийн нүдэн

Шөнө сонсохын чихэн болгоё” хэмээн гэр дотор тэжээв (Монголын нууц товчоо, 2006, хууд. 81).

Татарын өнчин хөвүүн Шихихутуг болон Өүлэн эхийн өсгөсөн 4 өргөмөл хүү нь Монголын эзэнт гүрнийг хамт бүтээлцсэн гавьяат зүтгэлтнүүд болжээ. Энэ нь монголын төрд зүтгэх хүмүүсийг бүр багаас нь гэр сургалт, гэрийн хүмүүжлээр сургаж, хүмүүжүүлж бэлтгэдэг байсны уламжлал юм.

Энэ нь цаашид үргэлжилсээр төрийн хэргийг үргэлжлүүлэн уламжлан захирах хөвгүүдийн сургууль бий болсон байна. Юань гүрний үед түшмэдийн албанд бэлтгэх албан сургуулийг байгуулж, түшмэлийг сонгох нарийн журам тогтсон байв. Энэ тухай баримтыг сийрүүлбэл, Юань гүрэн байгуулсан эхэн үед олон замд монгол үсгийн сургуулийн сургагч түшмэл байгуулав. Зарлиг “Олон замын даргач нарын хөвүүн, дүү нар, хайрын түшмэл сарних фу, олон жоугийн хөвүүд, дүү нарыг олон сянь-ий даргач болгоод, олон сянь-ий хөвүүд, дүү нарыг цагдагч түшмэл болгов”. [Хянан байцаах газар] Үйши тай яамны дяньши түшмэлийг халж души түшмэл болгов. Харагчин хонин өдөр цэргийн түшмэлийн зэрэг дэсийг тогтоосон нь түмэн өрхт, нийтийн дарга, мянган өрхт, зуун өрхт, зунба (zong ba) нарыг цэргийн ардын алба болгов. [Юань улсын судар I, 2021, хууд. 170] [Засгийн хэргийг тэгшлэн шийтгэгч] Пинжан жэнши түшмэл Атахай, Али нарт тохиож мөрний өмнө чийрэг чадалтай түшмэлийг сонгож сул түшмэл ба тушаалыг чадварлахгүй түшмэлийг байлгагтун хэмээв [Юань улсын судар I, 2021, хууд. 243].

Манж Чин улсын үед томоохон түшмэд нь тайж нарын үр хүүхдүүдээс бичиг үсэгт гарамгай нэвтэрснийг сонгон ажиллуулж байсан бол хошууны дундаас доош зэргийн албан тушаалд харц гаралтай ардуудаас чадварыг харгалзан сонгон ажиллуулж байв. Харин тамгатай хутагтын шавь нар болон Богд Жавзандамбын эрдэнэ шанзудбагийн яаманд харц гаралтай хүмүүс сонгогдон ажиллаж байв. Тусгаар тогтнолоо сэргээсний дараа Богдын засгийн газраас Нийслэл Хүрээнд тусгай сургуулийг нээн ажиллуулах болов. Энэ тухай архивын бичгийг дурдвал, аргын тооллолын 1912 оны 03 дугаар сарын 27-нд Нийслэл хүрээнд язгууртны хүүхдийн сургууль байгуулах тухай Дотоод яамнаас Сангийн яаманд явуулсан бичигт:

Явуулах учир:

Эдүгээ олноо өргөгдсөний тэргүүн он өвлийн сүүл сарын гучинд манай Дотоод яамнаас айлтгасан аливаа насан бага ван, гүн, засаг, тайж ба тэдний хөвгүүд дүү нарыг авч олон үсэг бичгийн сургуульд оруулж боловсруулах явдлыг нугалбар бичиж айлтгаад, Богд эзэн гэгээнээр толилуулахыг гуйхын учир:

Эдүгээ манай Монгол тулгуур төр тогтоогоод олон монголчуудыг амар жимэр аж төрүүлсэн учир шашин төрд улмаар тустай сайн болгох явдлыг шавь боол Цэ /Цэрэндорж/... нар санаа тавьж мэхийн хянаваас, түүний үндэс гагцхүү түшмэдийн засгийг бадруулах эрдэмтэнд хурмуй.

Тэр нь улс төрийн багана дам нурууны адил бөгөөд түүний үүсвэр бичиг үсгийн сургуулийг эрхэмлэн боловсруулахаас өөргүй, үүнд, ялангуяа язгуураас үе улиран байгуулсан олон засаг ноёдын дотроос эрдэмтэн гарах болбоос чухамхүү нэн тустайн тулд олон ноёд ба ноёдын хөвгүүдийг сургууль хийлгэхийг урьтал болговоос зохино.

Эдүгээ манай монголчууд тулгуур төр нээн байгуулсан нь Богд эзний сүр буянд энх жаргалын туйлыг бараалхан хүртсээр бөгөөд өчүүхэн ч айх бачимдах хэрэггүй гагцхүү шавь боол Цэ... нар эзний хишгийг хүртэж албан хаан явуулсан нь улс төрийн албан хэрэгт үнэн санаагаар зүтгэж түмэнд нэгэнт хариулахыг хичээх бөгөөд маш айн болгоомжилно.

Мэхийн хянаваас, улс болох нь эрдэмтэд итгэх бөгөөд эрдмийн эхийг эс бадруулбаас төгссөн хүн гарч үлэмж хэрэглэх гавьяаг хурааж үл чадахын тулд харьяат дөрвөн аймаг шавь таван газрын тайж, ард бага хөвгүүдийг тоо тогтоон тусгайлан сургаж боловсруулан бүхүй боловч ер ван, гүнгийн хөвгүүдийг сургуульд оруулсан газаргүй амуй.

Насанд хүрээгүй ван, гүн ба тэдний олон хөвгүүд болбоос үе улиран улс төрийн хүнд хишгийг хүртэж олон доод ардыг тусгайлан захиран баримтлах эрх бүхүй нь элдэвлэвч хүнд чухалд холбогдсон бөгөөд багад боловсорч төгсвөөс их болсны хойно элдэв хэрэг шийтгэхэд итгэж хэрэглэвээс хоосоор оролдсон тушаалыг гутаахгүй болон чадахын тулд, зүй нь, аливаа нас бага ван, гүн, тайж тэдний хөвгүүд, дүү нар арван наснаас дээш хорин насанд үл хүрснийг сонгон авч цөм өөр өөрийн хувийн хүчийг хэрэглүүлэн манай Дотоод яамны газар суулгаж монгол, орос, манж, хятадын зэрэг олон үсэг бичиг сурган боловсруулж тэднийг хорин нас хүрсэн цагт татан буцааж явуулбаас болох үл болох явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад, Богд эзэн гэгээнээр толилж заалхийлэн сургаж, дагаж явуулах ажааму.

Үүний тул хичээнгүйлэн айлтгав.

Зарлигийг гуймуй хэмээн айлтгасанд мөнхүү өдөр хүлээн авсан уг нугалбарт, улаан бийрээр цохсон зарлиг: Гуйсан ёсоор болгогтун гэснийг хичээнгүйлэн дагаж уг айлтгасан нугалбар буулгасан зарлигийг ёсоор сийрүүлж дөрвөн аймгийн чуулганы дарга, жанжин нарт тус бүр тушаан явуулаад хичээнгүйлэн журамлан дагаж уламжлан харьяат газар тушааж өөр өөрийн аймгийн насан бага ван, гүн, засаг, тайж нар мөн тэдний хөвгүүд дүү нарыг өөр өөрийн хувийн хүчнээс хэрэглүүлэн цөм энэ жил зуны тэргүүн сарын шинийн нэгний урьд манай яамны газар илгээн ирүүлж үсэг бичиг сурган боловсруулж эрдмийг бадруулахад бэлтгүүлэн, Богд эзний нигүүлсэн өршөөсөн туйлын таалалд нийлүүлсүгэй хэмээхээс гадна сургуульд оруулбаас зохих арван наснаас дээш хорин насанд үл хүрэх ван, гүн, засаг, жич хөвгүүд, дүү нарын нэр насыг цэс үйлдэж энэ жил хаврын сүүл сарын дотор мэдүүлэн ирүүлээд байцаахуйд бэлтгүүлье.

Үүнийг басхүү эрхэм дөрвөн яамнаа хуваан явуулъя. Үүний тул илгээв.

Олноо өргөгдсөний хоёрдугаар он, цагаан сарын шинийн есөн (Б.Чимид, 2010, хуудсд. 43-44)

Төрийн албанд ажиллах түшмэдийн чадварыг харгалзан тусгай чухал үүрэг хариуцуулах, хариуцлагатай албан тушаалд тохоон томилсон олон баримтыг эх хэрэглэгдэхүүнд хавсралтаар оруулсан тул үүгээр хязгаарлая.

4.6. Төрийн албан хэрэг хөтлөлтийн уламжлал

Сүүл үеийн археологийн шинжилгээний олдворуудаар монгол нутагт оршин тогтнож байсан хаант улсуудын бичиг үсгийн соёлын тухай материал өргөжиж байна. Үүнээс гадна олон музей, архив, номын сан зэрэгт хадгалагдаж буй эх хэрэглэгдэхүүн нь монголчуудын албан бичиг хэрэг хөтлөлтийн уламжлалыг тодруулахад үнэт сурвалж болно. Жишээлбэл, Их Монгол Улсын гуравдугаар хаан Гүюгээс 1246 онд Ромын пап IV Инносентэд илгээсэн захидал юм. Тэрхүү захианы бичигт “Мөнх тэнгэрийн хүчин дор. Их Монгол Улсын Далайн хааны зарлиг ил болгон иргэн дор хүрвээс биширтүгэй, аюутугай” гэсэн үсэгтэй төрийн тамга дарагдсан байв.

Бидний судалгааны хүрээнд төрийн албан бичиг хэрэг хөтлөлтийн уламжлалтай холбогдох 60 баримтыг түүвэрлэн авч эх хэрэглэгдэхүүнд оруулав. Эдгээрт задлан шинжилгээ хийж, онцлох баримтыг сийрүүлэн тайланд тусгав.

Сүүл үеийн судалгааны нээлтүүд, эх бичиг судлаачдын бүтээлээс үзэхэд уйгур үсгийг Чингис хаанаас өмнө тал нутгийн монголчуудын дунд хэрэглэж байсан нь тодорхой болж байна. Учир нь Их Монгол Улсын үед уйгур үсэг (худам монгол бичиг) нь нэгэнт хэлбэржин тогтож хөгжсөн байжээ. Иймд, Чингис хаан үүнийг Их Монгол Улсын төрийн бичиг үсэг болгож албан бичиг хэрэгт хэрэглэх болов. Үүнтэй холбоотой нэгэн сурвалжийг дурдвал, “Гүр иргэний хувь хувилсаныг зарга шүүсэнийг хөх дэвтэрт бичиг бичиж дэвтэрлэж, ургийн ураг хүртэл Шигихутугийн надтай зөвлөж ёсоор [болгон] хөх бичиг цагаан цаасанд дэвтэрлэснийг бүү өөрчилтүгэй. Өөрчилсөн хүнийг яллах болтугай” хэмээн зарлиг болов (Д.Цэрэнсодном, 2000, хууд. 134) хэмээжээ.

Их Монгол Улсад дорно, өрнийн улсуудаас элчээр ирж байсан хүмүүсийн тэмдэглэлд төрийн албан хэрэг хөтлөлтийн талаар дэлгэрүүлж болохуйц байна. Өмнөд Сүн улсын элч нарын тэмдэглэлд, “Одоо болтол бусад улсад явуулах бичиг хараа нь уйгур үсгийг хэрэглэх юм. Бичиг үсэг нь хятад улсын бишгүүрийн аялгууг тэмдэглэдэг тэмдэг шиг юм. Ойрын хоёр жилээс нааш Алтан улсаас урваж дагасан түшмэд орших газар үгүй болж, дуртайяа тэдэнд зарцлагдаад бичиг үсэг зааж өгөх болсноос нааш Алтан улс лугаа харилцахад харин хятад үсгийг хэрэглэх болжээ. Ноднин хавар Хун, би, тэдний явуулж байгаа бичиг харааг үзэхүл, харин бас их төр гэж бичих ба оны нэрийдлийг туулай, луу гэж дурдаж, ноднин жилээс усан цагаан луу жил гэж өөрчлөж, мөн оныг цагаагчин могой жил гэв (Ж.Баясах, 2006, хуудсд. 160-161).

Тэдний үйл явдлаа үзгээр тэмдэглэхийг үзвэл, атирсан могой чийгний

хорхой олж гурвалзах дүрс шиг, бас “Тэнгэрийн бичиг” бөгөөд тарнийн толгой үсэг адил, дуу хөгжимийн аялгууны тэмдэг: у, фань, гун, чи гэж бичсэн шиг харагдана. Уйгур үсэг лүгээ ах дүү мэт төстэй үсэг юм. Уйгур газар явуулж байх нь уйгур үсэг болно. Үүнийг Жэньхай эрхэлнэ. Уйгур бичиг 21 үсэгтэй. Үүнийг холбон хавсруулж үг болгодог юм. Хятад хийгээд Кидан, зөрчидийн зэрэг олон мөхсөн улсад явуулж байгаа баримт бичгүүдийг зөвхөн хятад үсгээр бичдэг буюу. Үүнийг Елюй Чуцай эрхэлнэ. Чингээд албан бичгийн төгсгөлд, өдөр сарын өмнө бас Жэньхай өөрөө уйгур бичгээр, үүнийг хэн хэнд тушаав гэж бичнэ. Энэ лав тусгайлан Елюй Чуцайг сэрэмжлэх учирт эрхиш уйгур үсгээр гэрч болгосон бөгөөд, ийм бус бол албан бичигт үл тооцогдмуй. Эрхиш Жэньхайгаар бичиг дамжуулж өнгөрүүлдэг нь мөн л харилцан хянан байцаалгахын учирт буюу (Ж.Баясах, 2006, хуудсд. 249-250). Дээрхээс үзэхэд аль газар явуулж буйгаас шалтгаалж өөр өөр үсгээр үйлдэж байсан ч түүний төгсгөлд нь тэргүүн сайд Чингай уйгур үсгээр баталгаажуулж явуулж байжээ. Энэ нь тухайн үед уйгур үсэг нь төрийн бичиг болсон нь тодорхой байна.

Мөн үед гадны элч нарыг хэрхэн хүлээн авах, тэдний үгийг бичигт тэмдэглэж авах нарийн дэг ёс тогтсон байна. Үүнийг Ромын пап ламын элчийн тэмдэглэлээс үзэж болно. “Их хаанд биднийг бараалхуулах болоход тэргүүн түшмэл Чингай биднийг хэн болох, хэний элчин болж ирсэн болохыг ийн уунгүй бичиглэж аваад их хаан болон бусад бүх ноёдын өмнө өндөр дуугаар уншин сонсгов (Карпини, 1988, хууд. 72). Үүний дараа эзэн хаан бидэн рүү тэргүүн сайд Чингайгаа илгээж ярьж хэлсэн үг, ямар үүрэг хүлээснийгээ бичиж өгтүгэй хэмээн хэлүүлжээ. Бид ч Батад хэлсэн үгээ дээр өгүүлсэнчлэн нэгд нэгэнгүй бичиж ёсчлон гүйцэтгэв (Карпини, 1988, хууд. 75). Мөн бусад элч нарын тэмдэглэлээс үзэхэд монголчууд гадаад улсад явуулах бичгээ уйгур үсгээр болон тухайн орны хэлээр давхар үйлдэж явуулж байсныг олонтоо тэмдэглэсэн байдаг нь тэр үеийн албан бичиг хэрэг хөтлөлт нэгэнт хэлбэржин тогтсон нарийн дэг журмын дагуу явагдаж байсныг илэрхийлдэг юм.

Монголын эзэнт гүрний хэмжээ өргөжин тэлсэн үед Хубилай хаан зарлиг гаргаж “хуучин уйгур үсгийг хэрэглэсэн нь бүлгээ, монгол үсгээр халагтун” (Юань улсын судар I, 2021, хууд. 249) хэмээснээр шинээр зохиосон монгол үсгийг төрийн албан хэрэгт ашиглах болов. Энэ тухай монголын түүхийн тулгуур сурвалжуудад тэмдэглэсэн нь: Шарагчин могой, Жи Юань-ий зургадугаар он, хаврын дунд сард, улсын багш Пагва лам өөрийн зохиосон монгол дөрвөлжин үсэг, эдүгээ цагийн дөрвөлжин үсэг хэмээн алдаршсан түүнийг бичиж, хаанд айлтгасанд хаан маш зөвшөөн сайшааж бүрүүн. Бүх улсдаа жуу бичиг буулгаад, нийтэд зарлиг явуулбай. Тэр бичгийн үг:

Би санаваас, бичгийн үсгээр хүлээн явдлыг тэмдэглэх нь, эртнээс тогтоосон ёс амуй. Эдүгээ манай манай улс язгуур ер бүгд үнэнч шударга бүхүйн тул, бичгийн үсэг эс зохиожээ. Хэрвээ, бус улсад бичиг явуулахуй бөгөөс хятад буюу уйгур улсын бичгээр манай улсын үгээр ухуулмуй. Бус бээр Ляо улс ба Алтан



улс хийгээд жич, хол ойрх олон улсыг үзвээс, цөм өөр өөрийн харьяат үсэг нь буй бөгөөд, эдүгээ манай улс бичгийн ёсыг улмаар эрхлэн бөгөөтөл бидний харьяат үсэггүй бөгөөс л, манай төр ёс омтгой болмуй хэмээн санаж бүрүүн. Даруй улсын багш Пагба ламд тушааж, монгол үсгийг зохиолгоод, дэлхий дахины нийтэд тархаавай. Аливаа зүйлийн бичгийг орчуулж бичихүйдээ, үг нь найртай болоод, тэр хэргийн шалтгаан утгыг нь тодорвоос төгсвэй зэ. Үүнээс хойш аливаа явуулах бичгийг монголын үсгээр бичээд, бус улсын үсгийг зэрэгцүүлэн хадтугай хэмээлээ (Рашпунцаг, 2006, хуудсд. 180-181).

Мөн “тэндээс өдий төдий болсон хойно хаан, Пагва ламд зарлиг болруун: Энэтхэг, хятадулсад өөр өөрийн үсэг буй бөгөөтөл манай Монгол Улсад үсэг үгүй тул чи үсэг гаргагтун!” хэмээн зарлиг болсонд, Пагва лам монголд дөрвөлжин үсэг гаргаж, монголын билигтэй хүүхдийг цуглуулж сургаал (сургууль) хийв (Гомбованжил, 2006, хууд. 46)”. Уйгар үсгээр төрийн албан хэрэг хөтөлж байсан цаг үед Хубилай хааны зарлигаар Пагва ламын зохиосон монгол үсэг нь эдүгээ өрнө дахинд зохиогчийнхоо нэрээр нэрлэгдэх болсон дөрвөлжин үсэг юм. Юань гүрний хэмжээнд их хаан монгол үсгийг нэвтрүүлэх гэж хичээж байсан бөгөөд олон хэлээр энэ бичгээр албан бичиг хэрэг үйлдэгдэж байв.

Юань гүрний үед төрийн албан хэрэг хөтлөлтэй холбоотой нэгэн чухал зарлиг гарсан нь “аливаа хэрэг айлтгахад эрхгүй урьд нөхөд түшмэлтэй айлтгахыг хэлэлцэгтүн. Айлтгасан хойно буулгасан зарлигт юун хэмээснийг нөхөд түшмэлд мэдүүлсэн хойно дэвтэрт бичигтүн. Тодорхой ухуулахгүйгээр даруй дэвтэрт бичвээс бичигчийг чавчиргадагтун хэмээв (Юань улсын судар I, 2021, хууд. 312). Айлтгал, шийдвэрийг нягтлан шалгаж байж бичгээр үйлдэх болсон нь албан хэргийн хөтлөлтөд хяналт тавьж байсан уламжлал болно.

Монголчууд эх нутагтаа эгсний дараа ч хөрш зэргэлдээ улс орнуудтай албан бичиг солилцож байсан арвин мэдээ баримт байна. Мин улсын сударт тэмдэглэгдсэн нэгэн мэдээг иш татвал, “Хунжы-гийн тэргүүн оны зун, Шяованзы бичиг өргөн барьж алба барихыг хүссэн бөгөөд, өөрийгөө Их Юань улсын их хаан хэмээн нэрлэжүхүй. Засгийн газар уужуу тайвнаар хандахыг хичээж, үүнийг зөвшөөрөв (Мин улсын судар (Олон шастир). III боть, 2018, хууд. 159). Хөрш зэргэлдээ улсын хаадыг хятадууд Шяованзы буюу “бага хаан” хэмээн хожмоо түүх сударт бичиж үлдээсэн ч тэр үедээ Их Юань улсын хаан нэрийдэж байсныг Батмөнх Даян хааны үеийн дээрх дипломат бичгээс үзэж болно.

Монголчуудын албан бичиг үйлдэхдээ, хөрш улсын хаад, эрэмбэ дээгүүр, эн сацуу, доогуур хүмүүст явуулж байсан бичгүүдийн хэв маяг нь тогтсон хэлбэртэй байсныг Зүүн гарын хаан Галдан бошготын бичгүүдээс үзэж болно. Тухайлбал, түүний Манж Чин улсын хаан Энх-Амгаланд явуулсан бичиг эхлэхдээ: “Өөлдийн Галдан бошогт ханы айлтгах нь. Агуу их Замбутивийн зүүн этгээдэд, хүнийг магад ялгуусан алдар нэр арван зүгт алдаршсан, тэнгэр газрын эрхт Амгалан хааны гэгээнээ айлтгах учир” (Дайчин гүрний дотоод

яамны монгол бичгийн гэрийн данс. V боть, 2010, хууд. 132) хэмээсэн бол Халхын Жавзандамба хутагтад явуулсан бичигт, “Бор талаас Жибзундамбын дэргэд өчих учир” (Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс. VI боть, 2010, хууд. 59) гэсэн байдаг. Энэхүү албан бичгийн хүндэтгэл нь Манж Чин улсын үед залгамжлагдаж байсныг тэр үеийн орон нутгийн ноёдын хооронд явуулсан захианаас илэрхий байна.

Данс шүүхэд туслуулахаар дуудсан туслагч Самгарьд, тайж Гарам нар саатсан учрыг гаргаж Гандандоржоос Хэбэй гүнд илгээсэн захидал

Захиа. Муу ах Гандандорж бээр Хэбэй гүн, өршөөлт мэргэн дүүгийн амгаланг эрмүй. Энэ учраа өршөөлт дүүгийн буянтай бие амгалан, өргөө хөвчөөр амар, албат сүрэг мэнд аливаад баясгалан бэлгэтэй сонин зүйл юу болов. Албан ба алин зүйл өөрийнхөө таалалчлан амуй. Жич, эрхэм хошуунаас данс шүүхэд хэрэг туслуулахаар дуудсан туслагч Самгарьд, тайж Гарам нар тус тус саатсан нь үнэнхүү бөгөөд эдний оронд эрхэм хошуунаас чадах түшмэл бичээч нар хошоодыг дуудахаар илгээсэн. Үүнд, өршөөлт дүү түүгээр чангалан тушааж эрхгүй илгээхийг гэрийн хэрэг болгон гуйхаас гадна таван хошууны албаны учрыг жанжин сайдад мэдүүлсэн сайх хэргийг даруй нийлэн хэлэлцэж нэгэн болгож мэдүүлэхээр тушаан ирснийг миний газраас харьяат аймгийн чуулган уулзахыг бүр нэгмөсөн болгож энэ таван сард Алдар газарт нийлье. Гагцхүү хурах өдрийг түүгээр тогтоомуу хэмээн жанжинд зөвлөснийг сонгохоос гадна бидний тушаалуудад аймгаас энэ мэт албан туслуулахаар дуудагчдаас эс ирэх нь олон бөгөөд ер уг тушаалыг хэрэгсэж огт ирэхгүй байн байсаар хойч өдөр албан хэрэг осолдох цалгардахыг үгүй болгож үл чадахаас эргэлзэх тул яахин болговоос хойч өдөр хэрэгт тус бүхийг толилмуу. Эдний дотроос өвчнөөр шалтгаалж эс ирэгчдийн тоо хэд болохыг үзэж өөр байцаан шийтгэе. Энд муу ахын бие ба гэрийн бүхнээр дүүгийн ивээлд эсэн мэнд тушаалын хэрэг тайван өөр сонин хэмээлтэй нь үгүй тул олныг бичихийг байж үүний тул тусгайлан нугалбар үйлдэж амгаланг эрмүй.

Тэргүүн сарын 16

(МУУТА, ТБА. ХМ-170. Д-1. Хн-124. Б-3. Эх).

Богд хаант Монгол Улс байгуулагдсан даруйд төрийн албан бичиг хэрэг хөтлөлт нарийн тогтсон дэгийн дагуу явагдаж болов. Эдгээрийг аргын тооллолын 1912 оны 02 дугаар сарын 24-ний өдөр таван яам харилцан албан бичиг бичиглэхэд өргөн хэмээх үсэг хэрэглэх эсэх зэрэг явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгасан айлтгал, хариу зарлигаас сийрүүлье.



Шавь боол Цэ, Го, Цэ сөгдөж хичээнгүйлэн айлтгах нь таван яам харилцан албан бичиг бичиглэхэд өргөн хэмээх үсэг хэрэглэх эсэх зэрэг явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад Богд эзэн гэгээнээр толилж, заан сургахыг гуйхын учир саяхан манай Монгол Улс тулгар төр нээн тогтоож, таван яам байгуулснаас элдэв албаны учир харилцан бичиглэхэд манай Дотоод яам нөгөө дөрвөн яаманд цөм нэгэн адил өргөн илгээв хэмээн бичсэн. Сан, Цэрэг, Шүүх гурван яам манай Дотоод яаманд цөм өргөн илгээв хэмээн бичиж ирмүй. Гагцхүү Гадаадын яам илгээв хэмээн бичихийг ирэх бөгөөд харилцан дор адилгүй болсон. Үүнд шавь боолчууд хянан байцааваас анх Зарлигийг дагаж таван яам байгуулахад ерөнхий олон улсын журмыг дагасан буюу. Манай Дотоод яам тэргүүлэгч яам болгосон боловч шавь боол Цэ нар эелэл эвлэлийг чухал болгон нөгөө дөрвөн яамыг нэгэн адил сүслэн өргөж, чацууд үзэн албан бичигт өргөн хэмээх үсэг хэрэглэсэн бөлгөө. Сан, Цэрэг, Шүүх гурван яам нэгэн адил өргөн хэмээх үсэг хэрэглэсээр тул ер шүүмжлэх зүйлгүй болой. Гадаадын яам гагцаар бусдаас онц болон ямагт илгээв хэмээн бичих нь харин дор үзсэн мэт боловч өчүүхэн тэмцэлдэх явдалгүй.

Гагцхүү одоо Дээр айлтган тогтоолгож журамлан дагаж явахгүй болбоос өдөр удах тутам дүрэм болсоор харин хожмын албан хаагчид өгүүлэл тэмцэл болон балар будилаан өдөж, хол дахь ойр дахинд шүүмжлэгдэх болуужин хэмээн болгоомжлохын тулд хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад гуйх нь Богд эзэн гэгээнээр толилж үүнээс урагш аливаа албаны бичигт манай таван яам харилцан өргөн хэмээх үсэг хэрэглэх, эсэх хэрвээ хэрэглэвээс зохих, үл зохих зүйл буй ахул алин нь алинд өргөн илгээв, алин нь алинд илгээв хэмээн бичиж явбаас урьд дотоод, гадаадад шүүмжлэлгүй болон улам улмаар тэргүүлэх, дэдлэх ёс журмыг мэдэж улсын сүрийг гутаахгүй болохыг Дээрээс заалхийлэн буулгаж дагаж явуулахыг хичээнгүйлэн хүсмүй. Үүгээр хожмын будилааныг ариутган ёс журмыг илэрхийлсүгэй хэмээмүй. Үүний тул хичээнгүйлэн айлтгав.

Зарлигийг гуймуй хэмээн айлтгасанд мөнхүү сарын шинийн долооноо хүлээн авсан уг нугалбарт улаан бийрээр цохсон Зарлиг Дотоод яам угаас тус улсын дотор тэргүүлэгч ахмад яам мөн. Гагцхүү манай улс гадаад лугаа найрамдахыг эрхэмнэн гадаадын хэргийг чухал болгох тул Гадаадын яамыг дэд болготугай. Бас улсыг хамгаалах үндэс цэрэг буй тул Цэргийн яамыг гутгаарт болготугай. Сангийн яамыг дөтгөөрт болго, Шүүх таслах яамыг тавдугаарт болгон харилцан бичиглэхэд зэрэг дэвийг үзэж дээдэх яам доорогш бичихүй дор илгээв хэмээх бичиж, доорх яам дээш бичихэд өргөн хэмээн бичиж үүрд дагаж явуулагтун хэмээв

(МУУТА. ТБА. ХА-3, Д-1, ХН-16, хуудас 2а-4а).

Энэ үеэс албан хэрэг хөтлөлтөнд олон газар мэдүүлэх явуулах бичгийг уул газраа хэзээ хүрэх ба гаргасан өдөр жич өртөөдийн хүлээн авсан сар өдөр цагийг тодорхойлон бичүүлж байхаар тогтсон байна.

Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны бичиг. Дөрвөн аймгийн чуулганы дарга жанжин нарт тушаан илгээв. Тушаан явуулах учир ноднин өвөл цаг манай яамнаас Нийслэл Хүрээний зүүн баруун тийш Халх нутгийн зах хүртэл тус тус шинэ тутам өртөө байгуулж аливаа явж зорчих түргэн чухал алба нэвтрүүлэхэд дав дув болговоос зохих явдлыг айлтгаад зарлиг ёсоор болгосныг хичээнгүйлэн дагаж мөнхүү өртөөдийн алба дагнуулах өрхийн хүн нар ба захирах түшмэд жич суурь бүрийн занги бичээч нарыг харьяат дөрвөн аймгаас нийгэмчлэн гаргаж хуваан суулгах ба бас мөн өртөөдөөр явж зөрчих элдэв албаны дүрэм хэмжээ тогтоож зүйл дараалан ялган салгаж зохих газруудад нэгэн адил зарлиг тушаасны дотор олон хошуу шавийн газраас түргэн чухал мэдүүлэх явуулах албаны бичгүүдийг элчид авхуулан илгээхийг хэрэгсэхгүй болгож алгуур түргэн хэмээх ялгаваргүй цөм нутгийн хол ойрыг бодож уг бичиг хэдэн хоногт хүрвээс зохих хугацааг бичиж басхүү тусгай хуудас бичиг гарган дугтуйн гадна наалдуулж дагалдуулан өртөөнд тушаан өгч мөн өртөөд хүлээн авч дамжуулсан сар өдөр цагийг мөнхүү хуудсанд нэмэн бичиж саатуулахгүй улам улмаар довтолгон зохих газар хүргэгтүн. Бас аливаа өртөөний улаач нар өртөөгөөр дамжуулсан албаны бичгийг элэгдүүлэн урж тамтаглах, эсвээс хагасалж үзээд өдөр удаашруулан явуулахгүй будилаантуулах зэргийн гэм илэрхий болсны тул, үүнээс урагш алгуур түргэн албаны бичгийг цаг мөчөөр саатуулах ба хагаслахгүй болгон дамжуулж хааяа удаашруулсан нь буй болохул аль газар яахан саатуулсан зэргийг хойш мөрдөн сурвалжилж эрхгүй олж хүндэд цээрлүүлэн шийтгүүлбээс зохимуй хэмээснийг данснаа тэмдэглэжээ. Байцааваас Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгийн Да жанжин нар ба олон хошуудаас мэдүүлэн ирсэн бичигт шийтгэн гаргасан сар өдөр цагийг хуудас бичсэн боловч хэзээ уул газраа хүрэхийг бичсэнгүй мөн нийслэл хүрээний зүүн зүг байгуулсан өртөөний зарим нь хүлээн авсан сар өдөр цагийг огт бичсэнгүй. Засагт хан, Сайн ноён хан хоёр аймгийн Да жанжин олон хошуунаас манай газар мэдүүлсэн бичигт хэдэн өдрийн дотор хүрэхийг бичсэнгүй, бас дугтуйн гадна шийтгэн гаргасан сар өдрийн цагийг хуудас бичиж наалдуулсангүй бас нийслэл Хүрээнээс баруун тийш байгуулсан өртөөд цөм бичгийн дугтуй дээр тус тус хүлээн авсан сар өдөр цагийг бичсэнгүйн улмаас баруун зүгийн олон газраас мэдүүлсэн элдэв түргэн чухал албан бичиг нэн их саатаж арваад өртөөний чинад газраас нэг сар илүү болж хүргэн ирж буйг үзвээс эдүгээгийн чухал цагт элдэв түргэн мэдээ авалцах зэрэг алба саатагдаж хүнд будилаан үүдэхэд хүрэхийн дээр тогтоон тушаасан дүрэм хэмжээ хоосоор хоцрогдоход хүрсний тулд үүнийг дөрвөн аймгийн чуулганы дарга нарт нэгэн адил дахин довтолгон тушаан явуулаад хүрмэгц бичгэн доторхыг хянан үзэж басхүү манай Дотоод яамнаас дугтуйн гадна наалдуулсан хуудсыг дүрэмнэн улам улмаар залган бичиж хүргүүлэхийг өөр өөрийн аймгийн олон хошуу жич өртөөдийн захирал, туслагч занги бичээч нарт нэгд нэгнээр чангалан ухуулж зарлан тушаагаад урьд эдүгээгийн тушаасан ёсоор журамлан дагаж явуулсугай. Мөн урьд адил үл мэдээчнээр зөрчин явбаас тухайд зохигчдыг шууд дэс дараалан хүндэд шийтгэх явдлыг хамтаар ухуулан үүний тул тушаан илгээв.

Олноо Өргөгдсөний хоёрдугаар он, зуны тэргүүн сарын шинийн найман

[МУУТА, ТБА. ХА-3, Д-1, Хн-11, хуудас 126-129а]

Ийнхүү Богд хаант Монгол Улсын үед төрийн албан бичгийн уламжлал улам төгөлдөршиж, нарийн дэг жаягийн дагуу явагдаж байв.

4.7. Төрийн албаны ёслол, хүндэтгэлийн хүрээний уламжлал

Монголчуудын бий болгосон төрийн ёслол, хүндэтгэл бол өргөн хүрээний ойлголт тул олон салбар шинжлэх ухааны эрдэмтэд өөр өөрсдийн чиглэлээр судалж ирэв. Энэхүү төслийн нэгэн гол зорилт нь захиргааны түүхийн үүднээс монгол төрийн албаны ёслол, хүндэтгэлийн уламжлалыг тодруулах юм. Энэ хүрээнд эх сурвалжуудыг шүүж 46 баримтыг түүвэрлэн эх хэрэглэгдэхүүнд эмхэтгэж оруулав. Сонгосон баримтуудад дүн шинжилгээ хийж төрийн албаны ёслол, хүндэтгэлтэй холбоотой онцлох зарим уламжлалыг товчоор тайланд тусгалаа.

А. Хаан ширээнд өргөмжлөх ёслол

Дундад зууны үеийн түүхэн эх сурвалжуудад хаан өргөмжлөх ёслол, түүний дэг жаягийн тухай тэмдэглэн үлдээжээ. Түүнээс нэгийг сөхвөл "... Амагар (МНТ:Амбагай) хаан Хадаан, Хутала (МНТ: Хутула) хоёрыг нэрийдсэнээр, Хамаг Монгол, Тайчууд, Ононы Хорхог жигүүр (МНТ: Хорхонаг жубур)-т Хутала-г хаан болгов. Хадааныг тайш болгов. [Монголын жаргалан дэвсэн хуримлан жаргах бүлгээ. Хутула-г хан өргөөд Хорхонагийн саглагар модон орчин хавиргад хуулга] өвдгөөс үлэг (МНТ:өвдөгт өлхөг) болтол дэвсвэй (Лувсанданзан, 2006, хуудсд. 42-43)" хэмээжээ.

Харин Их Монгол Улс байгуулагдсаны дараа хаан ширээнд өргөмжлөх ёслол өндөр түвшинд зохион байгуулагдах болов. Өгөдэйг их хаанд өргөмжлөх арга хэмжээнээс энэ тухай дэлгэрэнгүй харж болно. "...Хэрлэн нутагт цэргийн ноёд, түшмэд гурав хоног хуралдай чуулж алжаалаа тайлж наадан цэнгэж байгаад төрийн хэрэг явдал ба хаанчлалын тухай яриа хөөрөө дэгдээв." Чингис хааны гэрээслэл ёсоор хааны эрхэм хүндэт албанд Өгөдэйг өргөмжлөхөд тэрээр татгалзсан бөгөөд түүний хариуд хан хөвүүд санал нэгтэйгээр "Чингис хаан бүх хөвүүд ах нарын чинь дотроос чамд л энэ аугаа их хэргийг даатгаж, түүнийг манлайлах эрхийг чамд л үлдээсэн шүү дээ. Түүний шулуухан, тушаал, халдашгүй тогтоолыг яахин хувиргаж өөрчилж болохсон билээ" гэв. Мөн "ихэд хүсэж, гуйсан, олонтоо уулзаж зөвлөлдсөний дараа Өгөдэй эцгийн тааллыг дагах, авга нар, ахсын зааврыг дагах нь чухал гэж үзээд зөвшөөрлөө өгчээ. Бүгд малгайгаа авч, бүсээ тайлан мөрөн дээгүүрээ тохлоо" хэмээжээ. Мөн цааш нь тэмдэглэхдээ "...Өгөдэй хааны баруун гараас Цагадай, зүүн гараас нь Толуй хан, бүсэлхийнээс нь түүний авга ах Отчигин түшиж Өгөдэйг хаан ширээнээ залав. Толуй хан аягатай сүү өргөн барихад хааны асрын дотор гадна байсан бүх хүмүүс есөнтөө өвдөг нугалан сөгдөж, улс гүрэн ба түүний хаан ширээнд заларсныг тохиолдуулан түүнд Энх-Амгалан хаан хэмээх хүндэт цол өргөмжлөв" хэмээсэн нь төрийн өндөр дээд ёслол болох хаан өргөмжлөх төрийн ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааны дэг жаяг, зан үйлтэй холбогдох томоохон баримт байгааг тодруулахын зэрэгцээ төрийн шийдвэр, хааны зарлиг, хуралдайн үйл явц, дэг, шийдвэр, хүндэтгэлийг маш тодорхой дүрслэн тайлбарласан байгаа юм. Мөн тухайн үед хаан өргөмжлөх ёслол хүндэтгэлийн

үйл ажиллагаатай холбоотой нэгэн зан үйлийг хийсэн нь “Хаан эрдэнэсийн санг авч ир гээд төрөл төрөгсөд ба гаднынхан нэгэн аймгийнхан болон цэргүүд, хүн бүрт өөрийн тайван өглөгч байдалдаа зохицсон бэлэг хүртээжээ” (Рашид ад дин, 2002, хуудсд. 15-17). Эндээс үзэхэд эзэн хааныг өргөмжлөх ёслол өндөр дээд хэмжээнд нарийн зохион байгуулалттай болж байв.

Б. Гэрэгэ, тамга хэрэглэх нь

Төрийн албанд ажиллах албан хаагчид олон тусгай эд зүйлсийг хэрэглэж байснаас онцлог зүйлс нь гэрэгэ юм. Их Монгол Улсын үед алтан гэрэгэ болон цагаан өнгөний бэлгэдэлтэй холбогдох уламжлалыг тодруулах баримтуудыг сийрүүлбэл, “... Алтан гэрэгэ-г тэргүүн зэргийн сайд зүүдэг бөгөөд гэрэгэ нь хоёр барс нүүр нүүрээрээ харсан сийлмэл дүрстэй. Үүнийг “барс арсалдаж байгаа алтан гэрэгэ” гэнэ (Баясах Ж., 2006, хууд. 179).

Марко Пологийн тэмдэглэлд, “... Тэрээр [Их хаан Хубилай Т.Б] онцгой гавьяа байгуулсан зуутын ноёдыг мянгатын ноёд болгож тэдэнд мөнгөн сав шагнахын хамт ноёдын гэрэгэ гардуулав. Зуутын ноён мөнгөн пайзтай, мянгатын ноён алтан буюу алтан мөнгөн хосолсон пайзтай, харин түмтийн ноён арслангийн толгой бүхий алтан пайз хэрэглэнэ. Эдгээр пайзны хүнд хөнгөний талаар хэдэн үг өгүүлсүгэй! Зуут, мянгатын ноёны пайз зуун хорин сайес²⁷ жинтэй, харин арслангийн толгойт пайз нь хоёр зуун хорин сайес татах бөгөөд бүгдийн дээр ийн нэгэн зарлиг бичсэн ажгуу. Үүнд: <<Мөнх тэнгэрийн ивээлээр ертөнц дахинд их хааны нэр сүр мөнхжин аливаа гэмтэн тэрсүүд нар арилан сөнөтүгэй>> гээд мөн тэр пайзан дээрээ тэр ноёны эзэмшил газартаа эрх тушаалаа хэрхэн эдлэх тухай бичсэн ажээ. Бас нэмэн өгүүлэхэд: Бумтын ноён буюу их цэргийн жанжин хүн дөрвөн зуун сайес хүнд алтан пайз хэрэглэнэ. Тэрхүү пайзны нүүрэнд дээрх зарлигийг бичиж, түүний дээд доод талд нар сар болон арслангийн дүрс сийлсэн байдаг. Тийм пайз бүхий хүн их хэрэг шийтгэх эрх тушаал хүлээж онцгой эрх дарх эдлэхийн дээр хаа газар морилон явахдаа ямагт бяцхан жууз дотор мөнгөн сандал дээр залрах бөгөөд энэ нь тэр хүний эрхэмсэг их ноён болохыг илтгэнэ.

Мөн их хаан зарим их ноёдыг элч мэдээчээр илгээхдээ шонхор шувууны дүрс бүхий пайз олгон, чингэснээрээ тэднийг өөртэйгөө адил эрх засаг бүхий болгон хааны агт морьдоос ч хэрэглэж болно хэмээжээ (Марко Поло, 1987, хуудсд. 90-91).

Баримтаас шинжлэхэд гэрэгэ нь ноёдын эрх хэмжээ, зэрэг дэв, алба, үүргээс хамаарч өөр өөр байжээ. Гэрэгэ-д түүний эдлэх эрх ямбыг шингээж өгсөн нь эзэмшигчийн хувьд чухал онцгой эрхийн бичиг болж байлаа.

Түшмэдийн хэрэглэх өөр нэгэн чухал зүйл бол тамга болно. Юань улсын сударт өгүүлснээр хас болон алтан тамгыг ямар зориулалтаар, ямар зэрэг түвшин хэрэглэж байсан нь тодорхой байна. “Шаргачин гахай өдөр өргөмжлөлд тамга хэрэглэхийг тогтоосон нь аливаа тархаах өргөмжлөл,

²⁷ Венецийн хүндийн хэмжүүр, ойролцоогоор 30 грамм.



тэргүүн, дэд зэрэгт болбоос хас тамгыг хэрэглэнэ. Гутгаар зэргээс тавдугаар зэрэгт хүртэл алтан тамга хэрэглэнэ. Түүний бичиг болбоос “[Хаан] Хуандигийн явах эрдэнэ” хэмээсэн нь сууринд суух цагт цутгасан бүлгээ. Гагцхүү тархаах зарлиг, ухуулах зарлигт хэрэглэнэ. Өөр тархаах өргөмжлөл алтан эрдэнэ цутгаж явуулжээ” (Юань улсын судар I, 2021, хууд. 141) гэжээ.

Манж Чин улсаас монголын олон ноёдод шинээр тамга өгч олгосон байдаг. Энэ тухай баримт дурдвал, “Халхын олон засагт тамга өгөв. Гадаад Монголын төрийг засах явдлын яамнаас айлтгасан нь, Халхыг дөчин есөн хошууны адил болгосны тулд дөчин есөн хошууны ёсоор тамга өгвөөс зохимуй (Биеэр дайлж өрнө умрын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг (дэвтэр: 1-13), 2019, хуудсд. 185-186) хэмээжээ. Манж Чин улсын үед тамгыг нээж, хаах зэрэг тусгай зан үйл үйлддэг байв. Гэвч үүнийг 1911 онд тусгаар тогтносны дараа монголчууд нэн даруй халав. Богд хаант Монгол Улсын төрийн тамганд монголын эртний төрийн бэлгэдлийг сэргээн хэрэглэж, үсгийг нь соёмбо, дөрвөлжин хоёр бичгээр үйлдэв. Тамганы дунд “Шашин, төрийг хослон баригч наран гэрэлт Богд хааны тамга” гэж бичжээ. Тамгыг олонд тархаах аливаа зарлиг, хэлтрүүлэх зарлиг, ухуулах, сургах лүндэн, жуух, шар торгон бичиг дээр дардаг байжээ. Харин бусад олон яам, аймаг, хошуудын гуулин тамганд дан монгол үсэг хэрэглэж, уг газрын нэрийг бичихийн дээр голд нь соёмбо сүлд урлаж, бариулыг нь хүслийг хангагч чандмань эрдэнийн дүрстэй үйлдэн, уул яам, газар, ноёдын эрх ямбанд тохируулан элдэв хэмжээ ба жинтэй цутгадаг байсан байна.

Түүхэн эх сурвалжид төрийн тамга, түүнийг хэрэглэх, хүндлэх зан үйлтэй холбоотой нэг баримт тэмдэглэгдсэн байгаа нь “Эрдэнийн тамганд ёслол мөргөж үзүүлэхээр тогтсон. Үүнд энэ арван хоёр сарын арван таванд манай Дотоод яамны сайд бараалхан мөргөж үзсэн тул одоо цагаан сараас эхлэн манай зургаан яам хошоод сараар ээлжлэн дараалж мөргөөд тухайд саатаж тасалдахгүй болговоос зохихын тулд жил бүр нэг, хоёр сард Бүгд ерөнхийлөн захирах яам, гурав, дөрвөн сард Дотоод яам, тав, зургаан сард Гадаад яам, долоо, найман сард Цэргийн яам, ес, арван сард Сангийн яам, арван нэг, арван хоёр сард Шүүх таслах яамнаас бараалхан мөргөж хэрвээ илүү сар тохиолдох болбоос манай дотоод яамны сайд бараалхан үзэж, мөргөн гүйцэтгэсүгэй хэмээх явдлыг Бүгд ерөнхийлөн захирах зэрэг таван яамнаа тус бүр сонсгон явуулаад ийнхүү дараалж гүйцэтгүүлэхээс гадна үүнийг басхүү Нийслэл Хүрээний эрдэнэ шанзудба нарт явуулаад зохих газар мэдэгдсүгэй хэмээн үүний тул өргөн тушаан илгээв (Д.Өлзийбаатар, 2011, хуудсд. 59-60) гэж нарийн зааж өгчээ.

В. Төрийн ёслолын хувцас

Төрийн ёслолын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг нь төрийн түшээд, албатын хувцас, эд хэрэглэгдэхүүнтэй холбоотой юм.

XIII зууны үед монголчуудын дээл зөв ташуу энгэртэй, гутал нь ээтэн хоншоортой, толгойн өмсгөл нь алчуур, юүдэн болон хив малгай байжээ. Дээлийнхээ солгой талд оноо хийж, баруун талдаа 3, зүүн гар талдаа 1 товч хаддаг байв. Монголын их хаад Мөнх, Хубилай нар тайлга ёслолын хувцасны дүрэм хуулийг тогтоосон бөгөөд монгол дээлийн хэв маягийг хэвээр хадгалж чимэг зүүлтийг улам нэмжээ. XIII зууны үеийн монголчууд дээл хувцсаа цэмбэ, арьсаар голдуу хийдэг байснаа торгомсог бөс, алтан саагаар хатгамаллан хоргой торгоор хийдэг болж, эрдэнийн чулуун шигтгээ бүхий хээ угалз, зээгт наамлаар чимэглэдэг байжээ. Монгол эхнэрүүд өндөр оройтой “богтог” хэмээх малгайны нарийн хоолойнд сүлжсэн гээгээ хийж дугтуйлдаг байсан нь монголчуудын үс засалтын хувьд содон засалт байв.

Марко Пологийн дурсамжид: Хубилай хаан хишигтэн нартаа янз янзын сувд, тана хийгээд бусад эрдэнийн чулуу шигтгэн хээлсэн өнгө өнгийн үнэт сайхан арван гурван хувцас (дээл), нэг нэг эрхэм сайхан алтан бүс, мөн мөнгөн утсаар оёсон үнэт бөгөөд үнэхээр сайхан тэмээний ширэн гутал бэлэглэдэг аж. Тэд энэ алдарт сайхан гоёлоо өмсөхөд хаан адил харагдана. Ямар баяраар ямар хувцас чимэг өмсөж, гоёхыг мөн тогтоосон ажээ. Их хаан хишигтэн нарт өгсөнтэйгөө нэгэн адил өнгийн арван гурван дээлтэй, ялгаа нь гагц үнэ хийгээд сүр жавхланд оршино.

Их хааны нэг түм хоёр мянган хишигтэн нартаа бэлэглэсэн арван гурван дээл нь нийтдээ бус таван түм, зургаан мянган үнэт хувцас болсныг тодорхойлов. Энэ бүгдийг тэмдэглэн бичихгүйгээр чухам хэчнээн их үнэтэй дээл, гутал болсныг бодохын аргагүй. Их хаан хурим найраа дээд зэргийн нэр хүндтэй, сүр жавхлантай болгохын тулд энэ бүгдийг хийдэг ажээ (Марко Поло, 1987, хууд. 105) гэж тэмдэглэн үлдээжээ.

Эндээс төрийн албаны ёслол, хүндэтгэлийн арга хэмжээнд төрийн албаны хувцаслалт, сүр жавхлантай байдлыг хэчнээн их чухалчилж байсан нь тодорхой харагдана. Мөн төрийн хүний хувцас хэрэглэгдэхүүнтэй холбогдох уламжлалыг тодотгох бас нэгэн баримт бол Юань улсын сударт тэмдэглэгдсэн “Улаагчин хонин өдөр чинсан Жуту айлтгасныг хэрэглэж дээдийн малгай, дээдийн дээл, дээдийн ёст бүс, дээдийн угаал, дээдийн наян тэрэг, дээдийн чимгийн Лиу фенүй хэмээхийг байгуулав. Зэрэг нь тавдугаар зэрэг бөлгөө. Бүгд дөчин найман түшмэл (Хааны хувцас хариуцах хүрээлэн) шайфү юань яаманд хавсруулав” (Юань улсын судар II, 2021, хууд. 176) хэмээсэн баримт юм.

Манж Чин улс XVII зууны үеэс хувцасны хууль гаргаж монгол ван, гүнгүүдийн цол хэргэм, зэрэг дэвийн хувцасны маяг, хэрэглэх зүйлийг тусгайлан заав. Монгол эрчүүд манж маягийн тав гэзэг тавьж, дөрвөлжин энгэртэй дээл өмсөх болсон ба дээлийн ханцуй нь нударгатай болжээ. Богд хаант Монгол Улс байгуулагдсанаар Манжийн үеийн ямбаны хувцас халагдаж шинэ тулгар төрийн ноёд түшмэдийн зэрэг дэвийг илэрхийлэх албаны хувцсыг хуульчлан



тогтоожээ. Энэ тухай архивын баримтад "...Монгол Улс тулгар төр нээн байгуулсан учирт олон хан, ван, бэйл, бэйс, гүн, засгийн хэрэгсэх ёст хүрмийн фүзийг зүй нь зэрэг дэвийг үзэж ялган салгаж тогтоовоос зохихын тул тусгай хуудсанд тодорхойлон жагсааж зураг зурж хичээнгүйлэн нугалбар бичиж хамтаар давшуулан айлтгасан (Д.Өлзийбаатар, 2011, хуудсд. 17-18) ажээ.

Хуучны адил хан, ван, бэйл, гүн, засаг гэх мэтээр ялгаж, тайж нарыг 1-4 зэрэг, бичиг хэргийн түшмэлийг 1-9 зэргээр ялган зэрэглэж харилцан адилгүй хувцас, хэргэм зэргийн фүс хэрэглэх болжээ. Фүс гэдэг нь хүрэм хувцасны ар, өвөр талд байх бэлгэдэл хээ ажээ. Тэргүүн зэргийн тайж түшмэд өмнө хойноо "таван нүдэт" алтан тэмдэг, дэд зэрэг нь "алтан өлзий", гутгаар нь "алтан хас", дөтгөөр нь "чандмань эрдэнэ", тавдугаар нь "мөнгөн лавай" фүстэй байжээ.

Түшмэдийн хэрэглэх өөр нэгэн өвөрмөц зүйл бол малгайн жинс болно. Энэ тухай баримт сийрүүлбэл, "... манай монголчууд өөртөө улс болж Очирдара Богд гэгээн эзэн шашин төрийг хослон барих хаанд өргөмжилж, эрдэнийн ширээнээ залж, ёслол мөргөсөн тухайд буулгасан хишиг Зарлигийг дагаж, эрдэнэ шанзудбаг хадын удаа, да лам нарыг вангуудын удаа жагсааж буулгаснаас гадна шинэ тавьсан шавийн бүгдийн дарга нарт тэргүүн зэрэг жинс хадуулж, засгийн хууль ёсоор явуулсан мөн дэд дарга нарт дэд зэрэг жинс хадуулж, туслагчийн хууль ёсоор явуулсан яамны хар зайсанг гутгаар зэрэг жинс, хөлөгч тайж олон нутгийн дарга нарт дөтгөөр зэрэг жинс, их хиа сангийн дарга нутаг захирсан шүүлэнгийн зоогийн зам ерөнхий дарга нарт тавдугаар зэрэг жинс, зоогийн зам, бага хиа, багийн шүүлэнгэ нарт зургадугаар зэрэг жинс тус тус шагнан хадуулсан ба бас бичгийн яамны түшмэдийн өөр өөрийн нэжгээд зэрэг дэвшүүлсэн нь угаас захирагч зангийн жинстэй нь тэргүүн зэрэг, гутгаар зэрэг жинстэй нь дэд зэрэгт хүрсэн бөгөөд чингэж зүй нь бүрнээ зэрэг дэвийг бодож жагсах суух ёслолыг тогтоолгож журамлан явуулбаас зохих (Д.Өлзийбаатар, 2011, хуудсд. 199-200) гэжээ.

Малгайн жинсний хувьд тэргүүн болон дэд зэргийн тайж түшмэлүүд "шүрэн", гутгаар нь хөх эрдэнийн чулуу болон хөх болор чулуу, дөтгөөр нь номин хөх өнгийн битүү болор, тавдугаар нь шил мэт өнгөт гэгээн болор жинс шигтгэж хэрэглэдэг байв. "Жинс" гэдэг нь малгайн сампингийн оронд байх шигтгээг хэлнэ.

Төрийн албаны ёслол, хүндэтгэлийн хүрээний олон зүйлс монголчуудын дунд үеэс үед уламжлагдан ирснийг түүхэн баримтууд өгүүлж байна. Дээр тоймлон өгүүлсэн жишээнүүдээс үзэхэд монголчууд эртнээс хаанаа өргөмжлөх ёслолыг бий болгон уламжлуулж байв. Тэдний бий болгосон өөр нэгэн зүйл нь элчин төлөөлөгч, түшмэдэд олгож байсан эрх бүхий гэрэгэ болно. Дипломатын төдийгүй тухайн түшмэдийн зэрэг зиндаа, эрх хэмжээг гэрэгэ нь илтгэж байв. Төрийн албаны хүрээлэнгүүдэд тусгай тамга, захирлага, тэмдэг хэрэглэх нарийн дэг жаяг уламжлагдаж байв. Эзэнт гүрний үеэс хэмжээт эрхэд хаант засаг хүртэлх төрийн албанд ажиллах түшмэдийн өмсөх ёслолын хувцас

нь нарийн журамтай байжээ. Дээрх жишээнээс үзэхэд монголчууд төрийн албаны ёслол, хүндэтгэлийн өөрийн гэсэн тусгай дэг жаягтай байж, тэр нь үеэс үед уламжлагдаж иржээ.

4.8. Төрийн албаны хүрээнд хариуцлага, урамшууллын тогтолцоонд баримталж байсан уламжлал

Судлагдан буй үеийн Төрийн албаны хүрээнд хариуцлага, урамшууллын талаар ямар уламжлал байсан бэ? гэдгийг тодруулж тэр үеийн манай төрийн албанд гавьяа байгуулж, ажил үүргээ нэр төртэй, сайн гүйцэтгэгчдэд үзүүлж байсан урамшуулал, хэргэм, зэрэг, цол өргөмжлөх, түшмэдийн цалин хангамж, пүнлүү, нийгмийн халамж, тэтгэмжийн шинжтэй уламжлал тогтож байсан эсэхийг тодруулж гаргах зорилт бидний өмнө байгаа. Нөгөөтээгүүр албан үүргээ ухамсарлаагүйн улмаас осол эндэгдэл гаргагчдад үзүүлэх сануулга, шийтгэл, торгууль, түшмэл эвдэх, цөлөх, цаазлах зэрэг ял шийтгэлийн уламжлалыг ч тодруулах зорилт бий.

Манай Монгол Улс эртний түүхтэй, дорно дахины уламжлалт соёлтойн хувьд, төрийн албаны салбарт шагнахуй хийгээд шийтгэхүйд чанд мэргэн бодлого, хариуцлагын тогтолцоог бий болгож уламжлуулан хадгалахыг зорьсоор ирсэн нь судалгааны хүрээнд эмхэтгэгдсэн баримт сэлтээс тодорхой харагдаж байна. Энэ их ажлыг эзэн Чингис хаан өөрийн биеэр хошуучлан сэдэж, үүсгэн тогтоосон өндөр зэрэглэлийн үнэт зүйл, эрхэмжийн хүрээнд үүрэг, хариуцлага хүлээгчдийн гүйцэтгэлийг бодитоор үнэлж шагнал хийгээд шийтгэлийг шалгуур өндөртэйгөөр оногдуулж байжээ.

Үүнд:

А). Шагнал, урамшууллын тухайд: Эзэнт улсын үед төрийн албаны хүрээнд ноёрхож байсан дээд эрэмбийн үнэт зүйл, эрхэмж нь нэгэнт дээр дурдсанчлан, бүрэн улс, төр байсан учраас шагнал, шийтгэлийн дээд нь ч мөн л үүн лүгээ холбогдож байна. Иймээс ч улсын төлөө, улсыг бүрдүүлж төлөвшүүлэхэд оруулсан бодит гавьяа зүтгэлийг үнэлж шагнах шагнал энэ цаг үеэс хатуу уламжлал болон тогтсон байна гэлтэй. Шагнал нь энгийн сайшаан магтаж, урам өгөхөөс эрх дарх, хувь хишиг оногдуулах, өндөр албан тушаал хүлээлгэх, хүндэтгэн дээдлэх, алдар сууг нь мөнхжүүлэх, зарим тохиолдолд гавьяа зүтгэлд нь нийцсэн жаргал цэнгэлийн өнгө аястай, гедонист маягийн шагнал ч хүртээж байжээ. Үүнийг батлах гол баримт сэлтүүдээс дурдвал:

1. Монголын нууц товчооны 202 дугаар зүйлд буй: “эсгий туургатан улсыг шударгатгаж” дуусаад “барс жил Ононы тэргүүнээ хурж”, Чингис хаан: “Улс байгуулалцан явагсдад та (та нар) мянган мянгалж, мянгадын ноёд түшиж, соёрхол үг өгүүлсү хэмээн зарлиг болов” гэх баримт чухал юм. Уг зарлигаар гавьяа зүтгэлийг нь үнэлэх замаар “Мянгатын ноёд түшин нэрийдрүүн: Мэнлэг эцэг, Боорчи, Мухали Гоо ван, Хорчи...” нараас тэргүүлүүлэн ...Монгол

Улсын мянгадын ноёдыг, Чингис хааны нэрийдсэн ерэн таван мянгадын ноёд болов” (Монголын нууц товчоо, 2019, хууд. 163). Энэ баримт бол Улс байгуулахад үнэнч зүтгэснээ үйл хэргээрээ харуулж чадсан хүмүүсийг албан тушаалаар шагнаж нэг ёсны ялалтын үр дүнд төрийн албан тушаалыг шагнал, “олз” болгон хуваах “спойл” тогтолцооны өвөрмөц хэлбэр ажээ.

Үүнтэй төстэй өөр нэгэн баримт бол:
“Хэн алагчлалгүй шүүвээс заргач²⁸-ийн зэрэгт оруул
Түдэлгүй эрүүлбээс заргын зэрэгт оруул
Эндэлгүй ухаас яамын зэрэгт оруул
Гэмийг тэтгүүлбээс жому-гийн зэрэгт оруул
Мухардалгүй хурааваас дэмч²⁹-ийн зэрэгт оруул
Бас бээр нэгэнтээ хүчин өгвөөс соёрхол соёрх
Хошоодод дарга соёрх
Гурваадад арван хүнийг мэдүүл
/+Дөрөвдүгээрт таван хүнийг мэдүүл
Тавдугаарт зуун хүнийг мэдүүл
Зургадугаарт гурван зуун хүнийг мэдүүл
Долдугаарт таван зуун хүнийг мэдүүл
Наймдугаарт мянган хүнийг мэдүүл/
Есдүгээрт /+таван мянган/ хүртэл хүнийг мэдүүл

Үлгэргүй эрдэмт мэргэн болоод, үлэмж /+гайхамшигт/ их ухаант /+сэцэн/ болоод гурван цагийг төгс мэдэж, хоёр ёсыг тэгш барин чадваас бидэгүн адахуч³⁰, мэргэн бичээч цолыг соёрх” гэх ажээ (Арван буянт номын Цагаан түүх, 2006, хууд. 40).

2. Улсын талаарх эрхэмж үзлээ гүйцэлдүүлэхийн тулд шагнал хариуцлагын урьдчилсан “гэрээ” маягийн хэлцэл хийж түүний гүйцэтгэлийн үр дүнгээр амласан шагнал, хариуцлага олгож байсны нэг тодорхой кейс бол МНТ-ны 121 дүгээр текстэд агуулагдаж буй баримт ажээ. Тэнд: “Бодончар богдын барьж авсан эмээс төрсөн, Жамуха лугаа хээл нэгтэн, хэлхээ ганцтан” Хорчи хэмээх бөө Тэмүүжин дээр ирж, “заарин нүдэнд нь үзүүлж зааснаар”, “Тэнгэр газар эетэлдэж Тэмүүжинийг улсын эзэн болтугай” гэснийг дуулгаад хэрвээ

²⁸ Зарга шийтгэх ноён. Чингис хаан анх Татарын Шихихутугийг “Улсын заргач” болгосон тухай “Монголын нууц товчоо”-нд тодорхой тэмдэглэжээ. К.Сагастер “шүүгч” гэжээ. Хожим “заргач” нь XIII зууны үе дэх “зарга шийтгэн тасалдаг тушаалтан” гэдэг утгаасаа илүү зарга заалихай үүсгэж, дундаас нь ашиг олз олдог хүнийг хэлэх болтлоо өөрчлөгдөн хувьсчээ.

²⁹ К.Сагастер үүнийг “хааны аж ахуйн захирагчийн албан тушаал” гэжээ. Юань гүрний үед шар (шашны талыг хариуцсан), хар (төрийн талыг хариуцсан) гэсэн хоёр “дэмч” байжээ. Мөн “дөчин гэрийн ноён”-ыг “дэмч” гэх нь буй.

³⁰ Бидэгүн адахуч - Юань гүрний үед түшмэдийг төрд байгуулсан гавьяа зүтгэлийг үнэлэн “бидэгүн адахуч”, “мэргэн бичээч” цолыг өгч байжээ. Сайшаал “бидэгүн адахуч”-ыг “хашха” цолоос нэг дэсийн дор цол гэж үзсэн байна. Харин К.Сагастер бичсэнээр Бидэгүн -1. “онгорхойгүй”, “битүү”, 2. “хаалттай”, “далд” гэсэн утгатай гэж тайлбарласан. Иймээс энэ үг нь “битүүг мэдэгч буюу нууц далдыг мэдэгч” гэдэг утгатай гэжээ. Чингис хааны цадигт (Цагаан түүх ч мөн адил) “бидэгүн адахуч” гэх энэ үг нь мэргэн бичээч, мэргэн оточ гэдэг үгтэй холбоотой байна.

түүнийг улсын эзэн болгох тал дээр зүтгэл гаргаад энэ нь гүйцэлдвэл яахыг тандаж буй тухай өгүүлж байна. Хорчи: “Тэмүүжин чи улсын эзэн болбоос, намайг заасны тул хэр жаргуулах, чи” хэмээхэд Тэмүүжин: “Үнэн тийн улс мэдүүлбээс, түмний ноён болгосу” гэжээ. Гэтэл үүнийг Хорчи үл зөвшөөрч: “Эл өдий төрийг (хэв ёсыг) заасан хүнийг, намайг түмний ноён болговоос юун жаргалан буй. Түмний ноён болгоод, улсын гоо сайн охид дархлан авхуулж гучин эмст болго. Бас юу бээр хэлснийг минь эсрэг сонс!” хэмээв (Монголын нууц товчоо, 2019, хууд. 69).

Үнэн байдалдаа ч, Хорчийн зөгнөж хэлсэн ёсоор болж, Тэмүүжиний үйлс бүтэж улсын эзэн болоод Хорчид хандан: зөгнөж хэлсэн үгээ зөв болгон тохирч, тэнгэрийн өршөөл хүчээр тэр ёсоор бүтвэл гучин эхнэр авъя гэж гуйсан билээ, чи. Одоо чи хэлсэн үг бүтсэний тул эзэлж оруулсан улсын дотроос чи сайн эхнэр сайхан хүүхнүүдийг сонгож ав хэмээн зарлигдсаны зэрэгцээгээр бас “Хорчи гурван мянган Баарины дээр Тагай Ашиг хоёр лугаа Адархины Чинос, Төөлөс Тэлэнгүд болон, түм дүүрч, Хорчи мэдэж, Эрт иш гудас ойн иргэнд хүртэл нутаг дархлан нутаглаж, ойн иргэдийг дагуулан, Хорчи түмэн мэдтүгэй”, “Хорчоос эегүй ойн иргэд ийн тийн бүү явтугай! Эегүй явахыг юу саарагдах!” хэмээн зарлиг болов /МНТ-207 дахь текст/.

Дээр дурдсан баримттай холбогдуулж цөөн боловч *комент* - эрэгцүүлэлийг нэмж оруулж байна: Нэгд, тэр үеийн улс төр, төрийн холбогдолтой асуудалд тал талын хариуцлага чухал байсан бөгөөд түүнийг “гэр”, хэлцэл харилцан амлалтаар баталгаажуулж байж. Хоёрт, одоотой харьцуулахад мэргэшсэн, мэдлэг чадвартай түшмэд гэх юмгүй тэр үед зөн билгийн ч атугай оюуны ов мэх, сүүхэйтэй бөө нарыг түшиж, тэдний энэ чадварыг урамшуулж тэтгэх бодит хэрэгцээ улсын эзэнд байж. Гуравт, тухайн баримт нь зөвхөн манайд биш, энэ үеэс нэлээд хожуу зарим улс, орнууд гавьяа зүтгэлтнүүдэд эрх мэдэл, түүний дотор тодорхой газар нутгийг эзэмших эрх олгож элдэв цол хэргэм шагнаан (граф, герцог гм) өөртөө ажиллуулж байсан уламжлалын эх ч байж болохыг харуулж байна. Дөрөвт, Төрийн албан хаагчдыг шагнаж урамшуулах талын зүйлийн зарим тал нь уг хүнийг жаргааж цэнгүүлэх зүйлтэй холбогдож байсныг харуулж байна. Аливаа хүн жаргалд дуртайг ухаарч, гагцхүү тухайн хүнийг, тухайн албан хаагчийг жаргалдаа ташуурч, жаргалд тэмүүлэх хүслийнхээ “боол” болохооргүй хэмжээнд жаргуулах “жор” гарган уламжлуулах оролдлого эзний зүгээс хийж байсан нь судлагдан буй үеийн нэг онцлог аж.

3. Монголын төр, төрийн албанд бичиг эрдэм, амьдралын зузаан туршлагатай хүмүүсээ эрхэмлэн дээдэлж хүндэтгэн урамшуулах, зөвлөмж сургаалыг нь сонсох явдлыг уламжлал болгон авч ирсэн олон баримт буйгаас энд ганцыг шигтгээ болгон оруулсу. Энэ нь:

“Бас Чингис хаан Үсүн өвгөнд өгүүлрүүн: “Үсүн, Гунан, Хөхөчос, Дэгэй эд дөрөв үзсэнээ, сонссоноо үл нуун, хавчин заан байх бүлгээ. Ухсан сэтгэсэнээ



хэлэн байх бүлгээ. Монголын төр, ноён мөр³¹ Бэхи³² болохуй ёсон ажгуу. Баарин ахын ураг бүлгээ. Бэхи мөр бидний дотор дээрээс Бэхи Үсүн өвгөнд болтугай! Бэхи өргөөд, цагаан дээл өмсөж цагаан агт унуулж, суурь дээр суулгаж тахиж, бас он сар саатаж³³, тийн атугай” хэмээн зарлиг болов” хэмээх утгат үгийг агуулсан Монголын нууц товчооны 216 дугаар зүйлд бөлгөө.

4. Энэ үеэс эхэлж тогтсон нэгэн уламжлал бол төр, улсын төлөө, улсын эзний төлөө амь нас бүхнээ зориулан зүтгэж байгсадын удам хойчийг урамшуулан халамжилж хувь хишиг хүртээх, цаашилбал, тусгай пүнлүү хөлс, эд материал, хүн хүчээр тусалж дэмжиж байсан байна. Энэ нь хэдийгээр амь хайргүй зүтгэгчдэд өөрт нь хамаарч байгаагүй ч цаад утгаараа төрийн албанд үнэнч, гавьяатай ажиллагсдын ар гэрт нь олгож байсан нэгэн төрлийн “нийгмийн даатгал”, нөхөн олговрын урамшуулал байжээ. Үүнийг батлах баримт олон буйгаас, “Чингис хаан өгүүллүүн: “Хуйлдар анд, хатгалдаанд амиа өрж, урьд ам нээсний тусын тул ургийн ургаа хүртэл өнчдийн авлага автугай” хэмээн зарлиг болов /МНТ-217/. “Чингис хаан Цагаан-Гуагийн хөвүүн Тоорилд өгүүллүүн: “Эцэг чину Цагаан-Гуа миний өмнө хичээж, хатгалдах болон, Далан Балжудад хатгалдахуйд Жамухад алагдлаа. Эдүгээ Тоорил эцгийнхээ тус, өнчдийн авлага автугай” гэж буйгаас харагдана /МНТ-218/.

Мөн түшмэдэд тогтвортой, амьдралаа залгуулахад нь хангалттай цалин, хөлс олгох тогтолцоог бүрдүүлж ажиллах талаар ч анхаарч уламжлуулсан байна. Энэ талаар, “Зуны сүүл сард, зарлиг буулгаж, түшмэл файлан нарын пүнлүүг нэмж өгвэй. Сүй Юй айлтгаруун: “Олон түшмэдийн пүнлүү багадваас, аж төрөхүйд мөхөстөөд эрхгүй ховдоглон ичгүүр сонжооныг үл хайхран, иргэнийг зовоож мөлжмүй” хэмээсэн хойно, тиймийн тул дотоод гадаад түшмэл файлан-ы пүнлүүг арван хувь болгоод, зэргийг ялгаж таван хувь нэмж өгвэй” (Рашпунцаг, 2006, хууд. 257).

“Байцаан үзэгч түшмэл айлтгасан нь “(Шаб ад дин) Шабудин, Насулт мил³⁴, Улир, ан Жужи, Лянь Жэньжя, Шада, Жяо Хуадэ нар цөм (Санга) Сэнгийн нам бөгөөд бузар эдийг хүлээн авч дэмий хэрэгссэн тулд Жянхуайгийн иргэд гаслах дуун зам төөрөхөд хүрсэн бөгөөд эдүгээ заримуудыг нь хорьсон ба заримуудыг тавьсан нь үүнийг доод түшмэд манай ухаж чадахгүй нь” хэмээсэнд хаан өгүүллүүн “(Санга) Сэнгэ нэгэнт цаазаар аваачжээ. (Насир ад дин мэлиг) Насул мил гянданд буй гагцхүү (Шаб ад дин) Шабудинг би түр тавьсан байгаа хэмээв. Упин, Пинлуань-ий олон жоу-д ховор болсон тулд авлах цаазыг байлгаад түүний хээлтэй цагт битгий баригтун хэмээв. (Төвлөн засаглах газар) Жуншу шэн-д ухуулан хэлэлцэж дотоод гадаад түшмэдийн пүнлүүг нэмэгтүн хэмээв (Юань улсын судар II, 2021, хууд. 29). гэх баримтуудаас аваад Богд хаант Монгол Улсын үед “Пүнлүүний мөнгө, пүнлүүний торго”, бас

³¹ Монголын ёс заншил, ноёдын уламжлалд

³² эрхэмд үзэх цолын нэр

³³ он сар бүр учран уулзаж

³⁴ Насир ад дин мэлиг

“Хүнс буулгах” талаар хууль зүйлийн тусгайлсан зохицуулалт хийж байснаас харагдана (Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичиг, 1995, хуудсд. 67-74).

5. Гавьяа зүтгэл гаргаж улсын төлөө зүтгэгч албаныхныг эхнэр хүүхнээр урамшуулах шагнал шагнал урамшууллын бие даасан хэлбэр болж байсныг Чингис хаан өөрийн охид, тэр ч бүү хэл өөрийн хатныг бусдад шагнал болгон өгч байсан баримт нотолно. Монголын нууц товчооны 208 дугаар зүйлд дүрслэн бичсэнээр, Хэрээдтэй болон Хар халзан элээтийн тулалдаан, Балжуна нуураас туршуулын үүрэг хүлээж явсан зэрэг улс төрийн учир холбогдол ихтэй үйл явдлуудад амь насаа үл хайрлан зүтгэж гавьяа олныг байгуулсан Жүрчидэйг шагнаж Ибаха хатнаа соёрхсон билээ.

Тийн соёрхохдоо Жүрчидэйд магтаал үг болгон:

“Алалдахуй өдөр

Амиа өгсний тул

Үхэлдэхүй өдөр

Өлөмлөсөний тул” хэмээн дурдахын хамт

Чингис хаан Ибаха-д ийн өгүүлсэн байдаг:

“Авир зангий чинь голсон биш,

Ариун үзэсгэлэнг чинь чамласан биш,

[Хөлий чинь шивэртэй гэсэн биш,

Хөлсий чинь үнэртэй гэсэн биш, А. то]

Өврөө дулаацуулж

Хөлөө хучуулсан

Өөрийн хатан чамайг

Их төрийн үйлст

Илт зүтгэсэн Жүрчидэйд

Ийнхүү соёрхох болов.

Хатгалдах цагт

Халх болж,

Хагацсан улсыг

Хамтатган өгч

Хутгалдан байлдахад

Хуяг болж

Хуваасан улсыг

Хурааж өгсөн

Жүрчидэйн ачийг хариулж, гавьяаг тэмдэглэхийн тул чамайг өгөв. Үүнээс хойш миний ургаас хаан ширээнд залгамжлан суугчид, энэ мэт тус хийснийг хариулсан ёсыг сэтгэж миний үгийг өөрчлөлгүйгээр ургийн урагт хүртэл Ибага-ын ор суурь (нэр хүнд)-ийг бүү тасалтугай” гэж зарлиг болов (Ц.Дамдинсүрэн, 1975, хууд. 171)³⁵ гэдгээс харж болно.

³⁵ Энд МНТ-ны 208 дугаар текстийн агуулгыг өнөөгийн монгол уншигчдад ойлгомжтойг харж Ц.Дамдинсүрэн гуайн найруулснаар авав. Энэ нь агуулгын хувьд сонгомол эхийнхтэй яг адил болой. (Я.Д)



Мөн Чингис хаан өөрийн охин Алха бэхийг Харлагийн Арслан хан байлдсангүй дагасны төлөө өгч, бас Уйгурын Идүүд ханд Алалтун бэхи охиноо шагнаж өгсний цаад шалтгаан нь мөнөөх л улс төрийн үнэт зүйл эрхэмжийн асуудал авай. Иймээс ч Уйгурын Идүүдэд Алалтун бэхийг өгөхдөө “Хатагтай хүнд гурван эр бий. Анхны эр нь алтан төр. Түүний дараах эр нь ариун нэр. Түүний дараах эр нь авсан эр мөн. Алтан төрийг хатуужин дагавал ариун нэр бэлэн болно. Ариун нэрийг бэхэлбэл, авсан эр ангид үл одно” гэж зарлиг³⁶ болсон аж. Энэ мэтчилэн Чингис хаан, түүний залгамж хойч үе “Амраг дээр давхар амраг больё” /МНТ-165/ хэмээн сэтгэж улс төрийн нөлөө бүхий хүмүүст өөрийн охид бүсгүйчүүдийг, өөрийн хөвүүд хойчийг залгамжлагчдад тэдний охид бүсгүйчүүдээс “шагнал, урамшууллын” журмаар “арилжин өгч, авах” бодлого барьж энэ нь уламжлагдсаар байжээ.

6. Эзэнт улсын үед төрийн албаны хүрээнд баримталж байсан шагнал, урамшуулах зүйлсийн үйлчлэх хугацааны хувьд авч үзвэл, харьцангуй урт хугацаатай, ихэнхдээ өвлөгдөх, тэр нь “**үеийн үед**”, “**ургийн урагт**” гэх хэллэгээр илэрхийлэгдэж хэрэгжиж байсан нь уламжлал урт хугацаанд үргэлжлэх, өвлөгдөх байдлыг тэтгэж байсан байна. Бас итгэл өгөх замаар урамшуулахдаа “**есөн алдаа гаргасан чял хэлэлцэхгүй**”, хариуцлага, тооцохгүй хэмээн нэмэлт нөхцөл өгч байсан нь албаны тушаал хүлээсэн хүмүүст улам бүтээлч, итгэл төгс ажиллах сэдэл болж байсан нь тодорхой. Зөвшөөрөгдсөн хэмжээнд алдъя, энэ боломжийг ашиглая гэсэн нэг ч тохиолдол таарсангүй.

Б) Хариуцлага, шийтгэл. Энэ үед төрийн албаны хүрээнд хариуцлагыг чангатгаж, хариуцлага алдсан тохиолдолд хүлээлгэх шийтгэл ял болохоор тодорхой байлгах уламжлал тогтоох талаар хичээж байсан нь илт аж. Тэгэхдээ хариуцлага шийтгэлийг ёс суртахууны хүрээний болон хууль, эрхзүйн хүрээний гэж зааглах оролдлого хийж байсан нь баримтаас харагдаж байна.

1. Ёс суртахууны хүрээнд хүлээлгэх хариуцлага, шийтгэлийн нэгэн чухал хэрэгсэл бол амласан, шийдсэн хэрэгтээ үнэнч байхын баталгаа - андгай, тангараг тавих явдал байсан байна. Төр, түмний төлөө үйлсийн төлөө тавьсан андгай, тангаргийн холбогдолтой баримт, андгай, тангараг тавих үйлдэл залуу Тэмүүжингийн үеэс Богд Жавзандамба хутагтыг хүртэлх олон зууны туршид тууштай үргэлжлэн уламжлагдаж байсан нь илт байна. Эдгээр баримтын дотроос: Тэмүжин, Тоорил хан, Жаха Гамбу гурвын өөр хоорондоо тавьсан тангараг буюу: Тэд “хамтдаж, тэндээс хөдөлж, Ононы тэргүүн, Ботохан бооржид хүрвээс, Жамуха болзоол газраа гурван өдөр урьд хүрчүхүй. Жамуха эд Тэмүжин, Тоорил, Жаха Гамбутаны³⁷ цэргийг үзээд, Жамуха хоёр түмэд цэргээн засч байжухуй. Тэмүжин. Тоорил хан, Жаха Гамбутан эд бээр³⁸ бас

³⁶ Энэ зарлиг Лу.Алтан товч-д байгаа бөгөөд академич Ц.Дамдинсүрэн асан МНТ-ны 238 дугаар зүйлд оруулсан байгаа.

³⁷ Жаха Гамбу нарын

³⁸ Тэмүжин, Тоорил хан, Жаха Гамбу нар, эд ч

цэргээн засаад, хүрэлцэж, жич танилдав³⁹. Жамуха өгүүллүүн:

“Бороон бээр болбоос болзоолд
Хур бээр болбоос хуралд бүү хожидъя
хэмээн хэмээлдлээ бус уу, бид?
Монгол “За” андгаартан⁴⁰ бус уу?
“Зээ” - гээс хожидсоныг
Зэргээс гаргая хэмээлдлээ” хэмээв.

Жамухын үгэнд Тоорил хан өгүүллүүн: “Болзоол газраа гурван өдөр хожид байв⁴¹ хэмээн буруутгах, чамарлахыг⁴² Жамуха дүү мэдтүгэй” хэмээв. Болзоолын чамар⁴³ өдий өгүүлэлдэж буй гэх баримт (Монголын нууц товчоо, 2006, хуудсд. 59-60), Богд хаант Монгол Улс байгуулагдсаны дараагаар төрийн түшээд тангараг өргөх талаарх саналын тухайд түүний баримталж байсан байр суурийг илэрхийлсэн баримт хоёрыг энд оруулж тайлагнаж байна. Түүний байр суурь нь: “эдүгээ тулгар төр байгуулсан чухал цагт чингэж бат тангараг хийх нь маш мөн. ... Хэрхэн тангараглах явдлыг бичгийн эхийг зохиогоод урьдаар үзэхүл аль сахиусны өмнө болохыг тэр дор заасугай” хэмээн зарлиг буулгажээ. Олноо өргөгдсөний хоёрдугаар он зуны тэргүүн сарын хорин зургаан (МУУТА, ХА-3, д-1, ХН-325, нугалбар 1).

2. Төрийн албаны хүрээний бүх төрлийн хариуцлага тооцож, шийтгэхүйд дан ганц ёс суртахуун, шашны буян хийгээд нүглийн номнол хүчин үл хүрэх нь тодорхой учраас түүнд хууль, эрхзүйн үндэс эрх биш байх учиртайг Чингис хаан бүр эхнээсээ ухаарч түүний тодорхой хүрээ-институци бий болгох бодол барьж байж байсан байна. Энэ нь Чингис хаанаас төрийн албаны хүрээний ажил үүргийн хуваарилалт хийж ахуйдаа Шихи Хутугуд: “зургадугаар дүү бус уу, чи? Ороч дүүдээ, чамд соёрхол дүү нарын хувиар хувилалд. Бас тусын чинь тул есөн алдалд бүү алдтугай”.

“Мөнх тэнгэрт игээгдэж/ивээгдэж/
Гүр улсыг зүглүүлж бүхүйд, чи
Үзэхийн нүдэн сонсохын чихин болж, гүр улсыг
Эхэд, биднээ /бидэнд/, дүү нараа, хөвүүдэд хувь иргэний нэрээр
Эсгий туургатныг хувааж,
Хавтсан үүдтэнийг хагацуулж хувилж өг.
Хэн бээр чиний үгийг бус бүү болготугай!” хэмээн зарлиг болов.
Бас Шихи Хутугу-гийг

³⁹ бас харилцан танилцав.

⁴⁰ За тангарагтан

⁴¹ Хожимдов.

⁴² зэмлэх, буруушаахыг

⁴³ Болзол хожимдсоны зэмлэл

“Гүр Улсын хулгайг гэсгээж, худлыг мохоож

Үхүүлдэхүн ёстныг үхүүл!

Алдуулдахуун ёстныг Алдуул” хэмээн гүр дээдийн зарга түшив.

Бас “Гүр иргэний хувь хувилсныг, зарга заргалсныг, хөх дэвтэрт бичиг бичиж, дэвтэрлэж, ургийн урагт хүртэл Шихи Хутгугу-гийн надад эетэж, ёсолж, хөх бичиг цагаан цагаадсанд /цаасанд/ дэвтэрлэснийг бүү егүүтгэтүгэй. Егүүтгэхүн аран/хүмүүс/ алдалтан болтугай” хэмээн зарлиг болов гэснээс харагдана (Монголын нууц товчоо, 2019, хуудсд. 165-166).

3. Эрт цагаас эрхэмжлэн ирсэн “Бие тэргүүт, дэвэл захт сайн” буюу ах зах, эрэмбэ дэвээ “эндүүрч” нэгэнт тогтсон ёс, уламжлалыг “эвдэх”, тэдэнтэй мөчөөрхөхийг санаархагчдыг хүний, өөрийн гэхгүй хатуу шийтгэн донгодож байсан уламжлал Чингисийн дараагийн хаадад ч уламжлагдсаар байжээ. Энэ тухайд нэгэн тод баримт буй нь Батаас Өгөөдэй хаанд кипчак нутгаас нууцаар илгээсэн мэдээ болой. Түүний агуулга нь: “Мөнх тэнгэрийн хүчинд, хаан авгын сууд, Мэгэд балгасыг эвдэж, Оросууд иргэнийг дагуулж, арван нэгэн харь иргэнийг зүгт оруулж, алтан жолоо няцан татаж, салалцахуй хурим хуримлая хэмээлдэж, их цачир босгож, хуримлахуйд би эд бүхэн хөвүүдийн ах хан болсон болж, нэгэн хоёр аяга өтөг (сархад) урьд уув хэмээн надад Бүри, Гүег хоёр муулж, хурим үл хуримлан морилогдов” (Монголын нууц товчоо, 2019, хуудсд. 243-244)

Хурим хаяж гарснаар үл барам гарахдаа Бат ахыгаа доромжилж Бүри хэлсэн нь: “Бат бид адил байтал, яагаад тэргүүлэн уух билээ? Тэр сацуурхах санаатай сахалт эмгэнийг өсгийгээр давтаж өлмийгээр гишигчих юмсан” гэж, Гүюг болохоор: “Бид хоёр тэр нум сум агссан эмгэдийн эгмийг харвалдъя гэж, харин Элжгэний хөвүүн Аргасун: “Тэдэнд модон сүүл зүүвэл зохино” гэлээ гэдгийг Өгөөдэй хаан авгадаа дуулгаж одоо яахыг хаан авга мэдтүгэй хэмээжээ. Батын энэ үгийг Өгөөдэй хаан машид хилэгнэж тус бүрд нь тохирсон хатуу шийтгэлийг ногдуулж буй нь МНТ-ны 276, 277 дугаар зүйлд байна.

Энд онцгойлон сонирхол татахуйц нэгэн баримт бол аливаа хариуцлага, шийтгэлийг ноогдуулахад баримталж байсан нэгэн хэв хууль бол Чингис хааны үеэс уламжилж ирсэн: “**Хэрийн үйлийг хээрхүү (хээр л) ноёлох бүлгээ, Гэрийн үйлийг гэртхүү (гэрт л) ноёлох бүлгээ**” гэх зарчим аж. Энэ нь Гүегийг шийтгэх тухайд хажуунаас зөвлөгчдийн амнаас гарч буй: “Хээрийн үйлийг хээрхүү ноёлох, гэрийн үйлийг гэртхүү ноёлох” гэдэг бол Чингис хаан эцгийн чинь зарлиг гэж Өгөөдэй хаанд хэлж буйгаас харагдаж байна. Үүний дагууд ч Гүег нарын “хэрэг” хээрийнх тул “Бат мэдтүгэй” гэж хааны шийдвэр гарчээ (Монголын нууц товчоо, 2019, хуудсд. 243-244).

4. Эзэн хаанаас улс, төрийн нууц хадгалж ам бөхтэй байх, амны алдас нь амины алдас болж болох аюултайг түшмэд, төрийн албаныханд анхааруулж хариуцлагжуулсан нэгэн зарлиг МНТ-ны 154 дэх текстэд бий. Юу хэмээвээс

эртний өштөн татаруудыг бүр мөсөн сөнөөх талаар эх эе дээр нууцлан гаргасан шийдвэрийг Билгүүдэй Татарын Их Чирэнд задалж хэлснээс үүдэн их хохирол амссан билээ. Тийнхүү нууц алдсан тул, Чингис хаан: “Үүний хойно их эед Бэлгүдэй бүү оруулсугай” Эе бартал, гадна бүхнийг застугай. Засаад, хэрүүлийг, хулгай, худал, үйлтэнийг заргалттугай. Эе барваас, өтөг уусны хойно Бэлгүдэй, Дааридай хоёр тэнд ортугай” хэмээн зарлигдсан байна (Монголын нууц товчоо, 2019, хуудсд. 100-101). Энэ зарлигийн агуулга бол улс төрийн аливаа хэрэгт өнө мөнхөд уламжлан сахиуштай анхааруулга аж.

5. Төр, засгийн газраас юуны түрүүнд хэрэгжүүлбэл зохих үүрэг-функци нь улс, ард түмэн, төрийн албаны хүрээнд аюулгүй байдлыг ханган дэг журам тогтоон хэвшүүлэх ажил гэдэг нь тодорхой. Манай судлагдахууны хүрээнд ч дэг журам тогтоох, түүнийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага шийтгэлийг тодорхой болгохтой холбогдол бүхий олон баримт цуглуулагдлаа. Тухайлбал, хишигтэн, хэвтүүл, торгуудын үйлчилгээг бий болгон тэр хүрээнд тогтоосон хэв журмыг зөрчигчдөд хатуу шийтгэл ногдуулж тэр нь уламжлал болон урт хугацаанд мөрдөгдсөн зүйлс, Монголын нууц товчооны 228 дугаар зүйлд: “Гадаад мянганы ноёдоос миний хишигтний ерийн хүмүүс эрхэм гэж, гадаад мянганы ноёд миний хишигтэнтэй тэнцэж хэрэлдвэл мянганы ноёдыг шийтгэе”, 229 дүгээр зүйлд: “хэвтүүлийн дэргэдүүр хэн бээр бүү явтугай! Хэвтүүлийн захуун бүү явтугай! Хэвтүүлийн тоо бүү асуутугай! ... Тоо асуусан араныг (хүмүүсийг) хэвтүүл, тэрхүү хүмүүний тэрхүү өдрийн унасан агт эмээлт, хадаартыг (хазаартыг), өмссөн хувцас сэлт хэвтүүл автугай!” гэхчлэнгээр шийтгэл хариуцлагыг тодотгож өгсөн баримт бий.

6. Улс, төрийн өмнө түшмэд хүний үүрэг хариуцлагыг чангатгах, буруу үйлдэл гаргавал түшмэл эвдэх хүртэл арга хэмжээ авч хэвшүүлэн уламжлуулж байсан аж. Үүнийг нотлох баримт олноос нэгийг дурдвал:

“Байцаан үзэгч түшмэл Юань Сайнбөх (yuan sai yin bu hua) нар Тогтохыг буруушаан айлтгасан нь: “Цэрэг гарч гурван сар болтол өчүүхэн төдий ямхын гавьяагүй улс гэрийн эдийг дуусгаж, биеийн хэрэглэл болгон улс төрийн хагас түшмэлийг биеийн дагалдан болгоод бас түүний дүү Эсэнтөмөр энгийн болхи, эрдэм сав бөгөөд [Хянан байцаах газар] Үйши тай-гийн хэлхээ хэцийн засгийг булааж ховдог үжид сэтгэлийг засахгүй нэн илэрхий” хэмээн гурван удаа айлтгасанд зарлиг Эсэнтөмөрийг нийслэл хотын хаалган гадна гарч зарлигийг сонс хэмээгээд, суань хуйши түшмэл Ван Жяну-г [хянан байцаах дайфу] үйши дайфу түшмэл болгов. Улаагчин тахиа өдөр зарлиг Тогтоохыг цэргийг үдлүүлэн эдийг сүйтгэж гурван сар өнгөртөл сууж, дайсан хулгайг үзэж өст санаанд үл агуулах тул Тогтохын түшмэл хэргэмийг эвдэж Хуайнань замд тохинуулан тавьж, дүү [хянан байцаах дайфу] үйши дайфу Эсэнтөмөрийг Нинся замд тохинуулан тавигтун хэмээв (Юань улсын судар III, 2021, хуудсд. 190-191).

Энэ уламжлал Богдын үед ч үргэлжилснийг аргын тооллын 1912 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн дараах баримт илтгэнэ.

Шавь боол Цэ, Го, Цэ сөгдөж хичээнгүйлэн айлтгах нь тулгар төр байгуулах хэрэгт мөчөөрхөн явсан засаг вангийн зэргийг эвдэж дайчлан байцаах явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад Богд эзэн гэгээнээр толилон заахыг гуйхын учир шавь боол Цэ, Го, Цэ нар мэхийж байцааваас Чин улсын засгийн хэрэг маш самуун болсны учирт ноднин жил зуны цаг манай Монгол өөртөө улс төр байгуулж, Богд гэгээнээ эзэн хаанд өргөмжилж шашин төрийн хамаг эрхийг байгуулах явдлыг олон хан, вангууд хуран чуулж, анх эхэлж зөвлөн хэлэлцэх тухайд Сэцэн хан аймгийн жүн ван Доржпалам хамт зөвлөсөн нь бөгөөд тэр даруйд дээд доодыг бүрнээ мэхлэн хуурмаглаж харьяат аймгийн дотроос үлэмж тооны тэмээ, мөнгө албадан авч сэмхнээ оргож, Чин улсын нийслэлд орсон нь үзвээс анхнаас энэ хэрэгт их л ойшоосонгүй агаад өнгөцөөр хууран мэхэлж, бүрэн учрыг сонсоод гэрчлэн заалдахаар одсон учир илэрхий байтугай нэгэнтээ улс төр байгуулан тогтсоны хойно харин манж, хятад түшмэдийн хамт ирж ятгамуй хэмээх зэргийг тэрсэлгэж их үг бичиж Богд эзэн гэгээнд хүртэл бичиг захидал илгээхэд хүрсэн нь даанч аймшиггүй балмадын туйлд хүрч, язгуур үндсээ огоорон гагцхүү нэр ашигт шунаж, Монгол овогтныг дарлахын туйл болбой. Энэ хооронд манай улс төрийн газраас Доржпалам түүний хамтаар ирмүй хэмээсэн Гүй фан хэмээх хятадын түшмэлийг ирүүлэхгүй болох явдлыг цахилгаан мэдээгээр ухуулсан бөлгөө. Эдүгээ Доржпалам түүний бие Нийслэл хүрээний газраа нэгэнтээ хүрч ирэв хэмээмүй. Тэр язгуураас засаг төрийн жүн вангийн хэргэм буй. Түүний бие хэрвээ хуучин хэвээр улс төрийн хэрэгт оролцон, элдвээр хуурмаглан чимэглэж, дээд доордыг мэхлэн явахад хүрвээс сая тогтнож бүхий шинэ төрд галд усыг цутгах лугаа адил болох тул түүний засаг вангийн хэргэмийг шууд эвдэж, засаг тамгыг Доржпалам түүний хошуунд хавсаргасан жүн вангийн зэрэг үе улиран залгамжлах төрийн бэйл цолыг Жамъянчойжилсүрэнд шилжүүлэн тушаан өгч, үе улиран засаг төрийн бэйл залгамжуулж хошууг нь захиргаад, Доржпаламын биеийг одоо даруй Шүүх таслах хэргийг эрхлэн шийтгэгч яамнаа тушаан өгч чангалан нягтлан байцаан шийтгэж, үнэнийг тодорхойлуулан цээрлүүлэн шийтгэж гэм өдөхөд хүргүүлэхгүй болговоос хэн нь улс төрд харшлан явагч зальхай түшмэл буй аваас дуурайн хөгжихгүй мууг халж, ариун цэвэр болон чадах болов уу хэмээмүй. Түшмэл бид ийнхүү хянасан нь гагцхүү харгис зальхайг арилгаж, улс төрийг амаржуулах санаа буюу нийлэлцэх, үл нийлэлцэх явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад Богд эзэн гэгээнээр толилж заалхийлэн сургах ажаамуу. Үүний тул хичээнгүйлэн айлтгав. Зарлигийг гуймуй хэмээн айлтгасанд мөнхүү өдөр хүлээн авсан уг нугалбарт улаан бийрээр цохсон Зарлиг гуйсан ёсоор болгогтун хэмээв.

(МУУТА, ТБА. ХА-3, Д-1ХН-26, Хуу-54а-56а).

7. Манай эзэнт улсын үеийн төрийн засаглалыг, Чингис хааныг хатуу ширүүн, харгис хэрций, түрэмгий дээрлэхүү гэж тэмдэглэсэн зүйлс элбэг байдаг. Гэвч энэ нь улс төрийн үнэт зүйл, эрхэмжтэй холбоотой асуудалд ажил хэрэгч бус, хариуцлагагүй хандсан тохиолдолд л, тэрхүү эрс шийдэмгий харгис хатуу “үхлийн шийтгэл” оногдуулж байсан аж. Энэ нь Татаруудын тухайд гаргасан:

“...Өвөг эцэгсийн өшөл өшиж, хясал хясаж

Цүүнд үлиж, хядаж алж өгье

Улиттэл хядъя. Үлдэгсдийг боолдъя.

Зүг зүгт хуваалдъя” хэмээх эх эеийн шийдвэр /МНТ-154/, болон Тангад улсыг эзэлж уг удмаар нь хүртэл мохол мушгилгүй болгож үүнийг тэмдэглэхийн учир “Идээ идэхүй зуураа мохол мушгил үгүй хэмээн, үхүүлэн эцэтгэн хэлэн адхун (байгтун!)” /МНТ-268/ хэмээн гаргасан зарлиг, эсвэл, улс төрд урван тэрсэлсэн Жамуха-тай холбогдуулж гаргасан “...Үхүүлье хэмээвээс төлгөд үл ормуй. Шалтгаан үгүй аминд хор хийвээс үл зохимуй. Хүнд мөрт хүмүүн буй.....Амийг чинь хайрлаас эс болов чи...эдүгээ чиний үгээр цус үл гарган нөгчөөтүгэй хэмээгээд “Цус үл гарган нөгчөөж, ясыг ину ил бүү гээдхүн”/МНТ-201/ гэж зарлигдаж буйгаас тодорхой байна. Бусад ихэнх тохиолдолд хүний амь насны асуудалд туйлын болгоомжтой хандаж “Хүний амийг хорлоход хүндэт шалтгаан хэрэгтэй” гэж үзэж байсан нь уламжлал болсон гэлтэй. Харин улс төрийн үнэт зүйлтэй холбоотой, төрийн албаны хүрээнд хатуу зарчим барьж байсан улсын эзнийг буруутгахад хэцүү бололтой. Европын шилдэг сэтгэгчдийн нэг М.Вебер бүүр хожуу, тодорхой хэлбэл, ХХ зууны эхээр: “Улс төрийн салбарт [үхлийн гэсгээл амсвал зохих] хүнд хэлбэрийн хоёр нүгэл байна. Нэг нь ажилдаа бодит бусаар хандах, нөгөө нь хариуцлагагүй байх” (Вебер, Улс төр мэргэжил болох нь, 2018) хэмээн бичиж байсан нь эдүгээ ч зөв мэт. Хариуцлагын ёс суртахуун төрийн албанд чухал ажээ.

8. Эзэн Чингис хаанаас өвлөгдөн ирсэн улс төрийн үнэт зүйл, эрхэмжтэй холбоотой төрийн албан дахь шагнал, шийтгэл, хариуцлага тооцох асуудал бол эмзэг нарийн зүйл аж, Товчхон хэлбэл, тэдгээрийн уялдааг хангаж үл өрөөсгөлдүүлэхгүйгээр тэнцвэрийг хадгалах нь удирдлагын нэгэн урлаг аж. Үүнийг илтгэх нэгэн кейсээр энэ хэсгийг өндөрлөө.

Дарьгангын бүгдийн тэргүүн Богд хаант Монгол Улс байгуулахад хүчин зүтгэж олноо дагуулан тус улсад дагаар орсон нь улс төрийн эрхэмжийн үүднээс чухал гавьяа зүтгэл байсан. Ийм ч учраас Богд хаан 1911-12-29-нд гаргасан хишиг тараах зарлигтаа: “Содномдовдон үнэнхүү сүслэн биширсний тул ...түүнд үе улиран залгамжлах засаг, улсын түшээ гүн шагнаж засгийн тамга олгожээ” (МУУТА, ХА-3. Д-1. ХН-2.Х-23-25).

Гэтэл тэрээр 1912 оны 07 дугаар сарын 11-нд Нийслэл Хүрээний олон хүрдний баруун талд шал согтуугаар мориноос унаж газар хэвтэхдээ “өгүүлэх бүр Жибзундамба золиг хэмээн харааж Богд эзэн гэгээнийг муу үгээр дайран” байсан тул Яамдууд, түүний дотор Шашин төрд туслах яам энэ асуудалд хатуу байр сууринаас шүүмжлэлтэй ханджээ. Хэдийгээр Дарьгангын ноён буруугаа хүлээж, Дотоод яаманд тайлбар бичиг өргөж, “Богд хааны ач, бурхан шашны хүчийг” (МУТА, ХА-3.Д-1. ХН-13.Х-390-391) дурдсан ч олон яамд хэлэлцээд Шүүх яаманд өгч хариуцлага тооцуулах саналыг Богд зарчмын хувьд зөвшөөрсөн боловч ч “Содномдовдон тэр анх тулгар төрд олныг дагуулан ирсэн онц гавьяа бүхийн тул хэтэрхий хишиг хүртээж Шүүх яаманд тушаахыг байлгаж үе улиран түшээ гүнгийн хэргэмийг хэвээр үлдээн гагцхүү бүгдийн

тэргүүний тушаалаас байлгагтун. Бус олон цөм хэлэлцсэн ёсоор болго” гэж Богд хаан шийджээ. Хэдхэн сарын дараагаар Богд хаан “Содномдовдон нэгэн удаа чингэж осол их явсан боловч энэ завсар цээрлэлийг мэдэж хэв сахиж явах нь харин өршөөлтэйн дээр тэр анх тулгар төрд дагаар орсон гавьяа бүхий тул одоо түүнийг бүгдийн тэргүүнд дахиул” (МУУТА, ХА-4,Д-1. ХН-126) гэсэн зарлиг буулгаснаар албаны хүмүүсээ аван буцаж албандаа орохоор нутаг явсан ажгуу. Энэ бяцхан кейс бол улсын тэргүүн Богд Жавзундамба хутагт Содномдовдонгоос түүний нэр хүндэд халдсан гэм, нүглийг нь улс төрийн үнэт зүйлийн хэрэгжилтэд оруулсан гавьяатай жигнэж үзээд ийм шийдвэр гаргаж буй нь хааны ухааны урыг нь илтгэнэ. Улс төрийн эрхэмж-үнэт зүйлийн зэрэг, зиндаа улсын эзний нэр хүндээс хавьгүй өндөр ажээ.

4.9. Төрийн алба, захиргааны зүгээс иргэдээ үүрэгжүүлж ирсэн уламжлал

а. Төрийн дээд, захиргааны албан тушаалыг хашиж байсан уламжлал

Улс байгуулагдах, тусгаар тогтнолоо сэргээх үед төрийн дээд эрх барих үйл хэрэгт харц гаралтай хүмүүс оролцох тохиолдол гарч байв. Тухайлбал, 1206 онд Их Монгол Улс байгуулагдахад улсын тэргүүн сайдаас эхлээд засаг захиргааны томоохон нэгжийн удирдлагад харц гаралтай хүмүүс томилогдсон байна. Чингис хааны анх өргөмжилсөн 95 мянгатын ноёдын олонх нь түүний элсүүлсэн нөхөрчүүдийн дотроос шалгаран гарагсад бөгөөд гарал язгуурыг нь авч үзэхэд хуучин уг шаг бүхий овгийн толгойлогч язгууртнууд бус, тэдний дотор жирийн малчдын төлөөлөгчид олон байжээ. Тухайлбал, Монголын нууц товчоонд дурдсанаар адуучин Бадай, Хишилэг нар хурдан хүлгээр хуй салхи мэт довтлон ирж Чингис хаанд мэдэгдэн, Хаан эзнээ аварсан төдийгүй, Хамаг Монголын сүр хүчийг бататгахад үнэтэй хувь нэмэр оруулсан билээ. Үүнийхээ хүчинд Бадай, Хишилэг нар мянгатын ноёд болж байв. Мянгатын ноёд бол цэрэг иргэний хэргийг эрхэлсэн засаг захиргааны тушаалтан юм.

Их Монгол Улс байгуулагдсан дараагаас “хишигтэн” хэмээх өвөрмөц төрийн албан хаагчид энх цагт гүйцэтгэж байв. Чингисийн зарлигаар ноёдын хөвүүд болон сул чөлөөт хүмүүсээс Хишигтнийг бүрдүүлж авдаг байв. Хишигтэн цэргийн нэг чухал чиг үүрэг бол хааны орд өргөөнөөс гарч байгаа зарлиг, зар зэргийг олон түмэнд хүргэх явдал байсан байна. Чухамдаа гэвэл засаг захиргаа, аж ахуй, удирдлагын зохион байгуулалтын шинэ зүйл болгон бусад түшмэл, зөвлөхүүд байсан хэдий ч эзэн хааны хишигтэн цэргүүдээр дамжиж хэрэгждэг байсан (Н.Ням-Осор, 2012, хууд. 166) байна. Эдгээр албан хаагчдыг шинжилсэн Японы монгол судлаач М.Мураками: “Хишигтэн систем нь монголын төрийн ордны өвөрмөц зохион байгуулалт юм. Мөн Их Монгол Улсад цаашдын ноёрхогч давхаргыг бий болгох байгууллага ч гэж хэлж болно. Хишигтэн нь Их Монгол Улсын түшиг, улс төрийн хүчирхэг үндэс болж байлаа” (Ж.Болдбаатар болон бусад, 2019, хууд. 158) гэсэн оновчтой дүгнэлт хийжээ. Энэ мэт цөөнгүй бүтээлүүдэд хишигтэн нарыг тухайн үеийн төрийн

захиргааны тодорхой үйл ажиллагааг эрхэлж байсан мэргэшсэн байгууллага гэж үзсэн нь бий.

Их Монгол Улсын үед төрийн дээд албан тушаалыг хашиж байсан хүмүүс хожмоо сурвалжит гэр бүл болж тэдний үр хүүхдүүдээс их төлөв төрийн өндөр тушаалуудыг хашицгаах болов. Юань гүрний үед Боорчи, Мухулай зэрэг түшмэдийн үр хүүхдүүд гол төлөв Төвлөн засах газар зэрэг яамдын хариуцлагатай албан тушаалуудад томилогдож байв. Юань гүрнийг үндэслэгч Хубилай хааны зарлигаар түшмэдийг сонгох, хэрэглэх нарийн журам тогтож, төрийн албанд орж ажиллагсдыг мэдлэг чадвар, үнэнч байдал зэрэг үнэт зүйлсийг харгалздаг байсан бол түүний дараагаас зарим талаар энэхүү байдал алдагдах болов. Үүний нэгэн илрэл нь хөрөнгө чинээ бүхий иргэдийг төрийн албанд орж энгийн улирах түшмэлийн албыг хаахыг хөхиүлэх болов. Энэ тухай 2 баримтыг хүснэгтэд үзүүлбэл,

Баян иргэдийн амуу өргөж түшмэл суухыг дурдсан нь хоёр мянган таарт цөм наймдугаар зэрэг, таван зуун таарт дэд наймдугаар зэрэг, гурван зуун таарт чухам есдүгээр зэрэг, түшмэл суухгүй болбоос түүний үүдийг тэмдэглэсүгэй (Юань улсын судар II, 2021, хууд. 344).

Харагчин үхэр өдөр [Төвлөн засаглах газар] Жуншу шэн-гийн түшмэд амуу бариулж түшмэл тавих зарлигийг гуйсан нь: “Аливаа олон газрын хүн үнэхээр улсын тул хүч гаргаж өөрөө хүнс амуу бэлтгэн цэргийн хэрэгсэлд нийлүүлэн өгч чадваас тогтсон хуулийг дагаж газар орны энгийн сонгохыг тавьсугай. Улирах түшмэлийг хуулийг дагаж дэвшүүлэн улируулаад үе улиран залгамжлуулсугай. Жич нэгэнт тавьсан цай, давс, цалин, амууны түшмэд жич цалин нэмж бэлтгэн цэргийн бэлтгэлд нийлүүлэн өгч чадваас тавьсан зэрэг дэвийг магадлан үзэж, энгийн улирах түшмэл тавьсугай” хэмээснийг ёсоор болгов (Юань улсын судар III, 2021, хууд. 171).

Юань улсын судар, Их Юань улсын Болор эрих зэрэг тулгуур бичгүүдийг шүүрдэн үзэхэд түшмэдийг гурван жилд өөрчлөхгүй байх, нарийн шатлалаар дэвшүүлэн ажиллах зэрэг дүрмүүд гээгдэж түшмэдийг ойр ойрхон халан сэлгэж, олон хүмүүсээр төрийн алба хаалгах болсон байна.

б. Төрийн тусгай албыг гүйцэтгэж байсан уламжлал

Их Монгол Улсын үед төрийн алба өргөжиж төв засгийн газраас олон тусгай албадыг зохион байгуулж хэвшүүлжээ. Тэдгээрийн нэг нь өргөн уудам эзэнт гүрнийг холбосон “Улсын өртөөний алба” болно. Түүхэн сурвалжуудад тэмдэглэгдсэнээс үзэхэд Өгөдэй хааны үед бүрэн бус тоогоор 1500 өртөө байсан гэдэг мэдээ байдаг. Өртөө дотроо том, дунд, бага гэж хуваагдана. Хуурай замын өртөө, усан өртөө, морин өртөө (гол нь), үхэр өртөө, тэргэнцэр өртөө, нохойн өртөө, явган өртөө гэх мэт олон янз байжээ. Чухал том өртөөнд 1000 гаруй өртөөчин, дунд зэргийн өртөөнд 500 шахам өртөөчин, бага өртөөнд 100 шахам улаач хамаарагдана.



Өртөөний албаны хүмүүс хэдийгээр улсын алба татвараас чөлөөлөгдөж байсан мэт боловч өртөөний олон төрлийн дааж давшгүй дайчилгаанд нэрвэгдэж маш ядуу зүдүү амьдралтай байжээ. Монгол өртөөний албаны хүмүүс амьдралын хүнд байдлаас болж ажлаа орхиж оргон зугтах, эсэргүүцэл гаргах явдал байснаас болж Юань гүрний хаадаас өртөөний албаны айлуудад цаасан мөнгө, амуу будаа нэмэн олгож тэдний эсэргүүцэл тэмцлийг түр намжааж байв. Эдгээрээс үзэхэд өртөөний алба нь эдийн засгийн их зардал сүйдэлтэй тул иргэдийн залгуулж байсан төрийн алба нь хүнд албанд тооцогдоно.

Үүнээс гадна жирийн иргэд олон төрлийн алба гувчуурыг улсад залгуулж байсан юм. Жишээлбэл, Юань гүрний үед монголын малчин ардаас татах улсын алба гувчуур нь дунджаар 100 толгой малаас 1 толгойг гувчуурлаж байжээ. 1302 оны байдлаар үзэхэд 130 хонь тутмаас нэг толгойг татварлах бөгөөд хэрэв тоо нь эс хүрвэл хэлтрүүл гэсэн байна.

Юань улсын сударт “хачи”, “харчи” гэх мэтээр бичсэн байх бөгөөд эдгээр нь харц ардыг хэлж буй бололтой байдаг. Улсын иргэн буюу харц ард гэдэг нь албат иргэд мөн. Тэр үед гувчуур хураалгах, алба төлөх гэж хослон хэрэглэсээр албат иргэн гэдэг нэр бий болжээ (Монгол улсын түүх. II боть, 2003, хууд. 255).

Тэдгээр албат иргэд мөн хаад ноёдын мал сүрэг хариулах, идээ саалийг нь бэлтгэх, их ан хоморгод оролцох, гэр орныг нь нүүлгэх, ачаа тээх зэрэг олон төрлийн биеийн хөдөлмөрийн цаг бусын албанд дайчлагддаг байжээ. Монголын хаадаас тэр үед тогтоосон олон төрлийн алба нь малчин ард иргэдийн хөдөлмөрийн нэмүү бүтээгдэхүүнийг тэгш бусаар ашиглах явдал байв.

Чингис түүний залгамжлагчдын үйл ажиллагааны үр дүнд дэлхийн талыг эзэлсэн эзэнт гүрэнг монголчууд байгуулав. Монголын эзэнт гүрний үед иргэдийн залгуулж байсан нэгэн төрийн алба бол цэргийн үүрэгт алба болно. Цэргийн алба хаах гэдэг нь монгол иргэдэд их чирэгдэл учруулдаг зовлонтой хүчир зүйл байв. Цэргийн албыг ихэвчлэн эзлэгдсэн орны алс хязгаар нутгаар очиж хаана. Цэргийн алба хаахын тулд өдий төдий айл өрх гэр орондоо харь нутагт халин нүүх явдал ердийн үзэгдэл болжээ. Тэр үеийн цэрэг татлагын тухай Юань улсын судар-т бичсэн нь “хоёроос гурван эр бүхий өрхөөс нэг, дөрвөөс таван эр бүхий өрхөөс хоёр, зургаагаас долоон эр бүхий өрхөөс гурван хүнийг тус тус цэргийн албанд татдаг байсан” гэжээ. Эзэнт гүрний үед цэргийн албанд оролдсон энгийн иргэдийн нөхцөл байдал төдийлөн сайн байсангүйг дараах сурвалжийн мэдээнүүд илтгэж байна.

“Хятадын дотоод нутгаар сууж байсан цэргийн хүмүүс ядуурч авааль эхнэр, үр хүүхдээ хүртэл худалддаг байсан” (Юань улсын судар 140-р бүлэг), “Монгол цэрэг унах морь тарих газартай болох гэж эхнэрээ худалдаж байсан” (Юань улсын судар 143-р бүлэг), “Цэргийн хүн ар гэр оронд хүнд, бас татвар оногддог байсан”, “алс холын дайнд явж бие барсан хүнийг ерийн тогтоосон дүрмээс нэг

жилээр илүү тэтгэмж өгсүгэй”, “дайны талбарт үхсэн ба шархадсан хүмүүсийн гэр бүлийн хүнийг онцгой халамжлан анхаарвал зохино”, “дайнд бие барсан цэргийн хүнд хууль ёсны тэтгэмж олгохоос гадна хэрэв үнэхээрийн бие ядуу, хүч сул, амьдрах аргагүй хүмүүсийг албан газраас тэжээх”, “Хол ойрын дайнд явсан буюу дарангуйлан хамгаалж сахиж байх цэрэг үнэхээр хөөрхий өрөвдөлтэй тул түүний ар гэр орныг онцлон анхаарах”, “Монгол цэргийн алба хаасан хүн маш хүнд байдалд байсан” гэх мэтээр түүхийн сурвалжид тэмдэглэснээс үзвэл тухайн үеийн иргэдийн залгуулж байсан энэхүү алба нь хэр хүнд байсныг гэрчилнэ.

Монголын эзэнт гүрний үед жирийн иргэдийн биеэр гүйцэтгэж байсан өртөө-улаа, цэрэг, гувчуурын алба нь дараа дараагийн нийгмүүдэд агуулгын хувьд хэвээр уламжлагдсан юм. Энэхүү үед эзэнт гүрний эзэн улсын иргэд байсан нь зарим талаар хөнгөлөх тохиолдол гарч байсан бол Манж Чин улсын үед харь гүрний эрхшээл дэх хязгаар нутгийн хувьд нөхцөл байдал улам дордсон байна. Манжийн төрийн албан татвар залгуулагчдыг “сум ард”, “албат ард”, “сум эр” хэмээнэ. Сумын дансанд орсон 18 наснаас дээш, 60 наснаас доош бүх эрэгтэйчүүд бол “сумын хуяг”, “сумын эр”, “сумын ард” гэж нэрлэгдэх болов. Сумын ардын үүрэг бол цэргийн албыг хаах, зах хязгаарын харуулын албыг хаах, олон замын өртөөдөд алба хаах, Манжийн хааны сүргийг адгуулах, албан тарианы ажилд зүтгэх, Халх монголд байгуулсан бүх засаг захиргааны газар ба тэдгээрийн албан хаагчдын зардлыг нийлүүлэх зэрэг (Ш.Нацагдорж, 1963, хууд. 152) болно. Агуулгыг давхардуулахгүй үүднээс манжийн үеийн өртөө, цэрэг, гувчуурын албыг энд дурдалгүй, харин харуулын албыг тусгайлан авч үзье.

Халх монголыг Манж Чин улсын умарт хил хязгаарын харуул халхавч болгох ялангуяа Монголыг Оросоос тусгаарлах зорилгоор Найралт төвийн 5-р (1727) онд Манж, Оросын хил хязгаарын гэрээ хэлэлцээ тогтоосноор Хиагтын зүүн баруун этгээдэд 59 харуулыг анх байгуулжээ. 1760 оны үест Хиагт зүгийн харуулд есөн зуун цэрэг, 1777 онд цэрэг 1230, захирах түшмэл ба гэр хөрөнгийн хамт суулгасаар байжээ. Гэр харуул тус бүрд 20-30 айл өрхийг байнга суулгаж, бие хөрөнгөөр хаах үүргийг халхын ардад тохоосон байна (Ц.Насанбалжир, 1964, хууд. 123). Хаант Орос улсын нэрт аялагч Потанин тэмдэглэлдээ Монгол дахь харуулуудыг хоёр төрөлд хуваана. Нэгийг нь “гэр харуул”, нөгөөг нь “морин харуул” гэнэ. Гэр харуул гэдэг нь эндээ суурьшсан, гэр бүлтэй, малтай байнгын цэргийн харуулыг хэлнэ. Тэд ямар хошуунд хамаарагддагаа сайн мэддэг боловч өвөг дээдсийнхээ нутагт очиж үзээгүй, ихэнх нь энэ хилийн зурвастаа төрж өссөн, зөвхөн зэргэлдээ харуулынхаа нутагт л очиж үзсэн хүмүүс юм. Морин харуулд тодорхой хугацаагаар томилогдон ирсэн хүмүүс байдаг ба хугацаагаа дуусмагц нутагтаа буцдаг (Г.Н.Потанин, Онгүй, хууд. 57) гэжээ.

Дээр өгүүлсэн орос зүгийн харуулыг өрх хөрөнгийн хамт байгуулсан “гэр харуул”-аас гадна Алтайд цэргийн зохион байгуулалттай байгуулсан харуулыг “сум харуул” буюу морин харуул гэдэг. Ахмад түүхч Ц.Насанбалжирын судалгаагаар 1760 оны үеийн албан баримтад Алтайн сум харуулд 1040 цэрэг байжээ. Харин 1773 оноос хойш Халхын олон аймаг хошуудаас Алтайн 23 суман харуулд бүрэн зэвсэгтэй цэрэг 850, туслагч 6, тайж 23, хөтөл зарлага 122-ыг хуваарилан гаргуулж, харуулын албыг 3 жилийн хугацаатайгаар хаалгаж байжээ (Ц.Насанбалжир, 1964, хууд. 121). Ар Монголын умард хилээр тавьсан суман болон гэр харуулаас гадна бас “дотуур харуул” гэж байв. Хятадын худалдаачдыг харуулын нутагт оруулахгүй, тэднийг Оростой худалдаа хийлгэхгүй, сэргийлүүлж байх зорилгоор 1788 онд нэмэн байгуулсан харуулыг дотуур харуул буюу “хийлсэн харуул” хэмээн нэрийддэг байв. Энэхүү дотуур харуулд халхын 4 аймгаас 214 цагдаа өрх, 140 орчим түшмэл, зайсан, хөтчийг гарган суулгаж байжээ. Хийлсэн харуулын 1 жилийн зардал нь 4600 лан орчимд эргэлдэж байсан ажээ (Монгол улсын түүх. IV боть, 2003, хууд. 197).

в. Орон нутгийн албыг хашиж байсан уламжлал

Манж Чин улсын үед монголын засаг захиргааны үндсэн нэгж нь хошуу болов. Хошууны бүтэц нь Богд хаант Монгол Улсын үед өөрчлөгдөлгүй, орон нутаг дахь бие даасан засаг захиргааны үндсэн нэгж хэвээр байсан тул энд давхар шинжилье.

Хууль зүйлийн бичигт: Аливаа хошууг захирагч занги, мэйрэн, залан, сумын зангийн ор гарваас харьяат засаг уул хошууны дотор эр сайн захиран чадах тайж, тавнанг ялган сонгож язгуурын зэрэгтэйгээр тавь. Хэрэв тэр мэт хүн олохгүй болбоос харьяат албат нарын дотроос шударгыг барьж ялган сонгож тавь (Б.Баярсайхан, Б.Батбаяр, 2008, хууд. 113) гэсэн нь хошууны тамгын газар суух түшмэдийг сонгохдоо тэргүүн ээлжинд угсаа гарал бүхий тайж тэдэнтэй урагласан тавнан нараас сонгохыг заасан нь бодит байдалд нэлээд хэрэгжиж байв. Архивын баримтад тайж нар олонтой зарим хошуудын дээрх бүхий л түшмэдийн албанд тайж, тавнан нар ажиллаж байсан нь тэмдэглэгдэн үлджээ. Гэвч хоёр зуу гаруй жил 100 орчим хошууны албанд зүтгэсэн түшмэдийн угсаа гарал янз бүр байсан нь бий. Энгийнээр тайлбарлавал, засаг захиргааны суурь нэгж болох хошууны дээд удирдлага болох засаг ноён, түүний туслагч нар нь язгуур угсаатай хүн байна хэмээн хуульчлан заасан нь албан ёсоор хэрэгжиж байжээ. Үүнээс гадна хошууны бусад түшмэл хийгээд сумын занги ч мөн тайж, тавнан нараас ихэвчлэн тохоогддог байв. Харин хошууны бичээч, сумны орлон хөөгч гэх мэт жижиг албанд энгийн иргэдээс томилогдох нь хэвийн байжээ.

Тэр үеийн засаг ноёдоос гадна бүгдийн дарга нар ч бас тухайн орон нутагтаа дээд эрх мэдэл эдлэнэ. Бүгдийн дарга нь засаг ноёны адил хошууныхаа бүх хэргийг удирдан зохион байгуулж явуулна. Иймд засаг ноёнгүй хошууг

бүгдийн даргын хошуу гэнэ. Ар Монголын Алтайн Урианхайн 7, Өөлд, Мянгад, Захчин, Хөвсгөлийн Урианхай, Дарьгангын нэжгээд хошуудыг бүгдийн дарга нар захирч байв. Манжийн хуульд зааснаар бол, бүгдийн даргыг үе улируулан хошууг захируулахгүй, нэг биеэр дуусах бөгөөд тэдний ор сууринд манжид үнэнч түшмэдийг томилон тавьж байх ёстой байв. Гэвч ялангуяа манжийн эрхшээлийн сүүл үед янз бүрийн хээл хахууль цутган бүгдийн дарга нарын үр хүүхэд, төрөл садан нар тухайн хошууны эрх баригчаар тохоогдох нь элбэг байжээ (Монгол улсын түүх. IV боть, 2003, хууд. 178). Үүнээс үзэхэд өгүүлэн буй үед засаг захиргааны үндсэн нэгж болох хошууны удирдлагад түшмэдийг ажиллуулахдаа тэдний угсаа гарвалыг чухалчлан үздэг байсан нь илэрхий байна.

Манжийн эрхшээлийн үед Монголд бурхны шашин ихээхэн газар авч олон хутагт хувилгаад, хүрээ хийд буй болсон билээ. Манжийн хаанаас тусгайлан шавь нар захирахыг зөвшөөрч, тусгай тамга олгосон том лам нарыг тамгатай хутагт гэдэг. Манж Чин гүрний ноёрхлын сүүл үед Ар Монголд Богд Жавзандамбаас гадна тамгатай 13 хутагт байв. Манж нар Их шавийн эрдэнэ шанзудбын эрх, үүргийг өргөтгөж, 1723 онд Их шавийн хэргийг эрхлэх төрийн захиргааны байгууллага Шанзудбын яамыг байгуулжээ. Богд Жавзандамбын Их шавийн хэргийг эрхлэх Эрдэнэ шанзудбын яам нь аймгийн чуулганы эрхтэй бөгөөд их хүрээний 30 аймаг, 10 их дацан, баруун хүрээ, Амарбаясгалант, Дамбадаржаалин, Эрдэнэ зуу зэрэг хүрээ хийдийг харьяалан захирч байв. Түүхэн баримтаас үзэхэд “Эрдэнэ шанзудбын яаманд лам, хар зайсангууд ээлжээр жасаалан сууж хэрэг шийтгэнэ. Тэгэхдээ, лам зайсан нь лам шавь нарын, хар зайсан нь хар шавь нарын хэргийг эрхэлнэ” (Монгол улсын түүх. IV боть, 2003, хууд. 208).

Манж нар шавь нартай нэр нөлөө бүхий лам болгоныг бус, 500-аас дээш тооны шавьтай хутагт хувилгаадад шавь захирах тамга олгохоор хуульчилснаа хожим 700 болгон нэмэгдүүлжээ (Очир А. Э. Б., Монгол улсын түүх. Дөтгөөр боть (XVII-XX зууны эхэн), 2003). Энэхүү нөхцөлийг хангасан арван гурван тамгатай хутагтуудын шавийн захиргааны эрхийг хутагтын тамгын газар барих бөгөөд түүнийг шанзудба, да лам, 2-4 тамга барих эрх бүхий зайсан, мөн сул зайсан нар удирдана. Шанзудбыг хутагтын саналын дагуу харьяалах чуулганы даргын газраас батална. Да лам ба тамгат зайсангуудыг мөн аймгийн чуулганаас томилдог байжээ. Хутагтуудын шавь нарын өрхийн тоо, газар нутгийн хэмжээ, хөрөнгө чинээний байдал нь харилцан адилгүй байв (Очир А., 2003).

Хутагт нарын шавийн хэргийг эрхлэх газрыг яам буюу тамгын газар хэмээх ба түүнийг шанзудба толгойлж, шанзудбын яамнаа бас зайсан, түшмэл, бичээч зэрэг хүмүүс улирлаар ээлжлэн сууж өдөр тутмын ажлыг эрхлэн явуулж байжээ. Хэрэв Богдын шавь нь отгоор хуваагддаг бол тамгат хутагт нарын шавь нар нь дацангуудад хуваагддаг байлаа. Дацан нь нэгэн талаар хүрээ



хийдийн зохион байгуулалтын нэгж, нөгөөтээгүүр засаг захиргааны хуваарь ажээ. Дацангуудыг тамгын газраас тохоон томилсон лам, хар нэжгээд зайсан толгойлж лам зайсан нь гэгээний сан, дацан, жасад ажиллах хүмүүс, хурал номын зардал, лам нарын цав хүнс нийлүүлэх, дацангийн орлого зарлагын данс тооцооны ажил зэрэг шашин номын асуудлыг эрхлэх ба хар зайсан нь хар шавь ардыг захирч дацангийн доторх засаг захиргаа алба татвар зарга заалхай зэрэг шавийн тамгын газрын аливаа асуудлыг эрхэлнэ. Эдгээр зайсангаас гадна дацан бүрд басхүү дэмч бичээч, бошго нар байжээ. Хутагт нарын шавийн тамгын газрын дэргэд жил тутам шанзудба, тамгын зайсан, тамгын газрын бусад түшмэл, олон дацангийн лам, хар зайсангууд хуралдаж хүрээ хийд ба хурал номын зардлыг нийлүүлэх, засаг захиргаа, шүүх таслах хэрэг, алба татвар зэрэг асуудлыг зөвлөлдөн хэлэлцэж байв. Үүнийг “жасаа цуглаан” гэдэг байв.

Манж Чин улсын үед лам нарын олон болсон шалтгааныг феодалын дарлал ширүүссэн явдалтай холбон тайлбарлаж байв (Ш.Нацагдорж, 1978, хууд. 195). Гэвч үүнийг тухайн үед үйлчилж байсан давхаргын босоо шилжилттэй холбон тайлбарлавал мөн зохилтой байна. Олон тооны ямар нэгэн язгуур угсаагүй харц иргэд Богд Жавзандамба болон бусад тамгатай хутагтуудын тамгын газарт “шар” шашны болон “хар” захиргааны албыг хааж байв. Энэ нь өвөрмөц нэгэн төрлийн төрийн албанд иргэдээс эрдэм номоороо ялгаран гарсан хүмүүс идэвхтэй оролцож байсны илрэл болно. Тэдний дундаас л тусгаар тогтнолоо сэргээсний дараа Богд хаант Монгол Улсын төрийн зүтгэлтнүүд нэлээдгүй төрөн гарсан юм.

Энгийнээр дүгнэхэд, мэр сэр ардууд төрийн албанд идэвхтэй оролцож, улсыг удирдах үйл хэрэгт оролцож байсан авч, түүхэн цаг хугацаан дахь төрийн олон түшмэдийн тоотой харьцуулбал тэдний оролцоо үлэмж бага байна. Гэвч энэ бүхэн эгэл хүмүүсийг төрийн албанд үнэмлэхүй оролцоогүй байсан гэвэл өрөөсгөл болно. Тухайлбал, нэлээд тооны түшмэд Их Монгол Улсын үеийн төрийн сайд, төрийн захиргааны албан тушаалууд, орон нутгийн ноёдын албанд зүтгэж байсан бол Богд хаант Монгол Улсын үед яамдын тэргүүн сайдаас олон түшмэдийн алба, Улсын дээд, доод хуралд орж улс орныхоо хөгжлийн төлөө хичээнгүйлэн ажиллаж байв. Үүнээс гадна улсын албыг хэвийн явуулахад үүрэгтэй олон биеэр гүйцэтгэх болон хөрөнгө санхүүгээр хаах хүнд албыг улсын иргэд залгуулж иржээ.

Монгол Улсын төрийн албаны хүрээн дэх үнэт зүйлс, уламжлал” (Түүхэн эх сурвалжид хийсэн шинжилгээ) сэдвийн хүрээнд манай судалгааны төслийн баг өнгөрсөн нэг жилийн хугацаанд таван хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж ажлаа үндсэнд нь дуусгаад байна. Төслийн багийн судалгааны эцсийн үр дүн болж судалгааны ажлын энэхүү тайлан, түүний хавсралт буюу судалгааны ажлын үр дүнд олж цуглуулсан, нийт 580 гаруй хуудсанд багтаасан 887-оод баримт бүхий “Түүхэн эх сурвалжид хийсэн шинжилгээ сэдэвт судалгааны ажлын эх хэрэглэгдэхүүн” гар бичмэлийн эрхтэйгээр бэлтгэгдээд байна. Судалгааны ажлын тайлан үндсэндээ энэхүү баримт бичгийн эх хэрэглэгдэхүүн дээр тулгуурлан хийгдсэн болно. Гэвч хязгаарлагдмал хуудас бүхий тайланд цугларсан бүх баримт бичгийн агуулгыг задлан шинжилж багтаах ямар ч бололцоогүйг энд тэмдэглэж байна. Цугларсан баримтын эх хэрэглэгдэхүүнийг энэ чиглэлд судалгаа хийдэг, сонирхдог хэн хүн цаашид судалгааны эргэлтэнд оруулж ашиглах боломж нээгдэж буй гэдэг нь тодорхой.

Манай судалгаа төрийн захиргааны хөгжлийн үе шатны талаар хийсэн их эрдэмтэн В.Вильсоны үечлэлийг өөрийн улсын захиргааны хөгжилд холбогдуулан авч үзэж хэрэглэхийн хамт энэ удаад, аливаа улсын төрийн захиргааны хөгжлийн **Анхных нь** буюу “Хэмжээгүй эрхт засаг баригч-эээд, хэмжээгүй эрхт дэглэмдээ нийцэж тохирсон захиргааны тогтолцоотой байсан үе”-тэй холбоотой судалгааг хийлээ. Энэ үе нь манай улсын хувьд эзэн хаант засгийн үе буюу Чингис хаан эзэнт Их Монгол Улсын үеэс Богд хаант Монгол Улсын үе билээ.

Бид юуны өмнө, судлагдан буй энэ үед холбогдох улс, төр, төрийн албаны үнэт зүйлсийн тоймыг гаргахын тулд эх сурвалжид шинжилгээ хийх замаар тухайн цаг үеийн нэр томьёог тодруулав. Манай нийгэмд ноёлж байсан эрэист үзлээс улбаатайгаар өнөөгийн бидний үнэт зүйл гэж нэрлэж буй зүйлийг тэр үед эрдэнэ, эрхэмж эрмэлзлэл, эрхэм гэхчлэнгийн эр язгуурт үгээр голчлон нэрлэж байсныг тодруулж эрхэмж гэх нэр томьёог цаашид ч өвлүүлэн авч явах нь зүйтэй гэж үзэв.

Бид: **“Эрхэмж гэдэг нь олон түмний сэтгэлийг эзэмдэн цагийг элээж, ноёлох хүчийг олсон итгэл бөгөөд хүний болон хүй олны үйл ажиллагааны өдөр тутмын болон алсын чигийг зааж тэдгээрээс өөр хоорондоо болон байгаль, нийгмийн бусад хүрээнд харилцах практик харилцааны хэм хэмжээг тохируулан тодорхой болгож, харьцангуй тогтвортой баримтлагдах зарчим болж байдаг байна.** Ийнхүү тодорхой хэмжээний норматив шинжийг агуулж байдгийнхаа улмаас эрхэмж

нь зарим тохиолдолд хуультай эн зэрэгцэж, зарим тохиолдолд түүнийг давах хэмжээнд хүрч болох ч ихэнхдээ түүнтэй хоршиж хэрэглэгддэг зүйл юм” гэх онол, аргазүйн шинжтэй тодорхойлолт гаргаад түүндээ нийцүүлэн тэр үеийн Монголын төрийн албаны эрхэмж-үнэт зүйлсийг **улс төрийн эрхэмж хууль, эрх-зөвийн эрхэмж, Эв нэгдэл, итгэл үнэмшил, эрдэм, соёлын хүрээний эрхэмж, Захиргаа, төрийн албаны эрхэмж** хэмээн хуваан үзэж тус бүрт нь тохирох баримт сэлтийг тохируулан гаргахыг хичээсэн болно. Чингэхдээ бүх төрлийн үнэт зүйл-эрхэмжүүдээс улс төрийн хүрээний эрхэмж илүү чухал ач холбогдолтой зэргэмж, зиндаа өндөртэй байж бусад бүх зэрэглэлийн эрхэмжээ өөртөө захируулж байх учиртайг тодотгон улс төрийн хүрээн дэх эрхэмжийн сөргөлдөөн, мөргөлдөөний кейсээр харуулав.

Энэ бүх үнэт зүйлсийн суурь дэвсгэр дээр тулгуурлан цаашид манай төрийн алба, төрийн захиргаанд тогтвортой хадгалагдан уламжлал болон хөгжсөн зүйлсийг дараах чиглэлээр баримтанд тулгуурлан гаргахыг хичээв. Үүнд:

Төрийн албаны хүрээлэнд уламжлагдаж ирсэн зохион байгуулалтын бүтэц нь түүхэн урт хугацааны туршид нэрийдэл, хэлбэр гэх мэтээр цөөнгүй өөрчлөгдсөн боловч үндсэн агуулга нь дараа дараагийн үеүдэд уламжлагдсаар иржээ. Төрийн албаны зохион байгуулалтын үндсэн 4 субъект болох хэмжээгүй эрхтэй эзэн хааны хүрээлэн, зөвлөх эрхтэй хуралдай, гүйцэтгэх эрхтэй засгийн газар, орон нутгийн засаг захиргааны нэгжийг тус бүрчлэн шинжлэв.

Их засаг хуулиас Монгол Улсын хууль зүйлийн бичиг хүртэл хууль цаазын бичгүүд нь төрийн албыг зохицуулах гол үүрэг гүйцэтгэж байв. Тийм ч учраас Чингис хаан энэ цаазаа хатуу сахихгүй бол төрийн хэрэг тасалдах болно гэж захиас үлдээжээ. Эмхэтгэн гарсан эрх зүйн баримтуудаас гадна хаад, ноёдын зарлигийн дагуу төрийн албан дахь үе үеийн шинэтгэлүүд хийгдэж байв. Билэг сургаалийг үл ойшоогчид дарга байж таарахгүй гэж үздэг байв. Хэмжээгүй эрхтэй хаадын зарлиг нь улсын албанд шууд хэрэгжиж байв. Тухайлбал, Хубилай хааны зарлигуудад улсын албанд ажиллагсдыг шатлан дэвшүүлэх, залгамжлуулах, сонгож хэрэглэх, үнэнчээр ажиллуулах зэргийг тусгасныг дараа дараагийн хаад залган мөрджээ.

Хүннү гүрний засаг захиргаа, цэргийн хосолсон аравтын систем нь Их Монгол Улсад уламжлагдсан байв. Аравт, зуут, мянгат, түмтийн ноёд өөр өөрийн хариуцсан нэгж тус бүрийн цэрэг татлага, ахуй амьдрал, амжиргааг бүрэн хариуцдаг тогтолцоотой байв. Хамаг Монголын ханд өргөмжлөгдсөн даруй Чингис өөрийг нь түшиглэн ирж улс байгуулах үйл хэрэгт үнэнчээр зүтгэсэн хүмүүсийг зохих албадад томилсон ажээ. Энэхүү ажил үүргийн хуваарилалт нь Их Монгол Улсыг байгуулах үеэс улам хөгжиж, албан үүргээ гүйцэтгэх журам нь ч нарийсав. Жишээлбэл, төрийн захиргааны үндсийг бүрдүүлж байсан хишигтэн нарын ажил үүргийн хуваарийг өдөр, шөнөөр ялган, ажлын байран дээрх эрх хэмжээ, үүрэг хариуцлагыг зарлигаар баталгаажуулсан байна.

Өгөдэй хааны үед төв засгийн газрыг байгуулж төрийн албаны ажил үүргийн хуваарь улам боловсронгуй болов. Улсын албан байгууллагын үүрэг давхардалгүй, цомхон байхыг хуульчилж байсан нь Богд хааны үеийн яамдын эрхлэх үүргийг тусгайлан зааснаас үзэж болно.

Төрийн албанд ажиллуулахдаа хүмүүсийн мэдлэг, чадвар, эр зориг, бяр тэнхээ, овсгоо самбаа, үнэнч байдлыг харгалзан чухал хариуцлагатай албанд томилж байв. Гэрийн сургалтаар боловсруулсан хөвгүүд нь хожмоо Их Монгол Улсын их заргач зэрэг тэргүүн албадыг нэр төртэйгөөр хааж байв. Юань гүрнээс эхлэн түшмэдийг бэлтгэх монгол үсгийн сургуулиудыг олноор байгуулав. Түшмэдийн зэрэг дэвийг 3 жил болгож ахиулах, бууруулахыг хэлэлцдэг нарийн журам хэрэгжиж байв.

Төрийн албан хэрэг хөтлөлтийн уламжлал. Төв азийн монгол аймгуудад дэлгэрээд байсан уйгур үсгийг Их Монгол Улсын төрийн бичиг болгов. Хубилай хааны зарлигаар Пагва ламын зохиосон “монгол үсэг” буюу дөрвөлжин бичгийг төрийн албан хэрэгт хэрэглэх гэж хичээл зүтгэл гаргаж байсан ч түүний унших, бичихэд төвөгтэй байдал нь хязгаарласан байна. Тиймээс уйгур үсэг буюу худам монгол бичгийг монголчууд үе улиран хэрэглэж ирэв. Гадаад улс орон, дотоодын байгууллагууд хоорондын харилцах албан бичиг, нарийн тогтсон төрийн албан хэрэг хөтлөлтийн дагуу явагдаж байв.

Монголчууд эртнээс хаанаа өргөмжлөх ёслолыг бий болгон уламжлуулж байв. Тэдний бий болгосон өөр нэгэн зүйл нь элчин төлөөлөгч, түшмэдэд олгож байсан эрх бүхий гэрэгэ болно. Дипломатын төдийгүй тухайн түшмэдийн зэрэг зиндаа, эрх хэмжээг гэрэгэ нь илтгэж байв. Төрийн албаны хүрээлэнгүүдэд тусгай тамга, захирлага, тэмдэг хэрэглэх нарийн дэг жаяг уламжлагдаж байв. Эзэнт гүрний үеэс хэмжээт эрхэт хаант засаг хүртэлх төрийн албанд ажиллах түшмэдийн өмсөх ёслолын хувцас нь нарийн журамтай байжээ. Дээрх жишээнээс үзэхэд монголчууд төрийн албаны ёслол, хүндэтгэлийн өөрийн гэсэн тусгай дэг жаягтай байж, тэр нь үеэс үед уламжлагдаж иржээ.

Судлагдан буй үеийн төрийн алба, захиргааны хүрээнд холбогдох шагнал урамшуулал, хариуцлага, шийтгэлийн тогтолцоог нарийвчлан авч үзэж холбогдох баримт сэлтийг цуглуулахын зэрэгцээгээр аль болохоор системчлэхийг оролдов. Чингэхдээ энэ үеийн шагнал урамшууллын онцлогийг зургаан зүйлээр, хариуцлага, шийтгэлтэй холбоотой зүйлсийг найман зүйлээр дүгнэн гаргасаныг холбогдох хэсгээс харж болно.

Иргэдээс төрийн дээд, захиргааны алба, төрийн тусгай алба, орон нутгийн албыг хашиж байсан уламжлалыг тус тус тодруулав. Эзэн хаант засгийн үед хамаарах тул Чингисийн удмынханд дээд захиргааны албанд ажиллах давуу эрх төрөхөөс олгогдож байв. Харц иргэд тусгай болон орон нутгийн албадад дайчлагдан оролцож байсан ч цөөн тохиолдолд л өндөр албанд томилогдож байсныг тодруулсан болно.



Тус төслийн судалгааг өмнө хэвлэгдсэн олон тооны бүтээлд хөндсөн боловч тэдгээр нь их төлөв дам, хавсрага байдлаар гарчээ. Нэгэн сэдэвт зохиол, хамтын бүтээлийн багавтар хэсэг, зүйл эсхүл богино хэмжээний өгүүлэл, илтгэл төдийгөөр олны хүртээл болсон байна. Иймд, энэхүү сэдвээр дагнан ажиллаж тусгайлан судалсан дорвитой бүтээл гаргах нь нэн чухал байгааг цохон тэмдэглэе.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

А. Архивын баримт

- МУУТА, ТБА. ХА-2, Д-1, ХН-73. баримт-1.
МУУТА, ТБА. ХА-3, Д-1, Хн-11, хуудас 126-129а.
МУУТА, ТБА. ХА-3, Д-1, ХН-13. хуудас-390-391.
МУУТА, ТБА. ХА-3, Д-1, ХН-16, хуудас 2а-4а.
МУУТА, ТБА. ХА-3, Д-1, ХН-3, хуудас-28а-29.
МУУТА, ТБА. ХА-3, Д-1, ХН-325, баримт- 1.
МУУТА, ТБА. ХА-3, Д-1, ХН-413, баримт- 4.
МУУТА, ТБА. ХА-3, Д-1, ХН-81, хуудас-394а-396а.
МУУТА, ТБА. ХА-3, Д-1ХН-26, хуудас-54а-56а.
МУУТА, ТБА. ХА-3. Д-1, ХН-2, хуудас-23-25.
МУУТА, ТБА. ХА-4, Д-1, ХН-126.
МУУТА, ТБА. ХА-4, Д-1, ХН-38.
МУУТА, ТБА. ХМ-170, Д-1, ХН-124. баримт -3. Эх.

Б. Бүтээл (монгол хэлээр)

Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. (2020). Улаанбаатар.

Арван буянт номын Цагаан түүх. (2006). /Монгол бичгээс хөрвүүлж, бусад эхтэй харгуулан тайлбар хийсэн: Ш.Чоймаа, Р.Төрдалай, Оршил бичиж, эхийг хавсаргасан: Б.Баярсайхан/. Улаанбаатар.

Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд. (1954). Улаанбаатар: Улсын хэвлэл.

Батбаяр, Б. (2011). *Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг (Агуулга, мөн чанар)*. Улаанбаатар.

Баярсайхан, Б., Б.Батбаяр. (2008). *Монголын төр, эрх зүйн түүх (дээж бичиг) IV дэвтэр (I хэсэг)*. Улаанбаатар.

Баясах Ж. (2006). *Их Монгол Улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг (Хоёр дахь хэвлэлт)*. Улаанбаатар.

Биеэр дайлж өрнө умрын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг (дэвтэр: 1-13). (2019). /Эрх. На. Сүхбаатар/. Улаанбаатар.

Бира, Ш. (2001). *Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа III*. Улаанбаатар: Интерпресс.

Болдбаатар, Ж болон бусад. (2019). *Их Монгол Улс*. Улаанбаатар.

Болдбаатар, Ж. (2018). *Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, нийтлэл. II боть*. Улаанбаатар: Хэвлэлийн газар заагаагүй.

- Вебер, М. (2018). *Улс төр мэргэжил болох нь*. Улаанбаатар: Монсудар.
- Гомбованжил. (2006). *Алтан эрих. /Монгол бичгээс хөрвүүлж оршил бичиж, тайлбар хийсэн Д.Бүрнээ/*. Улаанбаатар.
- Дагвадорж, О. (2011). *Төрийн сүлд өршөө. XII-XIV зууны Монгол хаадын зарлигсын товчоон I, II*. Улаанбаатар:Цомирлог хэвлэл ХХК.
- Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс. V-VI боть. (2010). /Орчуулга, хөрвүүлэг, тайлбар сэлтийг хийсэн М.Баярсайхан, Т.Отгонтуул, Э.Мөнх-Учрал, С.Амарбаяр/. Улаанбаатар.
- Дарма гүүш. (2006). *Алтан хүрдэн мянган хигээст. /Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн: Т.Жамъянсүрэн, Л.Халиун/*. Улаанбаатар.
- Долгоржав, Я. (1989). *Танин мэдэхүйн үндсэн зарчим, аргууд*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Долгоржав, Я. (2019). Төрийн захиргааны тухай В.Вильсоны үечлэл, түүгээр Монгол Улсын төрийн захиргааг авч үзэх нь. *Төрийн удирдлага, эрхзүйн онол-практикийн өгүүллүүд*. Улаанбаатар:
- Долгоржав, Я. (2020). *Төрийн захиргааны шинжлэх ухааны үүсэл, хөгжлийн тойм*. Улаанбаатар: "Хүслийн өнгө" ХХК.
- Долгоржав, Я., Батсүх, Ш., Болд, Н., (2020). *Төрийн захиргааны сургалтад КЕЙС ашиглах нь*. Улаанбаатар: "Мөнхийн үсэг" ХХК
- Дэндэв, Л. (2015). *Монголын товч түүх*. Улаанбаатар.
- Зава Дамдин. (2007). *Хор чойнзун зава*. Улаанбаатар.
- Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг* (1995). Улаанбаатар: "Чойжил" пүүс.
- Инжаннаши, В. (2005). *Хөх судар. Тэргүүн дэвтэр*. Улаанбаатар.
- Карпини, П. (1988). *Монголчуудын түүх. /Орчуулсан С.Туяа, С.Цолмон/*. Улаанбаатар.
- Лувсанданзан. (2006). *Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой. /Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа/*. Улаанбаатар.
- Магсаржав, Н. (2015). *Монгол Улсын шинэ түүх. /Эрх. З.Лонжид, О.Батсайхан/*. Улаанбаатар: "Соёмбо принтинг"
- Майский, И. (2001). *Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр)*. Улаанбаатар.
- Марко Поло. (1987). *Орчлонгийн элдэв сонин. /Ред С.Бадамхатан/*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Маркс, К., Энгельс, Ф. (огноо байхгүй). *Түүвэр зохиол. 1-р боть*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Мин улсын судар (Олон шастир). III боть. (2018). /Эртний хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн: Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч. Содбилэг/. Улаанбаатар.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2020). Улаанбаатар.

Монгол Улсын түүх. (2003). I-V боть. Улаанбаатар: Адмон ХХК.

Монгол цаазын бичиг (Эх бичгийн судалгаа). (2004). /Галиглаж, үгийн хэлхээг үйлдэн, эх бичгийн судалгаа хийсэн: Б.Баярсайхан. Улаанбаатар

Монголын нууц товчоо. (1975). /Ц.Дамдинсүрэн/. Улаанбаатар.

Монголын нууц товчоо. (2000) /Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар хийсэн Д.Цэрэнсодном/. Улаанбаатар

Монголын нууц товчоо. (2006). /Монголын нууц товчооны эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа/. Улаанбаатар.

Монголын нууц товчоо. (2019). /Монголын нууц товчооны эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа/. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.

Насанбалжир, Ц. (1964). *Ар Монголоос Манж Чин улсад залгуулж байсан алба 1691-1911 он.* Улаанбаатар.

Нацагдорж, Ш. (1963). *Халхын түүх.* Улаанбаатар.

Нацагдорж, Ш. (1978). *Монголын феодализмын үндсэн замнал.* Улаанбаатар.

Нацагдорж, Ш. (2006). *Чингис хааны зарлигийн товчоон.* Улаанбаатар.

Нацагдорж, Ш. (2018). *Эрдмийн бүтээлийн эмхэтгэл.* VIII боть. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.

Ням-Осор, Н. (2012). *XIII-XIV зууны Их Монгол Улсын төрт ёсны хөгжлийн түүхэн судлал.* Улаанбаатар.

Орон нутагт ардчилсан засаг захиргаа байгуулагдсан нь. (1974). Улаанбаатар.

Өлзийбаатар, Д., Г.Дашням, Ш.Эрдэнэбат. (2011). *Монгол Улсын Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яам* (Баримт бичгийн эмхэтгэл) (1911-1921 он). Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК

Өлзийбаатар, Д., З.Лонжид, Г.Намнансүрэн. (2011). *Монгол Улсын дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яам* (Баримт бичгийн эмхэтгэл) (1911-1919 он). Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.

Потанин, Г.Н. (Онгүй). *Монголын баруун хойд нутаг. II боть.* Улаанбаатар.

Рашид ад дин, (2002). *Судрын чуулган I-II.* /Орос хэлнээс орчуулсан Ц.Сүрэнхорлоо/. Улаанбаатар.

Рашпунцаг. (2006). *Болор эрих (Тэргүүн дэвтэр).* /Харгуулан хөрвүүлсэн М.Баярсайхан, Ч.Нэргүй, Д.Бүдсүрэн/. Улаанбаатар.

Саган Сэцэн. (2006). *Эрдэнийн товч.* /Харгуулан хөрвүүлсэн М.Баярсайхан/.

Улаанбаатар.

Хэрлэн, Б., Ш.Түдэв, Ч.Санжмятав. (2017). *Монголчуудын үнэт зүйлсийг шварцын аргачилалаар тодорхолсон нь*. УБ.

Чимид, Б. Е. р. (2010). *Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Хоёрдугаар боть (1911-1926. V сар)*. Улаанбаатар.

Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршвой. (2006). /Монгол бичгээс харгуулан хөрвүүлж, тайлбар, хавсралт хийсэн Ц.Шагдарсүрэн, Э.Мөнх-учрал/. Улаанбаатар.

Юань улсын судар I-III. (2021). /Эртний хятад хэлнээс орчуулсан Ч.Дэмчигдорж, эрх На.Сүхбаатар /. Улаанбаатар.

В. Бүтээл (англи хэлээр)

Aristotle. (1946). *The Politics, edited and translated by Ernest Barker Book I, chap.ii*. New York: Oxford university press.

Ayalon, D. (1971). The Great Yasa of Chingiz Khan. A Reexamination (Part A). *Studia Islamica*. No. 33. pp. 97-140.

Elverskog, J. (2006). *Our Great Qing. The Mongols, Buddhism and the State in Late Imperial China*. Honolulu: University of Hawai's Press.

Endicott-West, E. (1989). *Mongolian rule in Chine: Local Administration in the Yuan Dynasty*. Cambridge, Mass: Harvard University Press.

Meynhardt, T. (2009). Public value inside: What is Public value creation. *International Journal of Public Administration* 32 (3.4), 192-219.

Morgan, D. O. (1986). The 'Great yasa of Chingiz Khan' and Mongol Law in the Ilkhanate. *Bulletin of the School of Oriental and African Studies*. Vol. 49, No. 1, In Honour of Ann K.S.Lambton. pp. 163-176.

Rachewiltz, I. (2004). *The Secret history of the Mongols: A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century*. Translated with a historical and philological commentary. Vol I, II. Leiden-Boston: Brill

Robinson, D. M. (2004, June). Images of Subject Mongols Under the Ming Dynasty. *Late Imperial China* vol. 25, No. 1. pp. 59-123.

Sablin, I., J.Badagarov and I.Sodnomova. (2021) Khural democracy: Imperial transformations and the making of the first Mongolian constitution, 1911-1924. *Socialist and Post-Socialist Mongolia: Nation, Identity, and Culture*, ed, by Simon Wickham Smith and Phillip P.Marzluf. London: Routledge. pp. 14-42.

Serruys, H. (Dec.m 1977). The Office of Tayisi in Mongolia in the Fifteenth Century. *Harvard Journal of Asiatic Studies*. Vol. 37, No. 2 pp. 353-380.

Tachibana, M. (2014). The 1911 Revolution and "Mongolia": Independence, Constitutional Monarchy, or Republic. *The Journal of Contemporary Chine Studies*. Vol. 3. No. 1. pp. 69-90.

Van der Wal, Z. (2016). Public values research in the 21st Century: Where we are, where we haven't been and where we should go. *International journal of public Administration* 39(1), 1-5.

Weber, M. (1946). *Essays in Sociology. Politics as a Vocation*. New York: Oxford University Press.

Wilson, W. (1887). The Study of Administration. *Political Science Quarterly*, Jun., 197-222.





Удирдлагын академи,
Удирдлагын академийн гудамж -100,
Стадион Оргил -3, Хан-Уул, Улаанбаатар хот 17012

Судалгааны төв
Утас: 70132135
Цахим шуудан: researchcenter@naog.gov.mn
Цахим хаяг: www.naog.gov.mn